

Монгол Улсын  
Үндэсний статистикийн газар



**2000 оны хүн ам, орон  
сууцны тооллого:**

**ҮНДСЭН ҮР ДҮН**

**Эхийг бэлтгэж, эмхтгэсэн: Чагнаадоржийн Баатарчулуун, ҮСГ-ын ХАТСТ-ны  
мэргэжилтэн**

**Орчуулсан: Дашицэрэгийн Ариунаа, ҮСГ-ын ХАТСТ-ны сургалт хариуцсан  
зохицуулагч**

**Монгол эхийг хянасан: Рэндэндэвийн Ойдовданзан, Монгол Улсын гавъяат эдийн  
засагч**

Батсүхийн Батмөнх, ҮСГ-ын дэд дарга

**Англи эхийг хянасан: Лорэнс Лиус, НҮБ-ын СХ, НҮБ-ын ХАС-гийн тооллогын  
зөвлөх**

Линда Демерс, НҮБ-ын ХАС-гийн суурин төлөөлөгч

---

---

**Санал хүсэлт байвал доорхи  
хаягаар холбоо барина уу.**

Үндэсний статистикийн газар  
Улаанбаатар 11, Бага тойруу 44,  
Засгийн газрын III байр,

E-mail:SSO@magicnet.mn  
Факс: 976-1-324518

**Энэхүү илтгэл нь англи  
хэлээр хэвлэгдсэн болно.**

**Үндэсний статистикийн газар  
Улаанбаатар, Монгол Улс**

**2001 оны 7-р сар**

# МОНГОЛ УЛСЫН 2000 ОНЫ ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГО: ҮНДСЭН ҮР ДҮН



Монгол Улсын  
Үндэсний  
статистикийн газар



НҮБ-ын  
Хүн амын  
сан



НҮБ-ын  
Статистикийн  
хэлтэс



## АГУУЛГА

	Хуудас
ТАЙЛАН БИЧИХЭД ОРОЛЦОГСОД	iii
ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	v
ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	xi
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	xii
ТАЛАРХАЛ	xv
ӨМНӨХ ҮГ	xvii
<b>Бүлэг 1. ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2000 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛСАН ТУХАЙ</b>	<b>1</b>
1.1. Монгол Улсын хүн амын тооллогын түүхээс	2
1.2. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалт	2
1.3. Сургалт	6
1.4. Газрын зураг, өрх, хүн амын бүртгэл	8
1.5. Ужуулга, сурталчилгаа	9
1.6. Асуулгын сорилт, туршилтын тооллого, тоолох үе, тооллогын чанарын шалгалт	12
1.7. Мэдээлэл боловсруулалт	14
1.8. Тооллогын үр дүнг хэвлэн нийтлэх, хэрэглэгчдэд тархаах	16
1.9. Тооллогод хэрэглэсэн ойлголт, тодорхойлолт болон тооллогын хуудасны боловсруулалт	18
<b>Бүлэг 2. ХҮН АМЫН ТОО, СУУРЬШИЛТ, НЯГТРАЛ</b>	<b>27</b>
<b>Бүлэг 3. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	<b>37</b>
<b>Бүлэг 4. УЛСЫН ХАРЬЯАЛАЛ, ЯС ҮНДЭС</b>	<b>47</b>
<b>Бүлэг 5. ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, ХОТЖИЛТ</b>	<b>53</b>
<b>Бүлэг 6. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ</b>	<b>71</b>
<b>Бүлэг 7. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИ</b>	<b>81</b>
<b>Бүлэг 8. ӨРХ, ОРОН СУУЦ, ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ ДҮГНЭЛТ</b>	<b>97</b>
<b>Хавсралт ХҮСНЭГТҮҮД</b>	<b>115</b>
1.	
<b>Хавсралт ТООЛЛОГЫН ҮР ДҮНГЭЭР ХЭВЛЭГДЭН ГАРСАН 2. БОЛОН ЦААШИД ХЭВЛЭГДЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ</b>	<b>167</b>
<b>Хавсралт ТООЛЛОГЫН ХУУДАС 3.</b>	<b>169</b>

---

---

## Тайлан бичижэд оролцогсод

**Чүлтэмжамцын Даваасүрэн**

Эдийн засагч-статистикч, Эдийн засгийн ухааны дэд  
доктор (ОХУ)

Олон улсын харилцааны мастер (Колумбын их сургууль,  
АНУ)

УСГ-ын дарга, Тооллогын улсын комиссын орлогч дарга

**Батсухийн Батмөнх**

Эдийн засагч-статистикч, Эдийн засгийн ухааны дэд  
доктор

(Москвагийн эдийн засаг, статистикийн дээд сургууль)

УСГ-ын дэд дарга, Хүн амын тооллого, судалгааны  
товчооны дарга, Тооллогын улсын комиссын нарийн  
бичгийн дарга

**Лорэнс Луис**

Хүн ам зүйч

НҮБ-ын СХ, НҮБ-ын ХАС-гийн тооллогын зөвлөх

**Линда Демерс**

Хүн ам зүйч

НҮБ-ын ХАС-гийн Монгол Улс дахь суурин төлөөлөгч

**ХҮН АМЫН ТООЛЛОГО, СУДАЛГААНЫ ТОВЧОО**

**Лувсанцэрэнгийн Зулцэцэг**

Эдийн засагч-статистикч-хүн ам зүйч, Эдийн засгийн  
ухааны мастер

(Монгол Улсын Их Сургууль)

Товчооны орлогч дарга

**Мэргэжилтнүүд**

**Аръяагийн Гэрэл**

Математикч (Монгол Улсын Их Сургууль)

**Цэнджавын Бадрах**

Эдийн засагч (Монгол Улсын Их Сургууль)

**Чагнаадоржийн Баатарчулуун**

Хөдөлмөрийн эдийн засагч (Хөдөлмөрийн дээд сургууль)

**Лхагвасүрэнгийн Мөнхтуяа**

Эдийн засагч, Эдийн засгийн ухааны мастер

(Ташкентийн их сургууль)

**Поолойн Мөнхцэцэг**

**Эдийн засагч (Техникийн их сургууль)**

**Шаалуугийн Наранцэцэг**

**Эдийн засагч-хүн ам зүйч (Монгол Улсын Их Сургууль)**

**Маширын Оюунцэцэг**

**Хөдөлмөрийн эдийн засагч (Хөдөлмөрийн дээд сургууль)**

**Цэрэндууламын Цэвээнням**

**Эдийн засагч-статистикч, Эдийн засгийн ухааны мастер  
(Монгол Улсын Их Сургууль)**

**Мэдээлэл боловсруулалт, программ  
хангамжийн газар**

**Гомбожавын Оюунбаяр**

**Электроникийн инженер**

**(Харьковын техникийн их сургууль)**

**Газрын дарга**

**Биндэръяагийн Цэрэнханд**

**Программ зохиогч, Тооцоолож техникийн инженер**

**(Прагийн техникийн их сургууль)**

**Ахлах мэргэжилтэн**

**Мэргэжилтнүүд**

**Элдэв-Очирын Эрдэнэсан**

**Эдийн засагч-кибернетикч**

**(Казаны улсын их сургууль)**

**Зундуйгийн Нансалмаа**

**Программ зохиогч (Техникийн их сургууль)**

**Оюунцэцэгийн Тодгэрэл**

**Математикч (Монгол Улсын Их Сургууль)**

**MON/97/P10 төслийн сургалт хариуцсан зохицуулагчид**

**Дашцэрэнгийн Ариунаа**

**Эдийн засагч-статистикч, Хүн ам зүйн мастер**

**(Лондонгийн эдийн засгийн их сургууль)**

**Баатарын Байгалмаа**

**Англи хэлний багш, орчуулагч**

**Мэдээллийн технологийн дипломын сургалт**

**(Оклендын Их Сургууль, Шинэ Зеланд)**

## ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

		<i>Хуудасн ы дугаар</i>
<b>Хүснэгт 1.1</b>	Тооллогын үр дүнгээр хэвлэгдэн гарсан болон цаашид хэвлэгдэх материалын жагсаалт	17
<b>Хүснэгт 1.2</b>	Тооллогод хэрэглэсэн ойлголт, тодорхойлолт, 2000 он	21
<b>Хүснэгт 1.3</b>	1989, 2000 оны тооллогын хуудсанд орсон хүн амын талаархи сэдэв болон асуултын ялгаа	25
<b>Хүснэгт 2.1</b>	Монгол Улсын хүн ам, 1918-2000 оны хүн амын тооллогоор	28
<b>Хүснэгт 2.2</b>	Монгол Улсын хот, хөдөөгийн хүн ам, аймаг, нийслэлээр, 2000 он	32
<b>Хүснэгт 2.3</b>	Хот, хөдөөгийн хүн ам, бүс нутгаар, 2000 он	33
<b>Хүснэгт 2.4</b>	Хүн амын нягтрал, бүс нутгаар, 2000 он	33
<b>Хүснэгт 2.5</b>	Хүн амын тоо болон нягтрал, аймаг, нийслэлээр, 1989 болон 2000 он	35
<b>Хүснэгт 3.1</b>	Аймаг, нийслэлийн хүн амын өсөлт, хувиар, 1979-1989, 1989-2000 он	39
<b>Хүснэгт 3.2</b>	Хүн амын нас, хүйсний бүтэц, хүйсийн харьцаа, мян.хүн, 2000 он	41
<b>Хүснэгт 3.3</b>	Хүн амын насны бүтэц, хувиар, 1979, 1989, 2000 он	43
<b>Хүснэгт 3.4</b>	15, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал, 1979, 1989, 2000 он	43
<b>Хүснэгт 3.5</b>	Гэрлэлтийн байдал, хүйсээр, 2000 он	44
<b>Хүснэгт 3.6</b>	Анхны гэрлэлтийн дундаж нас, 1989 болон 2000 он	44
<b>Хүснэгт 3.7</b>	Гэрлэлтийн байдал, насны бүлэг, хүйсээр, мян.хүн, 2000 он	45
<b>Хүснэгт 4.1</b>	Гадаадын иргэд, харьят улс орноор, 1989 болон 2000 он	49
<b>Хүснэгт 4.2</b>	Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын иргэд, зарим аймаг, нийслэлээр, 2000 он	49
<b>Хүснэгт 4.3</b>	Гадаадын харьят иргэд болон нийт хүн амын эзлэх хувийн жин насны бүлэг, хүйсээр, 2000 он	50

<b>Хүснэгт 4.4</b>	Монгол Улсын иргэд, яс үндсээр, 1989 болон 2000 он	<b>50</b>
<b>Хүснэгт 4.5</b>	Хүн амын эзлэх хувь яс үндэс, насны бүлгээр, 2000 он	<b>52</b>
<b>Хүснэгт 5.1</b>	Шилжигсийн тоо, цаг хугацаа, орон зайгаар, мянхүн, 2000 он	<b>56</b>
<b>Хүснэгт 5.2</b>	Төрснөөс хойшхи шилжигсэд, бүс нутгаар, 2000 он	<b>57</b>
<b>Хүснэгт 5.3</b>	Хүн амын тоо, төрсөн болон тооллогын үед байнга оршин сууж байсан газраар, 2000 он	<b>58</b>
<b>Хүснэгт 5.4</b>	Хүн амын эзлэх хувь, төрсөн болон тооллогын үед байнга оршин сууж байсан газраар, 2000 он	<b>60</b>
<b>Хүснэгт 5.5</b>	Таван жилийн өмнөхтэй харьцуулсан шилжих хөдөлгөөнд оролцогсод, бүс нутгаар, 2000 он	<b>61</b>
<b>Хүснэгт 5.6</b>	Тав, түүнээс дээш насны хүн амын тоо, 1995 оны 1-р сард болон тооллогын үед байнга оршин сууж байсан газраар, 2000 он	<b>61</b>
<b>Хүснэгт 5.7</b>	Хүн амын эзлэх хувь, 1995 оны 1-р сард болон тооллогын үед байнга оршин сууж байсан газраар, 2000 он	<b>62</b>
<b>Хүснэгт 5.8</b>	Шилжих хөдөлгөөний жилийн дундаж коэффициент, 1995 оны 1-р сараас 2000 оны 1-р сар	<b>63</b>
<b>Хүснэгт 5.9</b>	Сүүлийн нэг жилийн шилжих хөдөлгөөн, бүс нутгаар, 2000 он	<b>64</b>
<b>Хүснэгт 5.10</b>	Хүн амын тоо, сүүлийн нэг жилд болон тооллогын үед байнга оршин сууж байсан газраар, 2000 он	<b>65</b>
<b>Хүснэгт 5.11</b>	Хүн амын эзлэх хувь, сүүлийн нэг жилд болон тооллогын үед байнга оршин сууж байсан газраар, 2000 он	<b>65</b>
<b>Хүснэгт 5.12</b>	Сүүлийн нэг жилд шилжигсэд, насны бүлэг, хүйсээр, 2000 он	<b>67</b>
<b>Хүснэгт 6.1</b>	Арав, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь, боловсролын түвшин, хүйсээр, 1989 болон 2000 он	<b>72</b>
<b>Хүснэгт 6.2</b>	Арав, түүнээс дээш насны хүн ам, боловсролын түвшин, хүйс, байршил, дүнд эзлэх хувиар, 2000 он	<b>73</b>
<b>Хүснэгт 6.3</b>	Арав, түүнээс дээш насны хүн ам, боловсролын түвшин, насны бүлэг, дүнд эзлэх хувиар, 2000 он	<b>74</b>

<b>Хүснэгт 6.4</b>	Арван тав, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэг, байршил, хүйсээр, 2000 он	76
<b>Хүснэгт 6.5</b>	7-29 насны хүн амын сургуульд суралцаж байгаа эсэх, нас, хүйсээр, 2000 он	78
<b>Хүснэгт 6.6</b>	Сургуульд суралцаж байгаа 7-29 насны хүн амын эзлэх хувь, насны бүлэг, байршил, хүйсээр, 2000 он	78
<b>Хүснэгт 7.1</b>	Ажиллах хүчний оролцооны түвшин, байршил, хүйсээр, 2000 он	84
<b>Хүснэгт 7.2</b>	Эдийн засгийн идэвхи, насны бүлэг, хүйс, дүнд эзлэх хувиар, 2000 он	84
<b>Хүснэгт 7.3</b>	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, хүйс, байршилаар, 2000 он	87
<b>Хүснэгт 7.4</b>	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, насны бүлэг, хүйсээр, 2000 он	87
<b>Хүснэгт 7.5</b>	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, эрхэлдэг ажил, хүйсээр, 2000 он	88
<b>Хүснэгт 7.6</b>	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хүйсээр, 2000 он	89
<b>Хүснэгт 7.7</b>	Ажил эрхэлдэг хүн амын ажил эрхлэлтийн байдал, хүйсээр, мян.хүн, 2000 он	90
<b>Хүснэгт 7.8</b>	Ажилгүйчүүд, хүйс, байршилаар, 2000 он	92
<b>Хүснэгт 7.9</b>	Ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, байршил, хүйсээр, 2000 он	93
<b>Хүснэгт 7.10</b>	Арван тав, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхигүй хүн ам, ажил эрхлээгүй шалтгаан, хүйсээр, 2000 он	94
<b>Хүснэгт 7.11</b>	Арван тав, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхигүй хүн ам, насны бүлэг, ажил эрхлээгүй шалтгаанаар, мян.хүн, 2000 он	95
<b>Хүснэгт 7.12</b>	Тохирох ажил олдохгүй байгаагийн улмаас ажил эрхлээгүй хүн ам, насны бүлэг, хүйсээр, мян.хүн, 2000 он	95
<b>Хүснэгт 7.13</b>	Ажиллах хүч, өргөжүүлсэн ойлголтоор, мян.хүн, 2000 он	96
<b>Хүснэгт 8.1</b>	Өрхийн тоо, байршилаар, 1989 болон 2000 он	98
<b>Хүснэгт 8.2</b>	Өрхийн тоо, байршил, өрхийн хэлбэрээр, 2000 он	99

<b>Хүснэгт 8.3</b>	Өрхийн тоо, дүнд эзлэх хувь, байршил, ам бүлийн тоогоор, 2000 он	<b>100</b>
<b>Хүснэгт 8.4</b>	Өрхийн эзлэх хувь, ам бүлийн тоогоор, 2000 он	<b>100</b>
<b>Хүснэгт 8.5</b>	Өрхийн тоо, өрхийн тэргүүлэгчийн хүйс, байршил, дүнд эзлэх хувиар, 2000 он	<b>101</b>
<b>Хүснэгт 8.6</b>	Өрх, сууцны төрөл, байршилаар, 2000 он	<b>102</b>
<b>Хүснэгт 8.7</b>	Өрх, сууцны зориулалтаар, 2000 он	<b>102</b>
<b>Хүснэгт 8.8</b>	Өрх, сууцны зориулалт, байршилаар, дүнд эзлэх хувиар, 2000 он	<b>103</b>
<b>Хүснэгт 8.9</b>	Өрх, сууцны төрөл, өмчийн хэлбэрээр, 2000 он	<b>104</b>
<b>Хүснэгт 8.10</b>	Өрх, сууцны өмчлөлийн хэлбэр, байршилаар, 2000 он	<b>104</b>
<b>Хүснэгт 8.11</b>	Өрх, цахилгаан болон телефон утасны хангамж, байршилаар, 2000 он	<b>105</b>
<b>Хүснэгт 8.12</b>	Гэрт суудаг өрх, ам бүлийн тоо, гэрийн ханын тоогоор, 2000 он	<b>105</b>
<b>Хүснэгт 8.13</b>	Гэрт амьдарч байгаа өрхийн эзлэх хувь, ахуйн нөхцлийн үзүүлэлт, байршилаар, 2000 он	<b>106</b>
<b>Хүснэгт 8.14</b>	Байшинд суудаг өрх, ам бүлийн тоо, сууцны талбайгаар, 2000 он	<b>107</b>
<b>Хүснэгт 8.15</b>	Байшинд суудаг өрхийн эзлэх хувь, ам бүл, өрөөний тоогоор, 2000 он	<b>108</b>
<b>Хүснэгт 8.16</b>	Байшинд суудаг өрхийн эзлэх хувь, халаалт, байршилаар, 2000 он	<b>108</b>
<b>Хүснэгт 8.17</b>	Байшинд суудаг өрхийн эзлэх хувь, усан хангамж, байршилаар, 2000 он	<b>109</b>
<b>Хүснэгт 8.18</b>	Байшинд суудаг өрхийн эзлэх хувь, орон сууцны нөхцөл, байршилаар, 2000 он	<b>109</b>
<b>Хүснэгт 8.19</b>	Байшинд суудаг өрхийн эзлэх хувь, гал тогооны өрөөтэй эсэх, байршилаар, 2000 он	<b>109</b>
<b>Зураг 1.1</b>	Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын зохион байгуулалтын бүтэц	<b>5</b>
<b>Зураг 2.1</b>	Хүн амын суурьшилт, 2000 он	<b>30</b>
<b>Зураг 2.2</b>	Нийт хүн амд аймаг, нийслэлийн хүн амын эзлэх хувь, 1989, 2000 он	<b>31</b>

<b>Зураг 2.3</b>	Хүн амын нягтрал, аймаг, нийслэлээр, 2000 он	34
<b>Зураг 3.1</b>	Хүн амын жилийн дундаж өсөлт, хувиар, 1918-2000 он	38
<b>Зураг 3.2</b>	Аймаг, нийслэлийн хүн амын жилийн дундаж өсөлт, хувиар, 1989-2000 он	40
<b>Зураг 3.3</b>	Хүн амын нас, хүйсний суврага, 1989, 2000 оны тооллогоор	42
<b>Зураг 3.4</b>	Салсан хүн ам, насны бүлэг, хүйсээр, 2000 он	45
<b>Зураг 3.5</b>	Бэлбэсэн хүн ам, насны бүлэг, хүйсээр, 2000 он	46
<b>Зураг 4.1</b>	Улсын харъяалал, яс үндэс, 2000 он	48
<b>Зураг 4.2</b>	Казах иргэдийн суурьшилт, 2000 он	51
<b>Зураг 5.1</b>	Төрснөөс хойшхи дотоод шилжих хөдөлгөөн, 2000 он	54
<b>Зураг 5.2</b>	Сүүлийн нэг жилийн дотоод шилжих хөдөлгөөн (байнга оршин сууж байгаа хугацаан дээр үндэслэсэн), 2000 он	55
<b>Зураг 5.3</b>	Сүүлийн таван жилийн дотоод шилжих хөдөлгөөн, 2000 он	56
<b>Зураг 5.4</b>	Сүүлийн нэг жилд шилжигсэд, насны бүлэг, хүйсээр, 2000 он	67
<b>Зураг 5.5</b>	Нийт хүн ам болон шилжигсдийн эзлэх хувь, насны бүлгээр, 2000 он	68
<b>Зураг 5.6</b>	Улаанбаатар хот уруу цэвэр шилжин ирэгсэд, бус нутгаар, мян.хүн, 1995-2000 он	68
<b>Зураг 5.7</b>	Шилжих хөдөлгөөний жилийн дундаж коэффициент, аймаг, нийслэлээр, 1995-2000 он	69
<b>Зураг 6.1</b>	Дээд боловсролтой хүн амын эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр, 2000 он	75
<b>Зураг 6.2</b>	Бичиг үсгийн мэдлэгийн талаархи асуулт, 2000 он	76
<b>Зураг 6.3</b>	Арван тав, түүнээс дээш насны бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь, насны бүлгээр, 2000 он	77
<b>Зураг 6.4</b>	Сургуульд суралцагч 100 эрэгтэйд ногдох эмэгтэйчүүд, насны бүлгээр, 2000 он	79
<b>Зураг 7.1</b>	Эдийн засгийн идэвхийн ойлголт, 2000 он	82

<b>Зураг 7.2</b>	Ажил эрхлэлтийн ойлголт, 2000 он	<b>82</b>
<b>Зураг 7.3</b>	Арван тав, түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин, хувиар, 2000 он	<b>83</b>
<b>Зураг 7.4</b>	Ажиллах хүчний асуулт, 2000 он	<b>85</b>
<b>Зураг 7.5</b>	Эдийн засгийн идэвхийн байдал, 2000 он	<b>85</b>
<b>Зураг 7.6</b>	Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр, 2000 он	<b>86</b>
<b>Зураг 7.7</b>	Ажиллагсдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн бүлгээр, хот, хөдөөгөөр, мян.хүн, 2000 он	<b>90</b>
<b>Зураг 7.8</b>	Ажилгүйчүүдийн талаархи асуулт, 2000 он	<b>92</b>
<b>Зураг 7.9</b>	Ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр, хувиар, 2000 он	<b>93</b>
<b>Зураг 8.1.</b>	Өрх, нийтийн байранд тоологдсон хүн ам, 2000 он	<b>98</b>
<b>Зураг 8.2.</b>	Өрхийн хэлбэр, 2000 он	<b>99</b>
<b>Зураг 8.3.</b>	Өрхийн орон сууцны төрөл, 2000 он	<b>101</b>
<b>Зураг 8.4.</b>	Гэрт амьдардаг өрх, усан хангамжаар, 2000 он	<b>106</b>
<b>Зураг 8.5.</b>	Байшинд суудаг өрх, хог зайлцуулалтын төрлөөр, 2000 он	<b>110</b>

## ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

**Хуудасны  
дугаар**

<b>Хүснэгт 1.</b>	Монгол Улсад байнга оршин суудаг хүн амын тоо, насны бүлэг, хүйс, байршилаар, 2000 он	<b>116</b>
<b>Хүснэгт 2.</b>	Байнга оршин суудаг хүн ам, аймаг, нийслэл, насны бүлэг, хүйс, байршилаар, 2000 он	<b>117</b>
<b>Хүснэгт 3.</b>	Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал, насны бүлэг, хүйсээр, 2000 он	<b>128</b>
<b>Хүснэгт 3A.</b>	Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал, насны бүлэг, байршилаар, 2000 он	<b>129</b>
<b>Хүснэгт 4.</b>	Байнга оршин суудаг хүн амын тоо, харьяалал, яс үндэс, хүйс, байршилаар, 2000 он	<b>130</b>
<b>Хүснэгт 5.</b>	Хүн амын төрснөөс хойши хилжих хөдөлгөөн, аймаг, нийслэлээр, 2000 он	<b>133</b>
<b>Хүснэгт 6.</b>	Хүн амын тоо, төрсөн болон тооллогын үед байнга оршин суугаа аймаг, нийслэлээр, 2000 он	<b>134</b>
<b>Хүснэгт 7.</b>	Тав, түүнээс дээш насны хүн амын сүүлийн 5 жилийн шилжих хөдөлгөөн, аймаг, нийслэл, хүйсээр, 2000 он	<b>136</b>
<b>Хүснэгт 8.</b>	Хүн амын сүүлийн нэг жилийн шилжих хөдөлгөөн, аймаг, нийслэл, хүйсээр, 2000 он	<b>137</b>
<b>Хүснэгт 9.</b>	Долоо, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, аймаг, нийслэлээр, 2000 он	<b>138</b>
<b>Хүснэгт 10.</b>	Долоо, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, насны бүлэг, хүйсээр, 2000 он	<b>139</b>
<b>Хүснэгт 10A.</b>	Долоо, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, насны бүлэг, байршилаар, 2000 он	<b>140</b>
<b>Хүснэгт 11.</b>	Арав, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэг, насны бүлэг, хүйс, байршилаар, 2000 он	<b>141</b>
<b>Хүснэгт 12.</b>	Арав, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэг, аймаг, нийслэл, хүйсээр, 2000 он	<b>142</b>
<b>Хүснэгт 13.</b>	7-29 насны хүн амын сургуульд хамрагдалт, насны бүлэг, байршил, хүйсээр, 2000 он	<b>143</b>
<b>Хүснэгт 14.</b>	7-15 насны хүн амын сургуульд хамрагдалт, аймаг, нийслэл, хүйсээр, 2000 он	<b>144</b>
<b>Хүснэгт 15.</b>	Арван тав, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхи, насны бүлэг, хүйсээр, 2000 он	<b>145</b>

<b>Хүснэгт 15А.</b> Арван тав, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхи, насны бүлэг, байршилаар, 2000 он	<b>146</b>
<b>Хүснэгт 16.</b> Арван тав, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхи, аймаг, нийслэлээр, 2000 он	<b>147</b>
<b>Хүснэгт 16А.</b> Арван тав, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхи, аймаг, нийслэл, хүйсээр, 2000 он	<b>148</b>
<b>Хүснэгт 17.</b> Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо, эрхэлдэг ажил, хүйс, байршилаар, 2000 он	<b>149</b>
<b>Хүснэгт 18.</b> Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хүйс, байршилаар, 2000 он	<b>150</b>
<b>Хүснэгт 19.</b> Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо, ажил эрхлэлтийн байдал, насны бүлэг, хүйсээр, 2000 он	<b>151</b>
<b>Хүснэгт 19А.</b> Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо, ажил эрхлэлтийн байдал, насны бүлэг, байршилаар, 2000 он	<b>152</b>
<b>Хүснэгт 20.</b> Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын боловсролын түвшин, аймаг, нийслэлээр, 2000 он	<b>153</b>
<b>Хүснэгт 21.</b> Ажилгүйчүүдийн боловсролын түвшин, аймаг, нийслэлээр, 2000 он	<b>154</b>
<b>Хүснэгт 21А.</b> Ажилгүйчүүдийн боловсролын түвшин, аймаг, нийслэл, хүйсээр, 2000 он	<b>155</b>
<b>Хүснэгт 22.</b> Өрхийн тоо, ам бүл, байршил, өрхийн хэлбэрээр, 2000 он	<b>156</b>
<b>Хүснэгт 23.</b> Өрхийн тоо, аймаг, нийслэл, ам бүлээр, 2000 он	<b>157</b>
<b>Хүснэгт 24.</b> Өрхийн тоо, аймаг, нийслэл, сууцны төрлөөр, 2000 он	<b>158</b>
<b>Хүснэгт 25.</b> Долоо, түүнээс дээш насны орон гэргүй хүн амын тоо, аймаг, нийслэл, насны бүлгээр, 2000 он	<b>159</b>
<b>Хүснэгт 26.</b> Гэрт суудаг өрхийн тоо, ахуйн нэхцэл, байршилаар, 2000 он	<b>160</b>
<b>Хүснэгт 27.</b> Байшинд суудаг өрхийн тоо, ам бүл, байршил, өрөөний тоогоор, 2000 он	<b>161</b>
<b>Хүснэгт 28.</b> Байшинд суудаг өрхийн тоо, аймаг, нийслэл, өрөөний тоогоор, 2000 он	<b>162</b>
<b>Хүснэгт 29.</b> Байшинд суудаг өрхийн тоо, ахуйн нэхцэл, сууцны төрөл, байршилаар, 2000 он	<b>163</b>

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

<b>УСГ</b>	Үндэсний статистикийн газар
<b>НҮБ</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллага
<b>НҮБ-ЫН ХАС</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан
<b>НҮБ-ЫН СХ</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллагын
<b>ХАТСТ</b>	Статистикийн хэлтэс
<b>МБПХГ</b>	Хүн амын тооллого, судалгааны товчоо Мэдээлэл боловсруулалт, программ
<b>ХАНУЭМС</b>	хангамжийн газар
<b>ТЕК</b>	Хүн амын нөхөн үржихуйн эрүүл мэндийн судалгаа
<b>GPS</b>	Төрөлтийн ерөнхий коэффициент
<b>IMPS</b>	Global Positioning System (Байрлал тодорхойлох нэгдсэн систем)
<b>ГБ</b>	Integrated Microcomputer Processing System (Мэдээлэл боловсруулах нэгдсэн систем)
	Гарах боломжгүй

## **Талархал**

Монгол Улсын хүн ам, орон сууцны 2000 оны ээлжит улсын тооллого нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилтийн үед хийгдсэн анхны тооллого болсоны хувьд Нэгдсэн Үндэстний Байгууллага (НУБ)-аас зөвлөмж болгосон зарчим, аргачлалыг мөрдлөг болгон тооллогын ойлголт, тодорхойлолт, зарчмыг өмнөхөөс ихээхэн өөрчлөн ашигласан болно. Үүнээс гадна, энэ удаагийн тооллого нь 1-р сард буюу байгаль, цаг уурын таагүй, зарим нутгаар цас их орж, хүйтний эрч чангартсан нөхцөл байдалд явагдсан тул тооллогын ажилчид үлэмж хүндрэл бэрхшээлтэй тулгарч байв. Хэдийгээр тооллогыг явуулахад бэрхшээл, хүндрэл гарч байсан ч тооллого товлосон хугацаандаа амжилттай явагдлаа. Тооллогыг амжилттай явуулахад төр засгийн байгуулагууд болон НУБ-ын агентлагууд ялангуяа НУБ-ын Хүн амын сан (ХАС), НУБ-ын Статистикийн хэлтэс болон Австралийн Засгийн газрын Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэг туслалцаа ихээхэн нөлөөлсөн. Төв, орон нутгийн статистикийн ба аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны тооллогын ажилтнуудын хүчин чармайлтын үр дүнд тооллого товлосон хугацаандаа чанартай сайн явагдаж, одоо түүний эцсийн дунг Та бүхэнд танилцуулж байгаадаа бид их баяртай байна.

Энэ удаагийн тооллого нь хамтын хүч чартайлтын үр дун юм. Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нараас эхлэн манай улсын бүх иргэд энэ удаагийн тооллогод идэвх, санаачлага гарган оролцсныг зориуд тэмдэглэж байна.

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогыг амжилттай явуулахад бидэнд дэмжлэг, туслалцаа үзүүлсэн олон улсын байгууллага, тооллогыг удирдан зохион байгуулах улсын комисс, түүний гишүүд, төр, засгийн байгууллага, ялангуяа Сангийн яам, Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яам, Хууль зүйн яам, Дэд бүтцийн хөгжлийн яам, Цагдаагийн өрөнхий газар, Шүүхийн шийдвэр биелүүлэх өрөнхий газар, Монголын радиогийн "Хурд", Монгол телевизийн "ММ" агентлагууд, Монголын иргэний агаарын тээврийг удирдах газар, Нефть импорт концерн, Улаанбаатар төмөр замын хэрэг эрхлэх газар, Автотээврийн газар, олон нийтийн байгууллага бүх шатны Засаг дарга нар, Засаг даргын тамгийн газрын ажилтнууд, болон нийт ард иргэд эцэст нь энэхүү тооллогыг амжилттай явуулж дуусгасан бүх шатны тооллогын комисс, тур товчооны ажилтнуудад Үндэсний Статистикийн газар гүн талархлаа илэрхийлье.

Энэ удаагийн тооллогын асуулгыг олон улсын жишгээр боловсруулахад үнэтэй санал, зөвлөмж өгсөн НУБ-ын Статистикийн хэлтсийн ажилтан, ноён Икбал Алам, Сэм

Сухарто, төслийн суурин зөвлөх ноён Алберт Макбардт, зөвлөх ноён Лоренс Луис, тооллогын материалыг боловсруулах компьютерийн программаар сургалт явуулж, туршилт хийхэд үнэтэй зөвлөлгөө, сэтгэл харамгуй туслалцаа үзүүлсэн ноён Карлос Иллис, Нюри Озеров нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогыг олон улсын стандарт, арга зүйгээр амжилттай явуулж, дунг гаргахад бидэнд зайлшгүй шаардлагатай байсан зөвлөхүүдийг урьж ажиллуулах, техник тоног төхөөрөмж худалдан авах, үндэсний мэргэжилтнүүдийг сургахад санхүүгийн бүхий л талын дэмжлэг үзүүлж байсан НҮБ-ын Хүн амын сан, түүний Монгол дахь суурин төлөөлөгч, хатагтай Линда Демерс, суурин төлөөлөгчийн газрын ажилтан Каори Адачи нарт талархлаа дэвшүүлж байна.

Ч. ДАВААСҮРЭН

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗРЫН ДАРГА, ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ  
ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА

## **Өмнөх үг**

Улс орны өнөөгийн байдлын талаар шинэчлэгдсэн, үнэн зөв тоо, мэдээлэлгүйгээр Засгийн газраас тодорхой шийдвэр гаргах ямарч боломжгүй юм. Хүн амын талаархи мэдээлэл, ялангуяа хүн амын тоо, тархан суурьшилт, нийгэм, эдийн засгийн байдал болон орон сууцны нөхцөл зэрэг нь өнөөгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дүгнэх, түүнийг цаашид хөгжүүлэх бодлого боловсруулажад нэн чухал юм. Дэлхийн ихэнх улс оронд ийм мэдээллийг бүрдүүлдэг гол эх үүсвэр нь 10 жил тутамд явагддаг хүн ам, орон сууцны тооллого билээ.

Монгол Улсад 2000 оны эхээр явагдсан хүн ам, орон сууцны эзлжит тооллого нь ХХI зууны эхэн дэх Монгол Улсын хүн амын талаархи маш дэлгэрэнгүй мэдээллийг бүрдүүлсэн. Хүн амын тооллого нь 10 жил тутамд явагддаг учраас эдгээр мэдээлэл нь 2010 он хүртэл эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөлтөнд ашиглах тулгуур материал болох юм. Энэ тооллогын үр дүн нь өмнөх жилүүдэд Монгол Улсын төр, засгаас явуулсан хүн амын талаархи бодлого, уйл ажиллагааны үр дүнг дүгнэх бололцоо олгож, улмаар уг бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах үндэслэл болж чадна. Үүнд хүн ам, хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настан, эрүүл мэнд, боловсрол, хотжилт, ажиллах хүч, орон сууц болон ядуурлыг бууруулах зэрэг эдийн засаг, нийгмийн чухал асуудлууд хамрагдана.

Энэхүү тооллогын дүнг төр, засгийн байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээ, бизнесийн байгууллагууд болон өргөн олон хэрэглэгчдэд хүргэх явдал Үндэсний статистикийн газар (ҮСГ)-ын гол зорилт бөгөөд тооллогын дунгээр гаргаж байгаа анхны томоохон материал нь энэхүү тайлан болж байна.

Энэ тайлан нь 3 үндсэн хэсгээс бүрдэнэ. Эхний хэсэг нь 2000 оны хүн ам, орон сууцны тооллогыг зохион байгуулж явуулсан тухай тодорхой мэдээллийг агуулсан бөгөөд энэ хэсэгт тооллогын төлөвлөлт, тоолох ажиллагаа болон тооллогын мэдээлэл боловсруулалтын талаар товч дүгнэлтийг багтаасан. Тооллогын зохион байгуулалттай холбоотой эхний хэсгээр тусгайлсан дэлгэрэнгүй тайлан монгол, англи хэл дээр хэвлэгдэн гарсан тул энэ асуудлыг сонирхсон хэрэглэгчид түүнийг ашиглаж болно.

Тооллогын үр дүнгийн талаархи 2-р хэсэг хүн амын тоо, түүний тархан суурьшилт, хүн ам зүйн үзүүлэлт, ястан үндэстэн, боловсрол, бичиг үсгийн мэдлэг, шилжих хөдөлгөөн, хотжилт, ажил эрхлэлт, өрхийн үзүүлэлт гэсэн 7 бүлгээс бүрдэнэ. Тооллогын үр дүнгийн гол хүснэгтуүдийг уг тайлангийн 3-р хэсэгт эмхтгэв.

Тооллогын үр дүнгээр гарсан их хэмжээний мэдээлэл болон үр дүнгийн хүснэгтүүдийг ганцхан тайландаа бүгдийг хамруулан дүгнэн бичих боломжгүй юм. Мөн олон тооны хүснэгтүүдийг улс, аймаг, нийслэл, сум, дүүргээр боловсруулан гаргасан. Эдгээр хүснэгтийн ихэнх нь хот, хөдөө болон хүйсээр ангилагдсан. Энэ бүх хүснэгтийг тайландаа бүрэн хавсаргах боломжгүй юм. Иймд энэ тайлангийн зэрэгцээ тооллогын үр дүнгийн гол хүснэгтүүдийг багтаасан тусгайлсан ботиудыг аймаг, хот бүрээр болон улсын дүнгээр албан ажлын хэрэгцээнд зориуулан бэлтгэснээс гадна тэдгээрийг ундэслэн бүх аймаг болон нийслэл Улаанбаатар хотын дүнгээр хүн амын тооллогын тусгайлсан эмхтгэл, орон сууцны нөхцөлийн талаар бие даасан эмхтгэлийг хэвлэж нийтийн хүртээл болгож байна. Цаашдаа энэ тооллогын үр дүнгээр "Монгол Улс ХХ зуунд" гэсэн хүн амын эмхтгэл, тооллогын асуулганд орсон сэдвүүдээр тусгай бие даасан товхимолууд хэвлүүлэхээр төлөвлөж байна. Үүнээс гадна УСГ-ын WEB хуудаснаас тооллогын тухай мэдээллийг авч болно.

Тайланг Австрали Улсын Засгийн газар болон НУБ-ын Хүн амын сангаас үзүүлсэн санхүүгийн болон мэргэжилтний дэмжлэгтэйгээр бэлтгэн, монгол, англи хэл дээр хэвлүүлэв.

Энэхүү тайланг бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан төслийн тооллогын зөвлөх ноён Лоренс Луис, УСГ-ын дэд дарга, Хүн амын тооллого, судалгааны товчоо (ХАТСТ) -ны дарга Б. Батмөнх, уг товчооны орлогч дарга, Л. Зулцэцэг, мэргэжилтэн Д. Ариунаа, Ч. Баатарчулзуун, Ц. Бадрах, Б. Байгальмаа, А. Гэрэл, П. Мөнхцэцэг, Л. Мөнхтуяа, Ш. Наранцэцэг, Ц. Цэвээнням болон тус газрын Мэдээлэл боловсруулалт, программ хангамжийн газар (МБПХГ) -ын ажилтнуудад талархсанаа илэрхийлье.

Ч. ДАВААСҮРЭН

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗРЫН ДАРГА, ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ  
ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА

## Бүлэг 1. ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2000 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛСАН ТУХАЙ

### 1.1. Монгол улсын хүн амын тооллогын түүхээс

Хүн амын орчин үеийн тооллогын түүх харьцангуй боловч хүний нийгэм үүссэн цагаас хойш хүн амаа бүртгэн тоолж байсан байна. Үнэхээр, цэрэг дайчилгаа болон албан татвар хураах зорилгоор хүн амаа тоолдог байсан тухай олон орны түүхийн эх сурвалжид тэмдэглэн үлдээсэн байдаг.

Хүн амын тооллого нь 200 гаруй жилийн тэртээгээс тодорхой давтамжтайгаар, нэгдсэн хөтөлбөрөөр явагдаж, үр дүн нь албан ёсоор тэмдэглэгдэж иржээ. Гэхдээ, Монгол Улсад хүн амын тооллого XX зууныг хүртэл тогтмол явагдаж байгаагүй бөгөөд XX зууны анхны тооллого 1918 онд явагдсан байна. Дараа нь 1935, 1944, 1956, 1963, 1969, 1979, 1989, 2000 онуудад ээлжит тооллогуудыг явуулсан юм.

Хүн амын 1956 оны тооллогыг статистикийн байгууллага явуулсан бөгөөд тэр үедээ аргачлал, хөтөлбөрийн хувьд нэлээд боловсронгуй болсон гэж тооцогддог. 1963 оны тооллогод шинэ ахиц дэвшил гарсан. Тухайлбал тооллогын материал боловсруулалтыг улам сайжруулах зорилгоор анх удаа цахим тооцоолуур машиныг ашигласан байна. Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн аргачлалын дагуу 1969, 1979, 1989 оны тооллогыг явуулсан. Түүнчлэн НҮБ-ын зөвлөмжийн дагуу эдгээр тооллогыг 10 жилд нэг удаа явуулснаас гадна орон сууцны фондыг хамтад нь тоолсон байна.

Монгол Улсын хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого нь өмнөх тооллогуудаас ихээхэн онцлогтой болж өнгөрсөн. Энэхүү тооллого нь Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцаанаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байгаа үед хийгдсэн анхны тооллого болсны хувьд нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг шинэчлэн өөрчлөх шаардлагыг тусгасан. 2000 оны тооллого нь НҮБ-ын удирдамж, зөвлөмжүүдийг голчлон удирдлага болгосон тул олон улсын стандартад нийцсэн, Монгол Улсад явагдсан анхны орчин үеийн тооллого болсон гэж үзэж болно.

### 1.2. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт

#### Тооллогын төлөвлөлт

Хүн ам, орон сууцны тооллого нь Үндэсний статистикийн газрын зохион байгуулж явуулдаг статистикийн хамгийн том хэмжээний үйл ажиллагаа мөн. Тооллогын өөрийн үйл ажиллагааны цар хүрээ, ур чадвартай мэргэжилтнүүдийн хүрэлцээ, тооллогын бэлтгэл ажлыг сайн зохион байгуулах, тооллогын төлөвлөгөөг боловсруулах, удирдлагын багийг бүрдүүлж, сайн зохион байгуулалт бий болгох зэрэг шаардлагыг бүрэн гүйцэд хангах шаардлагаар хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого 11 жилийн дараа болж өнгөрлөө.

Тооллогыг амжилттай явуулах нэг чухал урьдчилсан нөхцөл бол хүн амын тооллогыг оновчтой төлөвлөх асуудал байдаг. Тооллогын төлөвлөлтөд ажлын

нарийн хуваарь, сайн бодож боловсруулж, үндэслэлтэй тооцсон хугацаа, зардал болон гарах үр дүн, бэлтгэл ажил, зохион байгуулалт, сургалт, тоолох ажиллагаа, мэдээлэл боловсруулалт, дүн шинжилгээ, тооллогын үнэлгээ болон тооллогын үр дүнг хэрэглэгчдэд хүргэх зэрэг бүхий л үе шатны ажил хамрагдах учраас энэхүү төлөвлөгөө нь тооллогын үйл ажиллагаанд их чухал үүргийг гүйцэтгэв.

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын анхны төлөвлөгөөг 1997 онд боловсруулж, Үндэсний статистикийн газрын дарга 1998 оны эхээр баталсан. Энэ төлөвлөгөөг үндэслэн 1998 оны сүүлчээр ажлын нарийвчилсан график төлөвлөгөөг боловсруулан тооллогын бүх шатны комисс, түр товчоодод хүргүүлэв.

### **Тооллогыг явуулах хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлсэн нь**

Хүн амын тооллого явуулах хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлэх нь тооллогыг явуулах үндсэн бөгөөд шийдвэрлэх нөхцөл болж өгдөг. Хүн амын тооллого явуулах тухай холбогдох хууль тогтоомжгүйгээр тооллого явуулах ямар ч боломжгүй юм.

Монгол Улсын хувьд одоогоор хүн амын тооллогын тухай бие даасан хууль байхгүй боловч Статистикийн тухай Монгол Улсын хуульд Үндэсний статистикийн газар нь улсын хэмжээний хүн ам, орон сууцны тооллогыг 10 жил тутам удирдан явуулна гэсэн заалт байдаг. Энэ хуульд тооллого явуулах хугацааны товыг Засгийн газар тогтооно, зааснаас өөр хугацаанд тооллого явуулах зайлшгүй шаардлага гарвал Засгийн газар, Улсын Их Хуралтай энэ талаар зөвшилцэн хугацааг нь тухай бүр тогтооно гэж заасан. Дор дурдсан хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэр нь хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого явуулах хууль, эрх зүйн үндэс болсон юм. Үүнд:

- Статистикийн тухай Монгол Улсын хуулийн (1994 онд батлагдаж, 1997 онд нэмэлт өөрчлөлт орсон) 7 дугаар зүйлийн 1, 3 дугаар заалт, 22, 23 дугаар зүйлийн 1, 2 дугаар заалт,
- Захиргааны хариуцлагын тухай Монгол Улсын хуулийн (1992 оны 11-р сарын 27) 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,
- Хүн ам, орон сууцны улсын тооллого явуулах хугацааг зөвшөөрөх тухай Монгол Улсын Их Хурлын 1998 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 06 дугаар тогтоол,
- Хүн ам, орон сууцны улсын тооллого явуулах тухай Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 28 дугаар тогтоол,
- Комисс байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 39 дүгээр тогтоол,
- Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын хуудсыг батлах тухай ҮСГ-ын даргын 1999 оны 7 дугаар сарын 21-ны өдрийн 125 тоот тушаал,

- Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого явуулах журам, тооллогын хуудасны асуултыг нөхөн зааврыг батлах тухай ҮСГ-ын даргын 1999 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 171 тоот тушаал.

## **Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын удирдлага, зохион байгуулалт**

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын бэлтгэл ажил ҮСГ дээр 1996 оны эхээр эхэлсэн. ҮСГ нь ээлжит тооллогыг явуулахад шаардагдах санхүү болон техникийн дэмжлэг туслалцаа авах талаар олон улсын нэлээд хэдэн байгууллагуудад хандах ажлыг санаачилсан. Удалгүй олон улсын хандивлагч байгууллагуудад хандсан төслийн баримт бичгийг боловсруулсан. 1998 оны эхээр Статистикийн тухай Монгол Улсын хуульд заасны дагуу тооллого явуулах талаар Улсын Их Хурлаас шийдвэр гарсан.

ҮСГ-ын даргын тушаалаар 1998 оны 3 сард Хүн ам, нийгмийн статистикийн хэлтсийг татан буулгаж Хүн амын тооллого судалгааны газар (ХАТСГ), Нийгмийн статистикийн хэлтсийг байгуулав. ХАТСГ нийтдээ 8 хүнтэйгээр байгуулагдаж, 2000 оны улсын тооллогын бэлтгэл ажлыг удирдан зохион байгуулах үүрэгтэйгээр ажлаа эхэлсэн.

ХАТСГ-ыг 1999 оны 2 сард Хүн амын тооллого судалгааны товчоо (ХАТСТ) нэртэйгээр нийт 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр дахин өөрчлөн зохион байгуулж ажиллууллаа. ХАТСТ тооллогын бэлтгэл ажлыг хангах, тооллогын хуудас, түүнийг нөхөн зааврыг боловсруулах, тооллогын бүх шатны комисс болон түр товчоодын ажлын удирдамжийг бэлтгэхээс эхлээд тооллогыг үндсэн газар дээр зохион байгуулж явуулах зэрэг бүх шатны ажлыг гүйцэтгэв.

НҮБ-ын ХАС-гаас 1997 оноос ҮСГ-т хэрэгжүүлж байгаа “ҮСГ-ын мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, тархаах чадавхийг сайжруулах” MON/97/P10, “Монгол улсын хүн амын болон нөхөн үргижүйн мэдээллийн баазыг сайжруулах” MON/97/P04 төслийн хүрээнд санхүүгийн болон мэргэжилтний туслалцааг үзүүлэв. Мөн эдгээр төслийн шугамаар ҮСГ-т ирж ажилласан гадаадын зөвлөхүүд энэ удаагийн тооллогыг олон улсын нийтлэг зарчим, аргачлалын дагуу зохион байгуулж явуулахад үнэтэй санал зөвлөгөө өгсөн юм. Энэ үед Улаанбаатар хотод НҮБ-ын ХАС-ын суурин төлөөлөгчийн газар байгуулагдаж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь ҮСГ-аас хүн ам, орон сууцны тооллогыг зохион байгуулж явуулахад чухал дэмжлэг үзүүлэв.

Хүн ам, орон сууцны тооллогыг амжилттай явуулах нэг чухал үндэс нь төр засгийн зүгээс тодорхой дэмжлэг туслалцааг авах явдал юм. Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогыг удирдан зохион байгуулах улсын комиссыг баттуулав. Уг комиссын даргаар Монгол Улсын Ерөнхий Сайд Р. Амаржаргал, орлогч даргаар ҮСГ-ын дарга Ч. Даваасүрэн, нарийн бичгийн даргаар ҮСГ-ын дэд дарга, ХАТСТ-ны дарга Б. Батмөнхийг тус тус томилсон. Тооллогын улсын комиссын гишүүдэд Батлан хамгаалахын сайд, Гадаад харилцааны сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайд, Сангийн сайд, Хууль зүйн сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд нар томилогдсон.

Тооллогын улсын комиссыг байгуулахын зэрэгцээ тооллогын бүтэц зохион байгуулалтыг орон даяар бий болгох шаардлага гарсан юм. Тооллогын бүтэц

зохион байгуулалтыг 2 хэсэгтэйгээр, тухайлбал тооллогын улсын комиссын шууд удирдлагын дор бүх шатны тооллогын комиссыг, Үндэсний статистикийн газрын удирдлагын дор өдөр тутмын ажлыг эрхлэх тооллогын түр товчоог шат шатанд нь байгуулсан болно (**Зураг 1.1**).

Тооллогын бүх шатны комисс нь тухайн шатны Засаг дарга нааар толгойлуулан байгуулагдаж, хариуцсан засаг захиргааны нэгжийн хэмжээнд тооллогын нийт ажлыг удирдан зохион байгуулж, шаардагдах хөрөнгө, хүн хүч, унаа, шатахуунаар хангах, тооллогыг чанарын өндөр түвшинд бүрэн хамралттай явуулах үндсэн үүрэгтэйгээр ажиллав.

Бүх шатны тооллогын комиссын дэргэд өдөр тутмын ажлыг эрхлэх тооллогын түр товчоодыг байгуулж ажиллуулсан юм. Тооллогын түр товчоог статистикийн хэлтсийн даргаар ахлуулж, гол төлөв статистикийн хэлтсийн болон тамгын газрын гүйцэтгэх ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ. Тооллогын түр товчоод нь тооллогын комиссын удирдлагын дор тооллогын бэлтгэл ажлыг хангах, сургалт зохион байгуулах, тооллогын явцын мэдээг гаргах, хяналтын тооллого явуулах, тооллогын материал, урьдчилсан дүнг шалгаж хүлээн авах, түүнийг засаг захиргааны хэмжээнд нэгтгэн дүгнэж, ҮСГ-т хүлээлгэн өгөх зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэв.

### Зураг 1.1. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын зохион байгуулалтын бүтэц



### 1. 3. Сургалт

Хүн амын тооллого нь олон байгууллага, янз бүрийн боловсрол, мэргэжлийн олон хүмүүсийг оролцуулсан статистикийн томоохон үйл ажиллагаа учраас тооллогын бүх шатны ажилд оролцох хүмүүсийг нэг ойлголттой болгох үүднээс сургалтад их анхаарал тавьж байлаа.

#### ҮСГ-ЫН АЖИЛЛАГСДЫН СУРГАЛТ

ҮСГ-ЫН өмнө тулгамдсан олон зорилтын нэг нь тооллогын төслийг гаргах, тооллогын төлөвлөгөөг бэлтгэх, тооллогын бэлтгэл ажлыг хангах чадвар бүхий өндөр мэргэшсэн ажилтнуудыг бэлтгэх явдал байв. ҮСГ-ЫН ажилтнууд тооллогын бэлтгэл ажлын үед олон улсын сургалтад оролцож байсан нь их ач холбогдолтой болсон. Эдгээр сургалтын ихэнхийг НҮБ-ЫН ХАС, НҮБ-ЫН СХ, Европын холбооны “ТАСИС” хөтөлбөр болон Австрали Улсын Засгийн Газар санхүүжүүлсэн болно.

ҮСГ дээр зохиогдож байсан бүх төрлийн сургалтууд хамгийн чухал байв. 1999 оны туршид гадаадын зөвлөхүүд, ялангуяа НҮБ-ЫН зөвлөхүүд ирж шинээр байгуулагдсан ХАТСТ-д сургалт, мөн НҮБ-ЫН СХ-ийн ажилтан ноён Карло Еллис, НҮБ-ЫН ХАС-гийн Бангконг дахь Улс орныг дэмжих багийн ажилтан ноён Нури Озевер нар ирж мэдээлэл боловсруулалтаар сургалтыг тус тус явуулсан юм. НҮБ-ЫН ХАС-гийн шугамаар ҮСГ-т ажиллаж байсан НҮБ-ЫН зөвлөх ноён М.А.Марквардт, мэдээлэл боловсруулалтын сайн дурын ажилтан ноён Мариан Залцман байнгын туслалцаа үзүүлж байв. ХАТСТ-ны ажилтнуудыг тооллогын ажлыг явуулах чадварыг дээшлүүлэх зорилгоор НҮБ-ЫН СХ-ийн ажилтан ноён Виллям Селтзер, ноён Сэм Сухарто, ноён Икбал Алам нар ҮСГ-т ирж ажилласан. Австрали Улсын Статистикийн газрын ажилтан ноён Жон Пайс, ноён Пол Виллям нар ҮСГ-т ирж ажиллаж, тооллогын үнэлгээ, тархаалтаар сургалт явуулсан.

ХАТСТ-ны ажиллагсдыг мастер багшаар бэлтгэх зэрэг зорилгоор ҮСГ-т сургалт, семинарыг тогтмол явуулж байв. 1999 оны 9-р сарын сүүлчээр НҮБ-ЫН СХ, НҮБ-ЫН ХАС-гийн тооллогын зөвлөх Лоренс Луис сургалтын арга зүй, тоологч наарт сургалтыг яаж явуулах, мэдээллээ хүргэх (тоологч нарын сургалт ямар байх талаар) зэрэг асуудлаар хоёр өдрийн сургалт явуулсан.

#### Аймаг, нийслэлийн Засаг дарга нарын сургалт

Аймаг, нийслэлийн Засаг дарга нарыг тооллогын комиссын даргаар томилсон тул тэд наарт зориулж ҮСГ 1998 оны 8-р сард нэг өдөр, 1999 оны 10-р сард Улаанбаатар хотод гурван өдрийн эрчимтэй сургалт зохион явуулсан. Тэдний үндсэн үүрэг нь удирдах, зохион байгуулах, нэхцэл бололцоог бүрдүүлэх явдал байсан тул сургалтаар тооллогын хэрэгцээ, шаардлага, тооллогын үр дүнг хэрэглэх, бэлтгэл ажил, зохион байгуулалт болон санхүүгийн талаархи ерөнхий мэдээллийг өгсөн.

#### Тооллогын ажилтнуудад сургалт явуулах багш нарын сургалт

1999 оны 10-р сараас хойш сургалтын хөтөлбөрийн анхаарал татсан гол зүйл бол газрын зургийн зураглаач, хүн амын бүртгэл хөтлөгч, тоологч, шалгагч зэрэг тооллогын үндсэн газар дээр ажиллах хүмүүсийг сургах багш нарыг

бэлтгэх, сургалтын материалыг боловсруулах асуудал байв. ХАТСТ-ны ажилтнууд сургалтын материал бэлтгэн, туршиж, тоологч нарт сургалт явуулах тусгай сургалтад оролцсон тул бүх түвшний сургалтыг явуулах чадвартай болсон байв.

Үндсэн газар дээр ажиллах тоологч, шалгагч нарыг сургах багш нарыг бэлтгэх сургалтад аймаг, нийслэлийн статистикийн хэлтсийн дарга нар оролцсон бөгөөд уг сургалтыг хоёр шаттайгаар 1999 оны 10-р сарын 12-14, 11-р сарын 17-19-ний хооронд явуулав. Сургалтад тооллогын удирдлага, зохион байгуулалт, тооллогын бэлтгэл ажил, тооллогод хэрэглэх ойлголт, тодорхойлолт, тооллогын хуудасны бүтэц, тооллогын асуултыг асуух арга, хуудсыг нөхөн зэрэг сэдвийг заалаа. Үүний зэрэгцээ тооллогын ажлыг газар дээр зохион байгуулах, ажлын чанарыг шалгах зэрэг асуудлыг хамрав. Тус сургалтаар тооллогын ерөнхий хөтөлбөр, аймаг, нийслэл нэг бурийн тооллогын бэлтгэл ажлын явцыг хэлэлцэж, тулгарч байгаа болон цаашид тулгарч болзошгүй хүндрэлтэй асуудлыг хэлэлцэж, зөвлөгөө өгч байв. Эдгээр сургалтад ҮСГ-ын бусад газар, хэлтсээс сонгогдсон хүмүүсийг мөн хамруулав.

Аймаг, нийслэлийн статистикийн хэлтсийн дарга нар орон нутагтаа очоод тооллогын комисс, түр товчооны ажилтан нарт тооллогын зохион байгуулалт, удирдан явуулах талаар сургалт явуулсан.

### **Тоологч, шалгагч нарын сургалт**

Тооллогын чанар бүхэлдээ ямар байх нь тоологч тоолох ёстой өрх, хүн амаа бүрэн гүйцэд тоолж, ярилцлага авч, үнэн зөв мэдээлэл цуглуулж, ажлаа хэр зэрэг гүйцэтгэнээс асар их хэмжээгээр шалтгаалдаг. Тооллого явуулж байсан хүмүүсийн өмнө тулгарсан хамгийн хүнд асуудал бол санхүү болон цаг хугацааны хувьд хомс, давчуу байсан үед тоологч нарт аль болох хамгийн сайн сургалт хийх явдал байв.

ҮСГ-ын багш нар тоологч, шалгагч нарт зориулсан гурав дахь шатны буюу үндсэн сургалтыг аймгуудад зохион явуулав. Энэ сургалт 1999 оны 11-р сарын 20-ноос эхэлсэн болно.

ҮСГ-ын багш нарын ур чадварыг зөв зохистой ашиглахын тулд тооллого явуулахад хамгийн хүндрэлтэй хөдөөгийн зарим сум, аймгийн төвд тэд очиж тоологч, шалгагч нарын сургалтыг явуулав. Бусад сумдад аймгийн тооллогын түр товчоо болон комиссын гишүүд очиж сургалт явуулсан. Багш нарын тоо нэгэнт хангалтгүй байсан тул нэг багш дунджаар 3-5 sumaар орж сургалт явуулсан.

Нийслэлийн хороодод ҮСГ-ын үндсэн багш нараар сургалт явуулах илүү боломжтой байв. Нийслэл хотын тоологч, шалгагч нарын сургалт 1999 оны 12-р сарын 20-нд эхэлсэн. Дийлэнхи хорооны сургалтыг, ялангуяа шаардлагатай гэж үзэж байсан хороонд тоологч, шалгагч нарын сургалтыг ҮСГ-ын ажилтнууд хийсэн. Үлдсэн хороодын тоологч, шалгагч нарын сургалтыг дүүргийн тооллогын түр товчооны ажиллагсад хийсэн хэдий ч ҮСГ-ын ажилтнууд шаардлагатай үед очиж тусалж байв.

Тооллогын сургалтын стратеги бол тоологч нарт дэмжлэг үзүүлэхийн тулд тооллогын ажилд оролцож байгаа бусад түр ажиллагсдыг сургах явдал байлаа. Жишээлбэл, тооллогод хүн амыг бүрэн хамруулах нь тухайн нутаг дэвсгэрийн хүн амыг урьдчилан сайн бүртгэж, судалсан байхаас их шалтгаална. Нэгдүгээрт, байшин, орон сууц бүрийн дугаар, байрлалыг зураг дээр үзүүлсэн байх шаардлагатай. Хоёрдугаарт, тооллогын хэсгийн орон сууц нэг бүрт оршин суудаг өрхийн тоо, өрх нэг бүрт амьдарч байгаа хүний нэрсийн жагсаалтыг хийсэн байх шаардлагатай. Эдгээр газрын зураг болон өрх, хүн амын жагсаалтыг газрын зургийн зураглаач, хүн амын бүртгэл хөтлөгч нар хийсэн.

### **Газрын зургийн зураглаач, хүн амын бүртгэл хөтлөгч нарын сургалт**

1999 оны 12 сард тооллого эхлэхийн өмнө сүүлийн сургалтыг явуулсан. Газрын зургийн зураглаачаар ажиллах хамгийн тохиромжтой хүмүүсийг хороо болон сумын тооллогын түр товчоонаос сонгож, сургасан. Газрын зургийн зураглаач нар өөрсдийн зурсан хэсэг дээр боломжийнхоо хирээр ажиллаж, тоологч, шалгагч нарт тооллого явуулах үед газрын зургаа тайлбарлаж өгч байв.

#### **1. 4. Газрын зураг, өрх, хүн амын бүртгэл**

Тооллогыг чанарын өндөр түвшинд сайн явуулахад газрын зураг чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь нэгдүгээрт, тооллогыг удирдан явуулж байгаа хүмүүс өөрсдийнхөө ажлыг тухайн засаг захиргааны нэгжийн зургийн дагуу төлөвлөж, тооллогын үйл явцыг зохицуулахад илүү хялбар болгодог, хоёрдугаарт, тоологдох орон сууцыг тоологч нарт бүрэн оноож өгснөөр тоологч нарын гүйцэтгэх ажлын хуваарийг тооллогын хэсгийн хил хязгаартай яв цав нийцүүлснээр бүх өрхийг тооллогод хамруулахад гол үүрэг гүйцэтгэдэг, гуравдугаарт, системтэйгээр зохион байгуулж, шаталсан газар зүйн тогтолцоо нь сэдэвчилсэн газрын зураг ашиглах боломжийг олгож, ингэснээр тооллогын үр дүнгээс гарах бүтээгдэхүүний төрөл, тоог баяжуулдаг юм.

Хүн ам, орон сууцны улсын тооллого явуулах тухай Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 28 дугаар тогтоолд нэг тоологч хотод 300-350 хүн, хөдөөд 30-35 өрх тоолно гэж заасан. Энэ заалтын дагуу 12,7 мянган тооллогын хэсгийг байгуулсан бөгөөд тооллогын хэсэг бүрт тооллогод зориулсан газрын зураг шаардлагатай байлаа.

Тооллогын комиссууд нийслэл, аймгийн төв, тосгоны газрын зургийг бэлтгэж, 1999 оны 9-р сард, сум, багийн газрын зургийг 1999 оны 11-р сард ҮСГ-т ирүүлэх байв. Нийслэл, аймгийн төвийн газрын зургийг тогтоосон хугацаа өнгөрсний дараахан бэлэн болгож, 1999 оны 10-р сард ҮСГ-т ирүүлжээ. Харин хөдөөгийн хувьд хүн хүч, бусад эх үүсвэрийн хүндрэлтэй байсны улмаас тооллогын газрын зураг, өрх, хүн амын бүртгэлийг малын тооллоготой хамтруулан хийх нь зүйтэй гэж үзээд 1999 оны 12-р сарын 8-наас эхэлсэн мал тооллогын ажилтай хамт өрх, хүн амын бүртгэлийг хийх шийдвэр гаргасан. Өрх, хүн амын бүртгэл хийсний дараа газрын зураг зурах ажлыг эхэлсэн юм. Хөдөөгийн газрын зургийг 1999 оны 12-р сарын 25 гэхэд хийж, бэлэн болгосон.

Хот суурин газарт зураглал хийх хөдөөгийнхөөс ихээхэн өөр нөхцөл байдалд байсан. Тооллогын хэсэг хоорондын хил хязгаарыг тодорхой болгож, өрхийг тооллогод бүрэн хамруулах нөхцлийг хангахын тулд хотод газрын зургийг тооллогын хэсгээс эхлээд бүх түвшинд хийв. Нийслэлийн хувьд тооллогын газрын зургийг тооллогын хэсэг, хороо, дүүрэг, нийслэлийн гэсэн түвшинд, аймгийн төвийн хувьд аймгийн төвийн сум, баг, тооллогын хэсэг гэсэн түвшинд зурсан юм.

Тооллогын хэсгийн газрын зургийг ашиглах нь тоологдох орон сууцыг бүгдийг тооллогод хамруулсан эсэхийг бүрэн гүйцэд сайн хянахад төдийгүй, тэдгээр орон сууцаанд байгаа хүн нэг бүрийг тооллогод хамруулахад чухал юм. Ийм зорилгоор орон сууц болгонд сууж байгаа өрх нэг бүрийг бүртгэх маягт боловсруулж ашигласан. Бүртгэл хийж байх үед тухайн өрхөд байнга болон түр хугацаагаар сууж байсан хүн нэг бүрийг маягтад бүртгэсэн юм. Өрх, хүн амын бүртгэлийн маягтад орон сууцны дугаар, орон сууцны төрөл, өрхийн хаяг, өрхийн гишүүдийн овог нэр, суурьшил зэрэг үзүүлэлтийг оруулсан. Энэхүү маягтыг хөдөөд мал тооллогын үед багийн ажилтан, хотод өрх, хүн амын бүртгэлийг хороо хийсэн.

### 1. 5. Ухуулга, сурталчилгаа

Тооллогыг амжилттай явуулахад улс орны төр, засаг захиргааны бүх түвшний байгууллагын зүгээс туслалцаа авч чадсанаас ихээхэн шалтгаалдаг. Санхүүгийн бэрхшээлтэй байдал 2000 оны тооллогын сурталчилгааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилтыг бүрэн биелүүлэхэд нөлөөлсөн юм.

#### Тооллогын ухуулга

Тооллого бол ҮСГ дангаараа амжилттай хийж чадахааргүй үндэсний хэмжээний үйл ажиллагаа гэдгийг нийтэд мэдүүлэх явдал нь ҮСГ-аас хийх хамгийн гол ажил байсан учраас үндэсний хэмжээний энэ ажилд бүх нийтийг өргөн оролцуулах, тэдний оролцоог улам бүр өргөжүүлэх шаардлагатай байв. Төр, засаг захиргааны бүх түвшинд тооллогын ажилд асар их хэмжээний дэмжлэг үзүүлсэн юм. Улсын түвшинд Ерөнхий сайд өөрөө тооллогын улсын комиссын дарга байсан бөгөөд тооллогын гол ухуулагчийн үүрэг гүйцэтгэсэн.

Өргөн хүрээтэй туслалцаа авах, тооллогын ухуулгыг үр ашигтай явуулахын тулд тооллогын комиссын албан ёсны сүлжээг байгуулсан. Гол гол яамны сайд нар тооллогын улсын комиссын гишүүнээр, ҮСГ-ын дарга тооллогын улсын комиссын орлогч дарга, ҮСГ-ын дэд дарга комиссын нарийн бичгийн даргаар томилогдон ажилласан нь тооллогын улсын комиссын гишүүд зөвхөн хэрэглэгчийн зүгээс биш, харин ухуулагч болж тооллогын бүх үйл ажиллагаанд тусламж, дэмжлэг үзүүлэх үүргээ ухамсарлан ажиллах нөхцлийг хангасан юм. Тооллогын бүх шатны комисс, түр товчоод нь үндэсний хэмжээний ухуулга, сурталчилгааны сүлжээг бүрдүүлж байлаа.

Улсын яам, агентлаг, сайн дурын байгууллага, хандивлагч орнуудтай хэд хэдэн уулзалт зохиосон нь тооллогын талаар мэдээлэл өгөх, тооллого явуулах шаардлагын талаархи ойлголтыг бий болгоход ҮСГ-т их туслалцаа үзүүлсэн. Энэ ажлын хүрээнд 1999 оны 6-р сард тооллогын асуудлаар хандивлагчдын уулзалтыг зохион явуулсан юм.

## Тооллогын сурталчилгаа

Тооллогын хөтөлбөрийн бусад хэсгийн нэгэн адил тооллогын сурталчилгаа хийх санхүүгийн эх үүсвэр хүрэлцээгүй байсан тул сурталчилгааны гол стратеги бол байгаа нөөцөө ашиглан аль болох нааштай үр дүн гаргахад оршиж байв.

Дорнод аймагт хийсэн туршилтын тооллогын үеэр түүнийг явагдаж байгаа талаар Монгол телевиз, радиогоор, мөн сонгосон газруудад хүмүүс биечлэн очиж мэдээлэл түгээж байсан хэдий ч түүнээс илүү сурталчилгааны ажил хийсэн бол тустай байх байсан гэдэг нь харагдсан юм. Сурталчилгааны ажил 1999 оны 5-р сард нийслэлийн Чингэлтэй дүүрэгт явуулсан туршилтын тооллогын үед сайжирсан. Телевиз, радиогоор сурталчилхаас гадна "Өнөөдөр" сонинд тусгай ярилцлага нийтлүүлж, туршилтын тооллогод оролцохыг уриалсан зурагт хуудас зэргийг бэлтгэж, сонгогдсон хороонуудын гол гол үйлчилгээний төвүүдэд байрлуулсан.

Тооллогын эмблемийг хийж, 1999 оны 5-р сард батлуулсан. Энэ эмблемийг аль болох олон хүнд хүргэж, түүгээр тооллогыг мэддэг болоход зориулж сурталчилгааны ажилд хэрэглэсэн юм.

Тооллогын сурталчилгааны хүндрэлтэй тал нь хувийн болон олон нийтийн бүх хэсгийг төлөөлсөн янз бүрийн бүлэг хүмүүст хүрэх явдал байв. Тооллогын талаар мэдээлэл өгөх хэмжээ болон бүтцийн хувьд ялгаатай хэд хэдэн цуврал илтгэлийг бэлтгэж, олон нийтэд тарааж, янз бүрийн сэтгүүл, сонинд хэвлүүлж, мөн телевиз, радиогийн сурталчилгаанд ашигласан. НҮБ-ын ХАС-тийн тусламжтайгаар тооллогын талаар телевизийн цуврал хөтөлбөр бэлтгэж явуулав. 1999 оны 11-р сараас эхлэн эдгээр хөтөлбөрийг тооллогын янз бүрийн лоозонгийн хамт сар бүрийн хоёр, дөрөв дэх долоо хоногт нэвтрүүлж, тооллогын талаар сонирхолтой мэдээлэл хийж, тооллогын эмблемийг сурталчилсан байна.

1999 оны 5, 6, 10-р саруудад болон 2000 оны 1-р сарын эхэнд ҮСГ-ын ахмад ажиллагсад оролцсон асуулт, хариултын нэвтрүүлгийг 4 удаа зохион явуулсан. Эдгээр нэвтрүүлэг дээр үндэслэн бичсэн илтгэлүүдийг Зууны мэдээ, Өнөөдөр, Монголын мэдээ, Өдрийн сонин, Үнэн сонинд хэвлэжээ. Үүнээс гадна 1999 оны 11-р сард асуулт, хариултын шууд нэвтрүүлгийг телевизээр, 2000 оны 1-р сард радиогоор явуулсан. Монгол телевизийн Цагийн хурд нэвтрүүлэг, Монголын радиогийн Хурд, мөн радио хөтөлбөрөөр тооллогын тухай, ялангуяа тооллого явуулахад хэдэн хоног үлдэж байгаа, тооллогод хүмүүсийг идэвхитэй оролцохыг уриалсан мэдээллийг тогтмол явуулж байсан. Тооллогын өмнөх 7 хоногт тооллогын сурталчилгааны богино хэмжээний телевизийн рекламыг өдөрт гурван удаа нэвтрүүлж байв. Тооллогын асуултыг яаж асуух, хариулахыг харуулсан жижиг хэмжээний жүжигчилсэн үзүүлбэрийг 1999 оны 12-р сарын 27-нд телевизээр үзүүлсэн юм.

Аймаг, нийслэлд зориулж сурталчилгааны материал бэлтгэсэн. Дөрвөн мянган ширхэг 60\*40 см-ийн хэмжээтэй өнгөт зурагт хуудас, түүнээс жижиг А4-ийн хэмжээтэй 10000 зурагт хуудас, 2000 дугтуй, 1000 ил захидалыг хэвлүүлж, аймаг, нийслэлийн тооллогын комисст тараасан. Аймаг, нийслэлийн комисс эдгээр материалыг хүлээж аваад зах, дэлгүүр, захиргааны байр, банк,

шуудангийн газар, эмнэлэг, сургууль зэрэг хүмүүс цуглардаг төвлөрсөн үйлчилгээний газар байрлуулахад зориулж сум, дүүргийн тооллогын комисст хүргүүлсэн байна. Үүнээс гадна олон илтгэл, тооллогын талаархи мэдээлэл болон бусад сурталчилгааны материалыг бүх тооллогын комисст орон нутгийн сурталчилгааны ажил явуулахад зориулж илгээсэн юм.

Ерөнхий сайд аймгийн Засаг дарга нартай радио хурал хийж тооллогын сурталчилгаа, бэлтгэл ажлын явцын талаар ярилцаж, хэлэлцсэн зарим асуудлыг шийдвэрлэх чиглэл өгсөн юм. Энэ радио хурлыг улс орон даяар нэвтрүүлж, дараа нь телевизээр мэдээлсэн нь өргөн хүрээг хамарсан сурталчилгааны том хэлбэр болжээ. Монгол Улсын Ерөнхий сайд тооллогын ажилд анхаарч ийнхүү идэвхитэй ажиллагаа явуулсныг үзүүлсэн нь ард иргэдийг тооллогод оролцоход түлхэц өгсөн сайхан үлгэр дууриалал болов. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди 2000 оны 1-р сарын 4-нд нийт иргэдэд хандаж тооллогод идэвхитэй оролцохыг уриалсан билээ.

Тооллогын үед FM радиогоор тооллогод оролцохын ач холбогдлын тухай лоозонгуудыг тогтмол явуулж байсан. Монгол телевизийн "Цагийн хүрд" нэвтрүүлгээр тооллогын ажлын явцын талаар тогтмол мэдээлж байлаа. Өдөр тутам телевиз, FM радиогийн сувгаар тооллогын талаархи мэдээлэл, тайланг үргэлж нэвтрүүлж, ихэнхи сонинд нийтэлж байсан болно. Тооллого явагдах 7 хоногт Улаанбаатар хотын төв гудамжинд тооллогын талаархи мэдээлэлтэй хоёр том самбар байрлуулсан. Үүнд дараахь мэдээллийг бичсэн байв.

*Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого 2000 оны 1-р сарын 5-11 нийт өдрүүдэд улс орон даяар явагдаж байна.*

*Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогод оролцож тоолуулах нь иргэн таны үүрэг мөн.*

Тооллогын эхний өдөр тоологч Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нараас ярилцлага авч байгааг телевизээр үзүүлж, сурталчилгааны ажилд ашиглав. Эдгээр бүх үйл ажиллагаа иргэдийг тооллогод өргөн оролцуулах, тооллогыг дотноор хүлээн авах, тоологч нар туслалцаа, дэмжлэг үзүүлэхэд чухал байсан гэж тоологч нар мэдээлж байсан.

Тооллого явуулж дууссаны дараа ч гэсэн тооллогод хандах олон нийтийн сонирхлыг хадгалах, тооллого улс орны сайн сайханд яаж нөлөөлөх талаархи мэдээллийг тэдэнд хүргэж байх нь чухал юм. Тооллого хэрхэн явагдсан, иргэд тооллогод яаж оролцсон, тооллогын нөхсөн хуудас болон бусад материалыг хэрхэн шалгаж, хүлээж аваад мэдээлэл боловсруулах төвд хэдийд шилжүүлсэн, тооллогын материалыг боловсруулах янз бүрийн шатны ажилд юу хийж байсан тухай мэдээллийн хэрэгслэлээр нэвтрүүлж байснаас гадна 2000 оны тооллогын тухай богино хэмжээний баримтат киног хийлээ.

## 1. 6. Асуулгын сорилт, туршилтын тооллого, тоолох үе, тооллогын чанарын шалгалт

### Асуулгын сорилт, туршилтын тооллого

Тооллогыг чанарын өндөр түвшинд явуулахын тулд тооллогын үйл ажиллагаа нэг бүрт зориулж туршилт хийх эсвэл үр ашиг, үр дүнгийн цуврал туршилт хийх нь зайлшгүй чухал. Хамгийн түгээмэл боловсронгуй туршилт бол тооллогын сорилт, туршилтын тооллого мөн. Тооллогын сорилтыг хийснээр шийдвэрлэх зарим асуудалд тооллогоор асуух асуултыг турших, асуултын хэллэгийг оновчтой болгох, тооллого явуулах багийн хамгийн боломжийн хэмжээ, ярилцлага авах норм тогтоох, тоологч нарын сургалтын хэлбэр зэрэг орно. Тооллогын сорилтын үр дүн нь үндсэн газар дээрх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахад чухал нөлөө үзүүлдэг. Харин туршилтын тооллого гэдэг нь тайлан дээр гарахын өмнөх сургуулалттай адил тооллогын бүхий л үйл ажиллагааг нэг зэрэг туршихыг хэлнэ. Иймд туршилтын тооллогоор жижиг аргачлалын чанартай асуудлыг бус, харин тооллогын өргөн хүрээтэй ойлголт болох тооллогын ерөнхий зохион байгуулалтын асуудлыг туршина.

Анхны албан ёсны бус асуулгын сорилтыг 1998 онд Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа (ХАНҮЭМС)-тай хамт хийсэн. Энэ нь өрхийн төрөл, хувь хүний асуулгын хуудсыг, өөрөөр хэлбэл тооллогын хуудас хэр оновчтой болсныг турших хязгаарлагдмал зорилготой байлаа.

Орон нутаг дахь анхны албан ёсны туршилтын тооллогыг 1999 оны 1-р сарын 5-11-нийг дуустал Дорнод аймгийн төвийн Хэрлэн сумын 2, 9-р баг, Сэргэлэн суманд хийв. Энэ туршилтад 12466 хүн ам, 2850 өрх (Хэрлэн сумын хоёр баг, Сэргэлэн сум бүхлээрээ) хамрагдсан. Туршилтын тооллогын гол зорилго нь өмнө хийсэн албан бус сорилтын үндсэн дээр дахин хянасан хүн ам, орон сууцны тооллогын хуудсанд байгаа тодорхой сэдвүүдийг тооллогод оруулах эсэх, асуултуудын дэс дараалал, хэллэг зэргийг туршихад оршиж байв. Мөн түүнчлэн энэхүү туршилтын тооллого нь үндсэн газар дээр ажиллах багийн зохимжтой хэмжээ, ажиллах хүмүүсийг сонгох шалгуур, сорилтын явцад тоологч нарын хийж гүйцэтгэх ярилцлагын дундаж хугацаа, сургалт хангалттай байгаа эсэх зэрэг тооллогын үндсэн газар дээрх ажлын зохион байгуулалттай холбоотой асуудлыг турших боломж олгосон.

Хамгийн сүүлийн гол туршилтын тооллогыг нийслэлийн Чингэлтэй дүүрэгт 1999 оны 5-р сард явуулав. Туршилтын тооллогод 2609 өрх, 11439 хүн хамрагдсан. Туршилтын тооллогоор өмнө явуулсан туршилтын тооллогын үед болон түүний дараа хэлэлцэж байсан аргачлалын чанартай асуудлаас гадна зохион байгуулалтын хариулт өгөх шаардлагатай зарим нэг чухал асуудалд илүү анхаарал тавьсан юм. Хамгийн чухал зүйл бол нийслэл хотын засаг захиргааны янз бүрийн түвшний, тухайлбал нийслэл, дүүрэг, хорооны тооллогын комисс, түр товчоог жинхэнэ тооллого явуулах үеийн ажилд татан оролцуулах, тэдний үйл ажиллагааг зохицуулахад оршиж байлаа. Мөн түүнчлэн тооллогын мэдээлэл боловсруулах системийг туршиж сайжруулах, туршилтын тооллогын хуудасны үндсэн дээр тооллогын үр дүнгийн хүснэгтүүдийг гаргаж авахад туршилтын тооллогыг ашигласан юм.

Энэ туршилт нь асуултуудын дэс дараалал, үг хэллэг найруулагатай холбоотой асуудлуудыг олж илрүүлэхэд хэрэгтэй байв. Тооллогч нарын зааврын дагуу ярилцлага авах, асуулгын хуудсыг нөхөх чадавхийг турших боломж өгсөн юм. Кодлох, мэдээлэл оруулах заавар хэр зэрэг болсныг эргэж хянах боломжийг бас олгов. Зарим засвар хийх тохиромжтой арга, засвар хийгдэхгүй байгаа тохиолдлын тоо зэрэг зохион байгуулалтын чухал мэдээллийг илрүүлсэн. Тооллогын олон төрлийн үр дүнгийн хүснэгтийг гарган авч болох мэдээллийн баазыг мөн бүрдүүлсэн байна.

## Тоолох үе

Тооллого 2000 оны 1-р сарын 5-ны өглөөний 8 цагаас эхэлж, 12-ны шёнийн 12 цаг хүртэл 7 хоног үргэлжилсэн. Тооллогын эхний хоёр өдөрт хотын хүн амын 42.3 хувь, дөрөв дэх өдрийн төгсгөлд 84.0 хувийг тоолсон байв. Тооллогын өдрүүдэд ХАТСТ-ны ажилтан нар өдөр бүр өглөөний 9 цагаас оройн 11 цаг хүртэл жижүүрлэн ажиллаж, урьдчилан зарласан утсаар лавласан бүх асуулт болон үндсэн газар дээр гарч байсан хүндрэлтэй асуудлуудын талаар тооллогын комисс, түр товchoодод хариулт өгч байсан.

Хүн амыг орхигдуулах, давхар тоолохоос сэргийлж тооллогын хамралтын зарчим боловсруулж, мөн хүн амын тодорхой хэсэг бүлгийг тодорхойлох зарим арга хэмжээг авсан. Хүмүүсийн тоолуулсан эсэхийг шалгах зорилгоор нисэх онгоц, хот хоорондын автобус, төмөр замын буудал, гааль, зочид буудал, гол зам гэх зэрэг газарт шалгалтын тусгай хэсэг ажиллуулж байв. Тооллогын шөнө гэрээсээ хол явах хүн байвал тэр хүнийг тооллогод урьдчилан тоолж, давхар тоолуулахаас зайлсхийх зорилгоор тооллогын үнэмлэх олгож байсан. Зорчин явах билет бичдэг хүмүүс билет бичихдээ тооллогын үнэмлэхтэй эсэхийг шалгах хэрэгтэй гэсэн заавар авсан байлаа.

Илүү хүндрэлтэй асуудал бол байнга оршин суудаг газаргүй, дээвэр, хонгил, дулааны шугам сүлжээ, уул, ой зэрэг газраар түр орогнодог гудамжны хүүхдүүд, гэр оронгүй хүмүүсийг тоолох юм. Ийм хүмүүсийг 1-р сарын 7 болон 10-ны өдрүүдэд цагдаагийн байгууллагын тусламжтайгаар тоолсон.

## Чанарын шалгалт

Тооллогын хамралт, хариултын үнэн зөв байдлыг сайжруулах зорилгоор үндсэн газар дээр, өөрөөр хэлбэл яг тооллого явах үед зориулж чанарын шалгалтын системийг бүрдүүлсэн. Тооллогын үйл явцыг заавар журмын дагуу явуулах, хүндрэлтэй асуудлуудыг хурдан шийдвэрлэх зорилгоор чанарын шалгалтын арга хэмжээг авч байв.

Чанарын шалгалтын зарим чухал арга хэмжээнд тооллогод зориулж хийсэн тооллогын янз бүрийн түвшний газрын зураг, ялангуяа тооллогын хэсгийн газрын зураг (тооллого явуулах үед зориулж хийсэн), мал тооллоготой хамт хийгдсэн өрх, хүн амын бүртгэл орно. Үүнээс гадна тооллогод туслах материал болгон ашиглаж болох орон нутгийн оршин суугчдын бүртгэлийг шинэчилсэн.

Хамгийн чухал зүйл бол тооллого явуулах үед үе шаттай заавар өгөх, туслалцаа үзүүлэх зарчмыг бий болгосон явдал юм. ҮСГ-ын ажиллагсад аль болох олон тооллогын түр товchoодод туслах, заавар өгөх зорилгоор ялангуяа

аймгийн түвшинд олон газраар явсан. Мөн түүнчлэн нийслэл, дүүргийн тооллогын товчоодтой өдөр бүр холбоотой ажиллаж, шаардлагатай гэсэн үед туслалцаа үзүүлж байв. Тооллогын комисс, түр товчоод хамгийн доод нэгжид хүрч, тэнд ажиллах ажиллагсдыг дагаж явж, газрын зураг, ажил үүргээ гүйцэтгэсэн эсэхийг шалгах, ажлыг удирдан чиглүүлэх, иргэдийн оролцох идэвхийг өндөр түвшинд байлгахын тулд орон нутгийн ухуулагчаар ажиллах зэрэг үйл ажиллагааны сүлжээг бий болгож ажилласан. Тооллого явагдах эхний үед төв суурин газарт тоологч нар ажлын явцаа тайлагнах, хүндрэлтэй асуудлаа хэлэлцэж тохирохоор хоногт ядаж хоёр удаа тооллогын түр товчоон дээр ирэх ёстой байв.

Шалгагч нар тоологч нарын ажилд туслах, тоологчийн авсан ярилцлагыг шалгах, тэдэнд зөвлөгөө өгч, ажил дээр давтан сургалт явуулсан нь тооллогын ерөнхий чанарыг сайжруулахад их хувь нэмэр болж байв. Ялангуяа шалгагч нар тоологч нарын тоолсон өрхөөр орж, дахин ярилцлага авах системтэй хөтөлбөр бий болгосон нь тоологч нарыг өөрсдийнхөө ажлыг сайн хийхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Үндсэн газар дээрх ажил дууссаны дараа тооллогын комисс, түр товчооны ажиллагсад тооллогын хамралтыг шалгах ажилд туслалцаа үзүүлсэн. Тоологдсон өрхийг газрын зураг, өрх, хүн амын бүртгэлтэй тулган шалгаж, ямар нэгэн эргэлзээтэй асуудал гарвал тухайн газар, айл өрхөд дахин очиж тодруулж байсан. Мөн түүнчлэн тооллогын түр товчоо тоологч ажлаа хангалттай сайн гүйцэтгэсэн гэдгийг батлахаасаа өмнө тооллогын хуудаснаас түүвэрлэн авч шалгалт явуулсан байна. Хүн амын суурьшлын байдлыг үнэн зөв тодорхойлсон эсэхийг шалгах оролдлого хийсэн. Энд түр өзгүй байгаа хүмүүсийг баг, хороо, сум, дүүрэг, аймгийн түвшинд тооллогын хуудсанд бичсэн одоогийн байгаа хаягтай нь тулгаж их хэмжээний ялгаа байгаа эсэхийг шалган тогтоож байв.

## 1. 7. Мэдээлэл боловсруулалт

### Мэдээлэл боловсруулах систем

Тооллого явуулахаар төлөвлөж байсан эхний үед ҮСГ-т байгаа тооцоолох тоног төхөөрөмж, бусад хэрэгсэл, программ хангамж орчин үеийн тооллогын материалыг боловсруулахад хангалттай биш байв. НҮБ-ын ХАС болон Статистикийн хэлтсийн тусламжтайгаар ҮСГ-т хэрэгжсэн “ҮСГ-ын мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, тархаах чадавхийг сайжруулах” MON/97/P10 төсөл, “Монгол улсын хүн амын болон нөхөн үржихүйн мэдээллийн баазыг сайжруулах” MON/97/P04 төслийн хүрээнд 1998 оны 1-р улирлаас эхлэн ҮСГ шинэ тоног төхөөрөмж, программ авч эхэлсэн юм. Ингэснээр 2000 оны тооллогод шаардлагатай тооцоолох техникийн хүчин чадлыг бэхжүүлэх үндсийг бий болгосон. Эхний ээлжинд ҮСГ 38 Сотрац компьютер, 2 ACER толгой компьютер болон бусад тоног төхөөрөмж авсан болно.

Программ хангамжийн хувьд ҮСГ IMPS багц программыг ашиглан тооллогын мэдээллийг боловсруулахаар шийдсэн. ҮСГ IMPS-ээс гадна программчлалын CLIPPER болон VISUAL BASIC хэлийг ашиглан тооллогод зориулж программ, мөн кодлох ажлыг түргэвчилэх зорилгоор Windows-ийн орчинд хайлт хийх программыг зохиосон юм. Кодлох, мэдээ оруулах, шалгах,

засварлах зэрэг мэдээлэл боловсруулах бүх төрлийн үйл ажиллагаанд зориулан Windows NT Server V4.0-ийг хянах төв болгон дотоод сүлжээг ашиглаг. Түүнчлэн YСГ мэдээллийг хадгалах, архивлах системийг дотоод сүлжээг ашиглан боловсруулсан байна. Энэ нь мэдээлэл боловсруулах, архивлах, шалгах үүргийг толгой компьютер дээр хийх боломжийг олгосон. Өдөр бүр ажлын явцын тайланг мэдээлэл хянах системд оруулж байв.

### **Мэдээллийг кодлох, шивэх**

Тооллогын бүх материалыг аймаг, дүүрэг шалгаж, хүлээн аваад, графикийн дагуу YСГ-т хүргүүлсэн. Мэдээллийг тоологч бүрээр багцлан боловсруулалтын нэгж болгон YСГ хүлээж аваходаа дахин шалгаж, баримт бүрдүүлсэн. Мэдээллийг бэлтгэх хамгийн чухал ажил бол тооллогын асуултын хариултуудыг кодлох байв. Кодлох, мэдээлэл шивэх ажил 3-р сараас эхэлсэн. Кодлогч операторууд үзүүлэлтүүдийн код зөв эсэхийг шалгаж, ажил эрхлэлт болон үйл ажиллагааны үндсэн чиглэлийн ангиллыг “Хайлт” программын тусламжтайгаар компьютерээр шалгаж, кодлосон юм. Энэ нь цаг хугацаа хожих, кодлолт жигд, чанарын өндөр түвшинд хийгдэх нөхцлийг бүрдүүлсэн.

Мэдээлэл шивэлт 2000 оны 4-р сарын 24-нд эхэлсэн. Энэ үйл ажиллагааг сааталгүй явуулахын тулд олон тооны шалгалтын системийг бий болгов. Мэдээлэл шивж оруулах ажлын явцыг бүртгэх, операторчийн ажлыг хянах компьютерийн программ боловсруулсан. Мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, мөн үр ашгийг зохицуулах зорилгоор нийслэл хот, аймгийн төвүүдийн тооллогын материалыг дахин шивсэн юм.

Мэдээлэл шивэх үйл ажиллагааны явцад 49 хүн мэдээлэл шивэх оператороор, 9 хүн дахин шивэлтийн оператороор, 8 хүн шалгагч буюу ахлагчаар ажилласан юм. 2000 оны 7-р сар дуустал бүх оператор хоёр ээлжээр, ажлын 6 хоногоор ажиллаж байв. 2000 оны 7-р сарын сүүл гэхэд Гадаад харилцааны яам, Батлан хамгаалах яам, Хууль зүйн яамны шугамаар тоолсноос бусад бүх материалыг шивж дуусгасан. Эдгээр яамны шугамаар тооллогыг тусгай зарчмаар явуулсан тул шалгалт, засвар хийх мөн тусгай зарчмыг бий болгох хэрэгтэй байсан.

### **Засварлах**

Засварыг хоёр шаттайгаар үйлдлээ. Эхний шатанд бичилтийн алдааг гараар засч, хоёр дахь шатанд IMPS болон Concor-ын засварын модулийг ашиглан автомат засвар хийсэн. Бүх засварын ажлыг ХАТСТ-ны ажиллагсад зохицуулж байсан ба 2000 оны 9-р сарын 10 гэхэд засварын ажил бүхэлдээ дууссан юм.

### **Тооллогын үр дүнгийн хүснэгт**

Тооллогын үр дүнгийн 36 хүснэгтийн анхны хувилбарыг Чингэлтэй дүүрэг, Дорнод аймагт явагдсан туршилтын тооллого, НҮБ-ын зөвлөмж, мэдээлэл боловсруулах болон тооллогын талаар ирсэн зөвлөхүүдийн зөвлөмж дээр үндэслэн боловсруулсан.

Тооллогын урьдчилсан дүнг 6 хүснэгтээр гаргаж, 2000 оны 3-р сарын 25-нд тооллогын улсын комисст танилцуулсан бөгөөд тус комисс урьдчилсан үр дүнг нийтэд тархаахыг зөвшөөрсөн юм.

2000 оны тооллогын үр дүнгийн хүснэгтийн төлөвлөгөөнд нийт 92 хүснэгт, үүнээс хүн амтай холбоотой 58 хүснэгт, орон сууцтай холбоотой 34 хүснэгт гаргахаар тусгасан. 2000 оны 6-р сард Өмнөговь, Дундговь аймаг, нийслэлийн Хан-Уул дүүргийн тооллогын материалыар үр дүнгийн хүснэгтийг боловсруулж, эдгээр хүснэгтийн хоорондын уялдаа холбоо, программын болон бусад алдааг шалгаж, засварласны үндсэн дээр дахин гаргаж авсан. Энэхүү гарган авсан хүснэгтийг дахин шалгаж, тооллогын үр дүнгийн хүснэгтийн эцсийн хувилбарыг 2000 оны 10-р сард гарган авлаа.

### **1.8. Тооллогын үр дүнг хэвлэн нийтлэх, хэрэглэгчдэд тархаах**

ҮСГ-ын хувьд тооллогын дараах үеийн хамгийн чухал зорилт бол хүн ам, орон сууцны тооллогын үр дүнг гаргаж хэрэглэгчдэд богино хугацаанд хүргэх, хэвлэн нийтлэх, гүнзгийрүүлсэн судалгаа, шинжилгээ хийх явдал бөгөөд тооллогын ажлын төлөвлөгөөний нэг үндсэн хэсэг нь тооллогын үр дүнг хэрэглэгчдэд хүргэх, тархаах төлөвлөгөө байв. Энэ төлөвлөгөөний дагуу Засгийн газрын яам, агентлагууд зэрэг гол хэрэглэгчдээс тооллогын үр дүнгээс ямар мэдээллийг авах сонирхолтой байгааг судлах зорилгоор хэрэглэгчдээс санал авах семинарыг 2000 оны 10-р сараас эхлэн зохион байгуулж, тэдгээрийн эрэлт хэрэгцээг судалсан болно. Эдгээр семинарын үеэр ҮСГ нь тооллогыг хэрхэн зохион байгуулж явуулсан, үр дүнг ямар үзүүлэлт, ангиллаар гаргаж авахаар бэлтгэж байгаа болон тооллогын үр дүнг хэрэглэгчдэд хүргэх төлөвлөгөөг танилцууллаа. Энэ уулзалт, ярилцлагын үр дүнд гол хэрэглэгч яам, газруудаас албан бичгээр хүсэлт ирсэн бөгөөд тэдгээрийн дагуу тооллогын үр дүнгээс гарган авах 100 гаруй хүснэгтэд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэ хүснэгт гарган авахаар болсон. Бодлогын даалгаварт холбогдох нэмэлт өөрчлөлт оруулж, яамдын хүссэн зарим мэдээллийг гаргаж хүргүүлсэн. Энэ ажлыг цаашид ч үргэлжлүүлэн гүйцэтгэсээр байна.

Тооллогын үр дүнг хэрэглэгчдэд хүргэх төлөвлөгөөний эхний үе шат нь урьдчилсан дүнг гаргаж, нийтэд хүргэх ажил байв. Тооллогын урьдчилсан дүнг тооллогыг удирдан зохион байгуулах улсын комисст 2000 оны 3 дугаар сарын 25-нд танилцуулж, дараа нь сэтгүүлчдэд зориулсан хэвлэлийн бага хурал хийж нийтэд зарласан. Мөн хүн ам, өрхийн тоо, өсөлт, нас, хүйсний бүтэц зэрэг үзүүлэлт, тооллогын зохион байгуулалт, тооллогод хэрэглэсэн ойлголт тодорхойлолтыг багтаасан тооллогын урьдчилсан дүнгийн тайланг монгол, англи хэл дээр хэвлүүлэн, гол хэрэглэгчдэд хүргүүлэв.

Тооллогын эцсийн үр дүнг 2000 оны 12-р сарын эхээр гаргаж, олон нийтэд албан ёсоор зарласан билээ. Тооллогын үр дүнг хэрэглэгчдэд тархаах төлөвлөгөөний дагуу хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогыг зохион байгуулж явуулсан тухай тайланг 2000 оны сүүлийн хагаст бэлтгэж, эхний ботийг 2001 оны 3-р сард монгол, англи хэлээр хэвлэн гаргав. Эхний ботид 2000 оны хүн ам, орон сууцны улсын тооллогыг удирдан зохион байгуулж явуулахад хуrimtluulsan туршлага, дараагийн тооллогыг зохион байгуулж явуулахад анхаарах асуудал, сайжруулах чиглэлийг оруулсан болно. Энэ нь дараа дараагийн хүн амын тооллогыг явуулахад мэргэжилтнүүд, тооллогын

талаар сонирхож буй эрдэмтэд, багш, оюутан сурагч, судлаач нарт тооллого явуулахад тулгарч байсан хүндрэлтэй асуудлуудыг яаж шийдвэрлэж байсныг бодит туршлагаас суралцах боломж олгож, улмаар тооллогыг илүү чанартай явуулахад үнэ цэнэтэй материал болсон.

Хоёр дахь ботийг зөвхөн монгол хэлээр албан хэрэгцээнд хэвлүүлэхээр бэлтгэв. Энэ ботид тооллого явуулахтай холбогдсон хууль эрх зүйн баримтаас эхлээд тооллогыг явуулах удирдамж, гарын авлага, сургалтын материал, тооллогын үе шатны ажлын төлөвлөгөө, тооллогын асуудлаар яам, агентлаг, орон нутагтай харьцсан албан бичиг, ҮСГ-аас гаргасан тушаал, бусад баримт бичиг зэргийг оруулсан бөгөөд тэдгээр нь дараагийн тооллого явуулахад чухал шаардлагатай эх үүсвэр юм.

Тооллогын үр дүнг хэрэглэгчдэд хүргэх төлөвлөгөөнд тусгагдсан нэг гол ажил бол тооллогын үндсэн үр дүнгийн тайлан юм. Энэхүү тайлан та бүхний гар дээр очиж байгаа нь энэ бөгөөд түүнийг монгол, англи хэлээр хэвлэн гаргаж байна. Энэ нь тооллогын эцсийн үр дүнгийн хүснэгтуудийг багтаасан албан ёсны нэлээд дэлгэрэнгүй тайлан болж байна. Цаашид бүх аймаг, нийслэл хотын хэмжээнд тооллогын тайлан тус тусад нь бэлтгэж хэвлүүлэх болно. Эдгээрээс гадна статистикийн эмхтгэл, сэдэвчилсэн судалгаа, тооллогын үр дүнгийн хүснэгтүүдээр аймаг, нийслэл, улсын хэмжээний ботиудыг 2001 онд багтаан хэвлүүлж, хэрэглэгчдэд хүргүүлэхээр бэлтгэж байна. Тооллогын үр дүнг тархаах, хэвлэн нийтлэх төлөвлөгөөнд тусгагдсан зарим гол ажлыг харуулав.

### **Хүснэгт 1.1. Тооллогын үр дүнгээр хэвлэгдэн гарсан болон цаашид хэвлэгдэх материалын жагсаалт**

Гарах бүтээгдэхүүн	Хугацаа	Тайлбар
1. Тооллогын урьдчилсан дүнгийн танилцуулга <b>Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого: Үндсэн үр дүн</b>	2000 оны 4-р сар	монгол, англи хэлээр тусдаа хэвлэгдсэн
2. тооллогыг зохион явуулсан тухай тайлан	2001 оны 3-р сар	монгол, англи хэлээр тусдаа хэвлэгдсэн
<b>Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого: Үндсэн үр дүн</b>		
3. -Улсын -Улаанбаатар -21 аймаг	2001 оны 7-р сар 2001 оны 9-р сар 2001 оны 9-р сар	монгол, англи хэлээр тусдаа хэвлэгдэнэ. монгол хэлээр хэвлэгдэнэ.
4. Тооллогын үр дүнгээр улс, аймаг, нийслэлийн эмхтгэл хэвлүүлэх -Улсын дүн -Улаанбаатар хот -21 аймаг -Орон сууцны нөхцөл	2001 оны 7-р сар	монгол, англи хэлээр
5. Тооллогын үр дүнгийн сэдэвчилсэн товхимолууд		
Монгол Улсын эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд	2001 оны 7-р сар	монгол, англи хэлээр тусдаа хэвлэгдэнэ.
Орон сууц, түүний нөхцөл	2001 оны 7-р сар	монгол, англи хэлээр тусдаа хэвлэгдэнэ.
Шилжих хөдөлгөөн, хотжилт	2001 оны 9-р сар	монгол, англи хэлээр

		тусдаа хэвлэгдэнэ.
<b>Эдийн засгийн идэвхи</b>	2001 оны 12-р сар	монгол, англи хэлээр тусдаа хэвлэгдэнэ.
<b>Гэрлэлт</b>	2002 оны 4-р сар	монгол, англи хэлээр тусдаа хэвлэгдэнэ.
<b>Боловсрол</b>	2002 оны 5-р сар	монгол, англи хэлээр тусдаа хэвлэгдэнэ.
<b>Өндөр настан</b>	2002 оны 6-р сар	монгол, англи хэлээр тусдаа хэвлэгдэнэ.
<b>Ястан үндэстэн</b>	2002 оны 7-р сар	монгол, англи хэлээр тусдаа хэвлэгдэнэ.
<b>Хүүхэд залуучууд</b>	2002 оны 10-р сар	монгол, англи хэлээр тусдаа хэвлэгдэнэ.
<b>6. Хүн амын хэтийн тооцоо</b>	2001 оны 9-р сар	монгол, англи хэлээр тусдаа хэвлэгдэнэ.
<b>7. “Монгол Улсын хүн ам ХХ зуунд” эмхтгэл</b>	2001 оны 10-р сар	монгол, англи хэлээр
<b>8. Тооллогын ойлголт, тодорхойлолт, нэр томъёоны лавлах</b>	2001 оны 11-р сар	монгол, англи хэлээр тусдаа хэвлэгдэнэ.
<b>9. Монгол Улсын хүн ам, нийгэм, эдийн засгийн гол үзүүлэлтийн атлас (GIS)</b>	2002 оны 10-р сар	монгол, англи хэлээр тусдаа хэвлэгдэнэ.
<b>Улаанбаатар хотын хүн ам, нийгэм, 10. эдийн засгийн гол үзүүлэлтийн атлас (GIS)</b>	2003 оны 2-р сар	монгол, англи хэлээр тусдаа хэвлэгдэнэ.

Тооллогын үр дүнг хэрэглэгчдэд хүргэх өөр нэг хэлбэр нь хэрэглэгчдийн захиалга хүсэлтээр тусгайлсан мэдээлэл, судалгааг бэлтгэж өгөх ажил юм. Энэ ажил дээрх төлөвлөсөн ажлуудын зэрэгцээ тогтмол хийгдэх болно (Хавсралт 2-ыг харна уу).

ҮСГ-ын ажилтнууд тооллогын мэдээллийг тархаах сургалтад оролцсон бөгөөд өнөөгийн байдлаар тус газрын өмнө тавигдаж байгаа гол зорилго бол мэдээлэл тархаалтын шинэ технологи болох газар зүйн мэдээллийн системийг бий болгон тооллогын дүнг хэрэглэгчдэд түгээх юм. Үүний зэрэгцээ тооллогын үр дүнг ҮСГ-ын ВЭБ хуудсаар дамжуулан гадаад, дотоодын хэрэглэгчдэд хүргэнэ.

### **1. 9. Тооллогод хэрэглэсэн ойлголт, тодорхойлолт болон тооллогын хуудасны боловсруулалт**

Тооллогын хуудасны боловсруулалт нь тооллогыг амжилттай явуулах үндэс болдог. Тооллогын хуудас болон тооллогод хэрэглэсэн ойлголт, тодорхойлолт хамтдаа тооллогын хамралт, өөрөөр хэлбэл хэнийг тооллогод хамруулах, мөн тооллогын хүрээг, хэрэглэгчид тооллогоос юу авах вэ гэдгийг тогтоож өгнө. Иймд тооллогын хуудсанд орсон ойлголт, тодорхойлолт, сэдэв болон тэдгээрт агуулагдах асуудлуудыг боловсруулахад анхаарал тавьж ажиллах нь чухал байдаг бөгөөд ялангуяа 2000 оны тооллогын мэдээллийг цуглуулахад олон улсын нийтлэг жишгийг дагаж, олон төрлийн аргыг шинээр хэрэглэсэн тул илүү анхаарал тавих шаардлагатай байв.

## Тооллогын хамралт, байнгын оршин суугч

2000 оны тооллогод хэрэглэсэн байнгын оршин суугчийн үндсэн тодорхойлоор тухайн хүн тоологдож байгаа өрхдөө (сум эсвэл дүүрэгтээ) зургаа, түүнээс дээш сарын хугацаанд амьдарсан байх ёстой. Гэхдээ тухайн хүн тооллогын үед оршин сууж байгаа өрхдөө (сум эсвэл дүүрэгтээ) өнгөрсөн зургаан сарын дотор шилжин ирсэн боловч цаашид эндээ зургаа, түүнээс дээш сараар амьдрах бол түүнийг байнгын оршин суугч гэж үзсэн. Үүний эсрэгээр тухайн хүн өөрийнхөө өрхөөс (сум, дүүргээс) шилжин яваад зургаан сар хүрээгүй ч гэсэн цаашид ядаж зургаан сар тэндээ амьдрах бол байнгын оршин суугч гэж үзэхгүй бөгөөд түүнийг тухайн өрхөд (сум, дүүрэгт) тоолоогүй юм.

Тооллогын хамралтыг тодорхойлоход хэрэглэгдэх өөр нэг чухал ойлголт бол тооллогын хугацааны тов юм. Тооллогыг 2000 оны 1-р сарын 5-11-ний хооронд 7 хоногийн хугацаанд явуулсан хэдий ч тооллогын үр дүнг тайлбарлахдаа тооллого хатуу тогтоосон нэг хугацаанд хамааралтай гэдгийг анхаарах нь чухал. 2000 оны 1-р сарын 4-ний шёнийг тооллогын шөнө гэж тогтоосон. Ерөнхийдөө энэ ойлголт ярилцлага өгч байгаа хүн болон тоологч нарт ямар нэгэн хүндрэл учруулаагүй. Харин цөөн тохиолдолд тооллогын шөнө тухайн хүн хаана байснаас шалтгаалж хүндрэл учирч байсан. Жишээлбэл, тухайн хүн тооллогын шөнө замд явж байсан бол цагийг тооллогын шёнийн (2000 оны 1-р сарын 4-ний шөнө) 12 цаг буюу тооллогын товтой харьцуулан илүү нарийн гаргаж суурьшлыг тодорхойлж байсан.

## Тооллогын асуулгын хүрээ

Хүн амын 2000 оны тооллого 1989 оныхоос хэд хэдэн үндсэн зарчмаар ялгаатай байсан. Энэ тооллого зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа үеийн анхны тооллого байсан тул эдийн засаг, нийгмийн талаархи шинэ төрлийн мэдээллийг хэрэглэгчдийн зүгээс шаардаж байв. НҮБ-ын Статистикийн Комиссын баталсан хүн ам, орон сууцны тооллогын тухай зөвлөмж, зарчмыг тооллогын хуудас боловсруулахад чухал гарын авлага болгон ашигласан.

Тооллогын хуудсыг батлахаас өмнө сайн хэлэлцэж тохиролцох, газар дээр нь турших шаардлагатай байв. 2000 оны тооллогын хуудсыг боловсронгуй болгох, ингэхдээ өмнөх тооллогуудынхтай харьцуулахуйц байлгах гэсэн хоорондоо зөрчилтэй зарим асуудлыг нэгтгэн шийдвэрлэсэн болно. Олон улсын зарчим болон НҮБ-ын зөвлөхүүдийн санал, зөвлөмжийг баримтлан, хүн амын тооллогод хамруулах сэдвүүдийн талаар олон дахин хэлэлцэн, ярилцсаны эцэст дараахь сэдэв, асуултуудыг тооллогод хамруулахаар тогтсон.

## 1 Нийгэм, хүн ам зүйн үзүүлэлтүүд

Нэр

Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох

Төрсөн, он, сар

Нас

Хүйс

Гэрлэлтийн байдал

Харъяалал

Яс үндэс

## 2 Газар зүй, шилжих хөдөлгөөний үзүүлэлтүүд

Суурьшлын байдал

Байнга суудаг газраа оршин сууж байгаа хугацаа

Төрсөн газар

Таван жилийн өмнө оршин сууж байсан газар

## 3 Боловсролын үзүүлэлтүүд

Боловсролын түвшин

Бичиг үсгийн мэдлэг

Сургуульд суралцаж байгаа эсэх

## 4 Эдийн засгийн үзүүлэлтүүд

Ажил эрхэлдэг эсэх (сүүлийн 7 хоногийн байдлаар)

Эрхэлдэг ажил

Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл

Ажил эрхлэлтийн байдал

Ажил эрхлээгүй шалтгаан

Хүн ам, орон сууцны тооллогын хуудасны эхний хувилбараар 1998 оны 10-12-р сард явагдсан ХАНҮЭМС-гаар 1500 орчим өрхөд албан бус байдлаар сорилт хийсэн. Энэ сорилтоор асуултууд ерөнхийдөө боломжийн болсон хэдий ч цаашид сайн нарийвчлан судалж үзэх шаардлагатай, хүндрэлтэй асуудал нэлээд байгааг харуулсан юм. Үүнээс гадна зарим асуулт, ялангуяа эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой асуултуудыг зах зээлийн эдийн засгийн үеийн хэрэглэгчдийн хэрэгцээг хангахын тулд дахин эргэж харах шаардлагатай гэдэг нь харагдсан. Орон нутаг дахь анхны албан ёсны туршилтын тооллогыг 1999 оны 1-р сард Дорнод аймгийн төвийн Хэрлэн сумын 2, 9-р баг, Сэргэлэн суманд явуулсан.

Дорнод аймгийн туршилтаар тооллогын хуудсанд орох нэлээд олон асуултыг туршсан хэдий ч бүгдээрээ тооллогын жинхэнэ хуудсанд ороогүй болно. Дорнодын туршилтын тооллогын хуудсанд байсан шашин шүтлэг, анх гэрлэсэн нас, сүүлийн нэг жилийн нас барагт, төрөлттэй холбоотой хэд хэдэн асуултыг туршсан боловч жинхэнэ тооллогод оруулаагүй. Эдгээр асуултыг хассан үндсэн шалтгаан нь тооллогын хуудасны багтаамжид баригдах, тооллогод хамрагдах сэдвүүд тодорхой болсон зэрэгт оршино. Үүнээс гадна дээрх асуултын заримыг 1998 онд явуулсан ХАНҮЭМС-гаар (тооллоготой адил засаг захиргааны нэгжээр гаргаж чадахгүй ч гэсэн) илүү нарийн асууж, магадгүй илүү үнэн зөв үр дүн гаргасан тул тооллогод хамруулахгүй байх бас нэг шалтгаан болсон.

Төв, суурин газар дахь туршилтын тооллого нь нийслэлийн Чингэлтэй дүүрэгт 1999 оны 5-р сард явагдсан. Энэ туршилт нь тооллогод оруулахаар

сонгосон 19 асуултыг сайжруулах боломж олгосон байна. Тус туршилтын тооллогоор илрүүлсэн алдаа, дутагдал болон эдгээрийг эргэн хянасты үндсэн дээр тооллогын хуудсанд нэлээд өөрчлөлт орсон.

Хийгдсэн бүх өөрчлөлтөөс хамгийн чухал нь эдийн засгийн идэвхийн (хүн амын ажил эрхлэлт) талаархи асуултад орсон өөрчлөлтүүд юм. ҮСГ-ыхны дунд тооллогоос хүн амын эдийн засгийн идэвхийг ямар аргаар тооцох талаар чухал ярилцлага хийсэн. Зарим хүмүүс сүүлийн жилийн ажил эрхлэлтийн түүх дээр үндэслэсэн ажил эрхлэлтийн байнгын идэвхи гэсэн ойлголтыг ашиглаж эдийн засгийн идэвхийг тодорхойлох сонирхолтой байхад зарим нь улирлын чанартай ажлын хувьд зарим хүндрэл учирдагийг үл харгалzan тухайн үеийн идэвхи гэсэн ойлголтыг тохиромжтой гэж үзэж байв. Асуулгын хуудасны анхны хувилбар дээр ажил эрхлэлтийг тодорхойлоход байнгын болон тухайн үеийн идэвхи гэсэн хоёр аргын аль алиныг нь хэрэглэхээр оруулсан байснаа туршилтын тооллогын дараа өөрчилсөн.

Туршилтын тооллогоор нэлээд тооны хүндрэлтэй асуудлыг илрүүлсэн. Тухайн үед мөрдөж байсан хуулиар тогтоосон тэтгэврийн насыг үндэслэн эдийн засгийн идэвхийн талаархи асуултыг асуух насын дээд хязгаарыг эрэгтэй хүний хувьд 59, эмэгтэй хүний хувьд 54 гэж тогтоосон байсан нь ядаж өндөр настны талаархи судалгаа хийх боломжгүй болгох зэргээр тохиромжгүй тул 15, түүнээс дээш настай бүх хүмүүсээс асуухаар өөрчлөв. Хүн амын эдийн засгийн идэвхийг тодорхойлох хугацаа мөн тодорхойгүй байв. Туршилтын үед сүүлийн 12 сард ядаж 7 хоног ажилласан уу гэж асууж байсан нь байнгын болон тухайн үеийн идэвхи гэсэн хоёр өөр ойлголтыг хольсон мэт байв. Туршилтын тооллогын энэ асуулт бол ажил эрхлэлтийг илүү, ажилгүйдлийг дутуу тооцоход хүргэсэн нь тодорхой болсон. Ийм учраас эдийн засгийн идэвхийг тодорхойлох хугацааг сүүлийн 7 хоног болгож өөрчилсөн юм.

## Хүснэгт 1.2. Тооллогод хэрэглэсэн ойлголт, тодорхойлолт, 2000 он

Ойлголт	Тодорхойлолт	Насны хязгаар
Монгол Улсад байнга оршин суудаг хүний тоо	Тооллого явагдах үед Монгол Улсад байнга оршин суудаг хүн ам, өөрөөр хэлбэл байнга оршин суугч болон түр эзгүй хүний нийлбэр юм. (энд гадаадад зургаагаас дээш сараар амьдарч байгаа зарим хүмүүсийг түр эзгүй гэж оруулсан)	Бүх насы
Тооллогын шөнө	2000 оны 1-р сарын 4-нээс 5-нд шилжих шөнө	-
Тооллогын тов	2000 оны 1-р сарын 4-ний шөнийн 12 цаг	-
Байнга оршин суугч	Тухайн үеийн байнга оршин суугаа газартаа 6 сар, түүнээс дээш хугацаагаар амьдарсан, эсвэл 6 сар, түүнээс дээш хугацаагаар амьдрах хүн	Бүх насы
Түр эзгүй хүн	Байнга оршин суудаг газраасаа өөр газарт 6 сараас илүүгүй хугацаагаар явсан хүн	Бүх насы
Түр суугаа хүн	Тухайн өрхөд (засаг захиргааны нэгж) 6 сар, түүнээс бага хугацаагаар амьдарч байгаа хүн	Бүх насы
Өрх	Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо хамааралтай эсвэл хамааралгүй байж болно.	Бүх насы

<b>Ам бүлээрээ байгаа өрх</b>	Ам бүлээрээ байгаа өрх дангаараа амьдрахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, эхнэр, нөхөр хүүхдийн (хүүхдүүдийн) хамт, мөн эцэг эсвэл эх нь хүүхдийн (хүүхдүүдийн) хамт өрх үүсгэн амьдрахыг хэлнэ.	-
<b>Нийлмэл өрх</b>	Нийлмэл өрхөд дараахь бүтэцтэй өрх хамрагдана. Үүнд: (а) нэг ам бүл бусад хамаатан садантайгаа хамт өрх үүсгэн амьдарч байж болно. Жишээлбэл, эцэг нь хүүхдүүдтэйгээ, бусад хамаатан садантайгаа; гэр бүл хосууд хамаатан садантайгаа амьдарч байж болно. (б) хоёр, түүнээс дээш, хоорондоо хамааралтай ам бүл дангаараа хамтран өрх үүсгэн амьдарч байж болно. Жишээлбэл, хоёр гэр бүл хос хүүхдүүдтэйгээ, бусад хамаатан садангүйгээр амьдарч байж болно. (в) хоёр, түүнээс дээш, хоорондоо хамааралтай ам бүл, аль нэгэнтэй нь хамааралтай хүнтэй хамт өрх үүсгэн амьдарч байж болно. Жишээлбэл, хоёр, түүнээс дээш гэр бүл хос нэг хамаатангийн хүнтэйгээ хамт амьдарч байж болно. (г) хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай боловч нэг ам бүлийн биш хүмүүс өрх үүсгэн амьдарч байж болно.	-
<b>Холимог өрх</b>	Холимог өрхөд дараахь бүтэцтэй өрх хамрагдана. Үүнд: (а) нэг ам бүл бусад хамаатан садан эсвэл хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байж болно. Жишээлбэл, эх нь хүүхдүүдтэйгээ, хамаатан садантайгаа болон хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байж болно. (б) нэг ам бүл, хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байж болно. Жишээлбэл, эцэг нь хүүхдүүдтэйгээ мөн хамаатангийн биш нэг хүнтэй өрх үүсгэн амьдарч байж болно. (в) хоёр, түүнээс дээш, хоорондоо хамааралтай ам бүл, аль нэгнийх нь хамаатан садан, хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байж болно. (г) хоёр, түүнээс дээш, хоорондоо хамааралтай ам бүл эдгээр ам бүлийн алинд ч хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байж болно. (д) хоёр, түүнээс дээш, хоорондоо хамааралгүй ам бүл бусад хүмүүстэй эсвэл хүмүүсгүйгээр амьдарч байж болно. (е) хоорондоо хамааралтай боловч ам бүлийн биш хоёр, түүнээс олон хүмүүс бусад хамааралгүй хүмүүстэй өрх үүсгэн амьдарч байж болно. (ё) хоорондоо хамааралгүй хүмүүс өрх үүсгэн амьдарч байж болно.	-
<b>Нийтийн байранд тоологдсон хүн ам</b>	Хүн амын тооллогын үед өрхөд тоологдоогүй цэрэг, хоригдол, цагдан хоригдогсад, албадан саатуулагсад, урьдчилан хорих байранд хоригдогсад, эмнэлэг, сургуулийн дотуур байранд амьдарч байгаа хүмүүс	Бүх насны
<b>Хотын хүн ам, өрх</b>	<b>Нийслэл</b> – Улаанбаатар хотын 9 дүүрэгт оршин суугаа бүх хүн ам, өрх <b>Аймгийн төв</b> - 21 аймгийн төвийн сумдад оршин суугаа бүх хүн ам, өрх <b>Тосгон</b> – Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогод зориулж ҮСГ-ын газраас гаргасан тосгоны жагсаалтад бичигдсэн суурин газарт оршин суугаа бүх хүн ам, өрх	Бүх насны

<b>Тосгон</b>	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуульд зааснаар 500-15000 оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг нь хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газрыг тосгон гэнэ.	-
<b>Хөдөөгийн хүн ам, өрх</b>	<b>Сумын төв</b> - Аймгийн төв, тосгонд ороогүй бусад сумын төвд оршин суугаа бүх хүн ам, өрх <b>Хөдөө</b> - Хөдөө эсвэл тосгоны жагсаалтанд ороогүй хөдөөгийн жижиг суурин газарт оршин суугаа бүх хүн ам, өрх	-
<b>Өрхийн тэргүүлэгч</b>	Өрхийн бусад гишүүд өрхийн тэргүүн гэж өргөмжилсөн хүн.	16, түүнээс дээш настай
<b>Нас</b>	Төрсөн он, сар, өдөр, тооллогын он, сар, өдрийн хоорондох бүтэн жилээр илэрхийлэгдэх зайд	Бүх насны
<b>Харьяалал</b>	Тухайн хүний тооллого явагдах үеийн хууль ёсны харьяалагдах улс	Бүх насны
<b>Яс үндэс</b>	Тухайн хүний тооллого явагдах үеийн хамаарагддаг гэж хэлж байгаа яс үндэс (Зөвхөн Монгол Улсын харьяат хүнээс асуусан.)	Бүх насны
<b>Төрсөн газар</b>	Монголд төрсөн бол төрсөн аймаг, нийслэлийн нэр, гадаадад төрсөн бол төрсөн улсын нэр	Бүх насны
<b>Байнга оршин сууж байгаа хугацаа</b>	Тухайн хүний байнга оршин суудаг аймаг, нийслэлдээ тасралтгүй амьдарсан бүтэн жилийн тоо	Бүх насны
<b>Өмнө нь байнга оршин сууж байсан газар</b>	Тооллогын үед байнга оршин суудаг газартаа хамгийн сүүлд шилжин ирэхээс өмнө байнга оршин сууж байсан аймаг, нийслэл, гадаадад байсан бол улсын нэр	Бүх насны
<b>1995 оны 1-р сарын 1-нд байнга оршин сууж байсан газар</b>	1995 оны 1-р сарын 1-нд байнга оршин сууж байсан аймаг, нийслэл, гадаадад байсан бол улсын нэр.	5 ба түүнээс дээш
<b>Гэрлэлтийн байдал</b>	Гэр бүлийн тухай Монгол Улсын хууль болон уламжлалт ёсны дагуу тухайн хүний тооллогын үе дэх гэрлэлтийн байдал	15 ба түүнээс дээш
<b>Боловсролын түвшин</b>	Монгол Улсын боловсролын тогтолцоо, эсвэл түүнтэй адилтгах сургууль дүүргэсэн боловсролын хамгийн дээд түвшин	7 ба түүнээс дээш
<b>Одоо суралцаж байгаа хүн ам</b>	Боловсрол олгох ямар нэг шатны сургуульд үнэмлэх авах болон мэргэжил өзээмшихээр суралцаж байгаа хүмүүс	7-29 насны
<b>Бичиг үсгийн мэдлэг</b>	Аль нэгэн хэлээр энгийн богино өгүүлбэрийг ойлгож, унших, бичих чадвар	7 ба түүнээс дээш
<b>Ажил эрхэлдэг хүн ам</b>	Сүүлийн 7 хоногт ядаж нэг өдөр ажил эрхэлсэн хүмүүс	15 ба түүнээс дээш
<b>Ажилгүйчүүд</b>	Сүүлийн 7 хоногт ажил хийгээгүй, тооллогын үед ажил хайж байгаа болон тохирох ажил олдохгүй байгаа хүмүүс	15 ба түүнээс дээш
<b>Тохирох ажил олдохгүй байгаа хүмүүс (итгэл алдарсан ажилчид)</b>	Урд нь ажил идэвхтэй хайж байгаад тохирох ажил олдохгүй итгэл алдарсны улмаас тооллогын өмнөх сүүлийн 7 хоногт ажил идэвхтэй хайгаагүй, өөрөө тохирох ажил олдохгүй гэж үзэж байгаа хүмүүс	15 ба түүнээс дээш
<b>Эдийн засгийн идэвхитэй хүн ам</b>	Тооллогын үед ажил эрхэлж байгаа хүн ам болон ажилгүйчүүд	15 ба түүнээс дээш
<b>Эдийн засгийн</b>	Эдийн засгийн идэвхгүй хүн амд тооллогын өмнөх	15 ба

<b>Идэвхигүй хүн ам</b>	7 хоногт дараахь шалтгааны улмаас ажил эрхлээгүй хүн ам хамрагдана. <ul style="list-style-type: none"> <li>• Сургуульд сурдаг</li> <li>• Тэтгэвэр, нөхөн олговорт</li> <li>• Өвчтэй, тахир дутуугийн группт</li> <li>• Гэрийн ажилтай</li> <li>• Бусад</li> </ul>	Түүнээс дээш
<b>Сууц</b>	Тооллогын үед айл, өрх амьдарч байсан, бүтцийн хувьд тусдаа, биеэ даасан орон байр (амьдрах зориулалтгүй байж болно).	-
<b>Байшин</b>	Бүтцийн хувьд нэг өрх амьдрах зориулалттай, нэг болон хэд хэдэн өрөөтэй сууц. Байшинд тусдаа байшин, нийтийн сууцны байшин, оюутан бусад хүмүүс амьдрах нийтийн байр болон бусад байшинд байгаа хүн амьдрах зориулалттай сууц орно.	-
<b>Сууцны тусдаа байшин</b>	Нэг болон түүнээс олон өрөөтэй, айл, өрх амьдрах зориулалттай баригдсан, зарим нь дэд бүтцийн хангамжтай (халаалтын систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг).	-
<b>Нийтийн сууцны байшин доторх сууц</b>	Хоёр, түүнээс олон айл, өрх амьдрахаар, тус тусдаа хаалгатай баригдсан байшин доторхи нэг өрх амьдрах сууц. Тохилог орон сууцанд хоёр, түүнээс олон айл, өрх амьдрах боломжтой, дэд бүтцийн хангамжтай (халаалтын систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг).	-
<b>Оюутан, сурагчдын нийтийн байр</b>	Боловсролын аль ч түвшинийн оюутан, сурагчид хамтран амьдрахад зориулсан байшин.	-
<b>Нийтийн байр</b>	Ажиллагсад, цэрэг болон нийтээрээ амьдардаг хүмүүсийг хамт амьдрахад зориулсан байшин.	
<b>Сууцны бус</b>	Анхнаасаа хүн суух зориулалтын бус байшин, түүний нэг хэсэг буюу өрөө тасалгаанд (зориулалтаараа аж ахуйн нэгж, байгууллага байрлахад зориулагдсан гэх мэт) болон вагончик гэх зэрэгт өрх айл, хүн сууж байгаа бол сууцны бус байшин гэж үзнэ.	-
<b>Бусад орон сууц</b>	Тооллогын үед өрх, айл, хүн амын сууж байгаа, сууцны тусдаа байшин, нийтийн сууцны байшин доторх сууц, оюутан сурагчдын нийтийн байр, ажиллагчдын нийтийн байр, нийтийн эзэмшлийн бусад байрнаас бусад байр, сууцыг хэлнэ.	-
<b>Өрөөний тоо</b>	Нийт өрөөний тоонд унтлагын өрөө, амрах болон ажлын өрөө орно.	-
<b>Сууцны талбай</b>	Орон сууцны унтах, амрах, зочин, ажлын өрөөнүүдийн талбайн нийлбэрийг Сууцны талбай гэнэ.	-
<b>Төрийн өмчийн сууц</b>	Төрийн болон төрийн өмч давамгайлсан (төрийн өмч нь 51 хувиас дээш) аж ахуйн нэгж, байгууллагын мэдлийн сууц (сууж байгаа өрх сууцаа хувьчилж аваагүй), гэр, байр үүнд хамрагдана.	-
<b>Хувийн өмчийн сууц</b>	Хүмүүс өөрөө барьсан хувийн орон сууц, нийтийн сууцны байшин дахь хувьчилж авсан орон сууц, мөн хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын (Өмчийнх нь 51 хувиас дээш хувийн өмчтэй) мэдлийн сууц, гэр үүнд хамрагдана.	-
<b>Холимог өмчийн сууц</b>	Төрийн, хувийн холимог өмч(адилхан 50 хувийн өмчтэй)-ийн аж ахуйн нэгж, байгууллагын мэдлийн байр, сууц, гэрийг үүнд хамруулна.	-

Эдгээр шинэчилсэн болон цоо шинээр бий болгосон тодорхойлолтоос шалтгаалан хүн амын 2000 оны тооллого олон талаар 1989 оныхоос ялгаатай байв.

Гол өөрчлөлтийн нэг нь судалгаа хийхэд чухал сэдэв болох шилжих хөдөлгөөний сэдвийг 2000 оны тооллогод оруулсан явдал юм. Эдийн засгийн идэвхийг тооцож гаргахад шинэ арга хэрэглэсэн тул хоёр тооллогын ажил эрхлэлтийн тоог тайлбарлахад маш анхааралтай хандах хэрэгтэй.

1989 онд асуусан мөртлөө 2000 онд асуугаагүй асуултууд байгаа гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Эдгээрт эзэмшсэн мэргэжил, амьдралын эх үүсвэр, төрөлтийн асуултууд орно.

### **Хүснэгт 1.3. 1989, 2000 оны тооллогын хуудсанд орсон хүн амын талаархи сэдэв болон асуултын ялгаа**

Сэдэв	Асуулт	1989	2000	Тайлбар
Шилжих хөдөлгөөн	1. Төрсөн газар	Асуусан	Асуусан	Төрсөн газраас шилжсэн байдлыг гаргана.
	2. Байнга оршин суугаа хугацаа, тооллогын өмнө байнга оршин сууж байсан газар	Асуугаагүй	Асуусан (Байнга суудаг аймаг, нийслэлдээ хэдийнээс сууж байна вэ?) (шилжиж ирсэн аймаг, нийслэл, улс, он)	Шилжих хөдөлгөөнд орсон хүмүүсийн байнга оршин суусан хугацаа, шилжих хөдөлгөөний ургалыг тодорхойлно.
	3. Таван жилийн өмнө байнга оршин сууж байсан газар	Асуугаагүй	Асуусан	Сүүлийн таван жилийн цэвэр шилжих хөдөлгөөн болон шилжих хөдөлгөөний ургалыг тодорхойлно.
Бичиг үсгийн мэдлэг, боловсрол	1. Боловсрол болон бичиг үсгийн мэдлэг	Нэг асуултаар асуусан	Салгаж асуусан	1989 онд боловсрол, бичиг үсгийн мэдлэгийг нэг асуултаар асууж байсан; дунд боловсролоос дооши түвшинг бага боловсрол, бичиг үсэг мэддэг, бичиг үсэг мэддэггүй гэж хуваажээ. 2000 онд боловсрол, бичгийн үсгийн мэдлэгийг хоёр өөр асуултаар асуусан тул боловсролгүй хүмүүсийн бичиг үсэг мэдэж байгаа эсэхийг тодорхойлж болно.
	2. Сургуульд суралцаж байгаа эсэх	Асуусан	Асуусан (Та одоо сургуульд сурдаг уу)	1989 онд та сургууль сурдаг уу гэж асуугаагүй. Ажлын газар, суралцдаг сургууль гэж асуусан.

	3. Эзэмшсэн мэргэжил	Асуусан	Асуугаагүй	Шаардлагагүй гэж үзсэн.
Гэрлэлтийн байдал	Гэрлэлтийн байдал	Асуусан	Асуусан	1989 оны гэрлэлтийн байдлын асуултын хариулт нь огт гэрлээгүй, батлуулсан гэр бүлтэй, бэлбэсэн, салсан гэж өгөгдсөн 2000 онд батлуулаагүй гэр бүлтэй, тусгаарласан гэсэн хоёр хариултыг нэмсэн.
Эдийн засгийн идэвхи (2000 онд эдийн засгийн идэвхийн талаархи асуултыг 15 ба түүнээс дээш насны хүнээс асуусан. Харин 1989 онд эдгээр асуултыг зөвхөн 16-59 насны эрэгтэй, 16-54 насны эмэгтэйгээс асуусан.)	1. Өнгөрсөн 7 хоногт ажилласан байдал	Асуугаагүй	Асуусан (Та сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн үү?)	2000 онд энэ асуултыг тухайн хүн тухайн үед ажиллаж байгаа эсэхийг мэдэх зорилгоор асуусан. (Үүнээс гадна тухайн хүн ажлаасаа түр хугацаагаар чөлөөлөгдсөн эсэхийг мэдэх зорилгоор нэмэлт лавлагаа авахыг тоологч нарт зааварласан.)
	2. Эрхэлдэг ажил	Асуусан	Асуусан	Ижил төрлийн асуулт асуусан. Гэхдээ 2000 оны ангилалд өөрчлөлт орсон.
	3. Нийгмийн гарал, үүсэл /анди	Асуусан	Асуугаагүй	Ийм ойлголт үгүй болсон тул шаардлагагүй гэж үзсэн.
	4. Орлогын эх үүсвэр	Асуусан	Асуугаагүй	Шаардлагагүй гэж үзсэн.
	5. Эдийн засгийн үйл ажиллагаа	Асуусан (ажлын газар)	Асуусан (үйл ажиллагааны чиглэл)	1989 онд ажлын газар, суралцдаг сургууль гэж асуужээ. 2000 онд аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг асуусан. Гэхдээ ангилалд өөрчлөлт орсон.
	6. Ажил эрхлэлтийн байдал	Асуугаагүй	Асуусан	2000 онд гэрээгээр ажиллагч, ажил олгогч, хувиараа ажиллагч, хоршоолын гишүүн, гэр булийн бизнест цалин авалгүй оролцогч, бусад гэж асуусан.
Төрөлт	Төрүүлсэн хүүхдийн нийт тоо болон амьд байгаа хүүхдийн тоо	Асуусан	Асуугаагүй	ҮСГ нь 1998 онд ХАНҮЭМС явуулсан тул 2000 оны тооллогоор төрөлтийг тооцохыг зориогүй.

Энэ удаагийн тооллогын хуудас **Хавсралт 3-т** өгөгдсөн.

## Бүлэг 2.

## ХҮН АМЫН ТОО, СУУРЬШИЛТ, НЯГТРАЛ

Монгол Улсын хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор тус улсын байнга оршин суудаг хүн ам (суурин хүн ам)-ыг тоолсон. Байнга суудаг хүн амыг байнга оршин суугч болон түр эзгүй хүн амын нийлбэрээр тооцсон бөгөөд үүнд тооллогын үед гадаадад 6 сараас дээш хугацаагаар амьдарч байсан зарим хүмүүсийг түр эзгүй гэж оруулсан болно. (Ойлголт, тодорхойлолтуудыг **Бүлэг 1**-ээс харна уу.)

Хүн амын тоо төрөлт, нас барагт, шилжих хөдөлгөөнөөр тодорхойлогддог. Монгол Улсын хүн амын нягтрал газар зүйн бүс нутгаар нилээд ялгаатай байна. Улс төр, соёл, түүх, засаг захиргаа, цаг агаар, газар зүй зэрэг олон хүчин зүйлс хүн амын суурьшилт, мөн үүнээс үүдээд хүн амын нягтралд нөлөөлжээ. Монгол Улсын хүн амын нягтралд хамгийн чухал нөлөө үзүүлсэн хүчин зүйлст шилжих хөдөлгөөн, засаг захиргааны төвийг бий болгох, хил хязгаарыг тогтоох, уламжлалт зан заншил, байгаль орчны нөхцөл орно.

### Хүн амын тоо, хүйсийн харьцаа

2000 оны 1-р сарын 5-ны байдлаар 2373493 хүн Монгол Улсын байнгын оршин суугчаар тоологдоны дотор 1177981 нь эрэгтэйчүүд, 1195512 нь эмэгтэйчүүд байна. 1989 оны тооллогоор суурин хүн амын тоо 2043954 байв. 1989-2000 оны хоорондох 11 жилд хүн ам 16,1 хувиар өссөн нь жилийн дундаж өсөлт нь 1,4 хувь болж байна. Өсөлтийн энэ хувь урд өмнөх тооллого хоорондын өсөлтийн хувьтай харьцуулахад ихээхэн доогуур байгаа юм. 1956 оноос хүн амын жилийн дундаж өсөлт огцом нэмэгдэж, 1989 он хүртэл жилийн дундаж өсөлт 2.5 хувиас дээш байлаа. Одоогийн энэ өсөлтийн хувь 1944 оноос хойшхи хугацаанд хамгийн бага нь юм. Хүн амын өсөлтийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл **Бүлэг 3**-т байгаа.

**Хүснэгт 2.1**-ээс харахад хүйсийн харьцаа (100 эмэгтэйд ногдох эрэгтэй) бага багаар буурч байгаа бөгөөд энэ нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад илүү байгааг харуулж байна. Гадаад шилжин явагсдын дунд эрэгтэйчүүд давамгайлж байгаагаас хүйсийн харьцааны бууралт нь зарим талаар шалтгаалсан байж болно. Гэхдээ гадаадад шилжин явагсдыг 2000 оны тооллогоор гаргаагүй болно.

**Хүснэгт 2.1. Монгол Улсын хүн ам, 1918-2000 оны хүн амын тооллогоор**

Тооллого явагдсан он	Хүн ам (мян.хүн)			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
1918	647.5	330.2	317.3	104.1
1935	738.2	370.8	367.4	100.9
1944	759.1	371.3	387.8	95.7
1956	845.5	420.3	425.2	98.8
1963	1017.1	508.0	509.1	99.8
1969	1197.6	597.4	600.2	99.5
1979	1595.0	798.9	796.1	100.4
1989	2044.0	1020.7	1023.3	99.7
<b>2000</b>	<b>2373.5</b>	<b>1178.0</b>	<b>1195.5</b>	<b>98.5</b>

## Хүн амын суурьшилт

Газар зүйн бүс болон засаг захиргааны нутаг, дэвсгэрт хөгжлийн түвшин ихэнхи тохиолдолд тэгш бүс байдаг. Хүн амын суурьшилтын судалгаа нь хүн амын байршил, хүн амын суурьшлын хот, хөдөөгийн шинж төрх, бүс нутгийн хүн амын нягтралыг тодорхойлсноор төлөвлөгчид, бодлого боловсруулагч наарт нэн чухал мэдээлэл өгдөг. Иймээс хүн амын суурьшлын судалгаа нь тухайн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн байдлыг цаашид гүнзгийрүүлэн судалж, бүс нутгийн болон орон нутгийн хэмжээний тохиромжтой бодлого боловсруулах үндэс болно.


Хүн амын суурьшилтыг **Зураг 2.1**-д харуулав. Ерөнхийд нь авч үзвэл Өмнөд болон Зүүн бүс нутгийг бодвол Улаанбаатар хот, Төвийн болон Баруун бүс нутагт хүн ам илүү нягт суурьшсан байна. Нийт хүн амын бараг гуравны нэг нь Улаанбаатар хотод, 60-аас илүү хувь нь Төвийн бүс нутагт (Улаанбаатар хот ороод) амьдарч байна. Хүн амын нягтрал арай өндөр нутагт Улаанбаатар хотоос гадна Дархан-Уул, Орхон, Архангай, Өвөрхангай аймаг, мөн Төв болон Сэлэнгэ аймгийн төмөр зам дайрч гардаг харьцангуй хөгжсөн газар багтаж байна. Нийт хүн амын бараг 18 хувь нь Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Баянхонгор аймгуудыг багтаасан Баруун бүс нутагт амьдарч байна. Харин нийт хүн амын 20-иос бага хувь нь хүн ам сийрэг суурьшсан Өмнөд болон Зүүн бүс нутагт амьдарч байна.

### Бүс нутгийн ангилал\*

<b>Төвийн бүс</b> Хөвсгөл,	- Архангай, Булган, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв,
<b>Зүүн бүс</b>	Дархан-Уул, Орхон
<b>Баруун бүс</b>	- Дорнод, Сүхбаатар, Хэнтий
	- Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Завхан,


\*Энэхүү ангилалыг 1998 онд явагдсан Хүн амын нэхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын мэдээллийг судлах зориулалтаар ашигласан болно.

Зураг 2.1. Хүн амын суурьшилт, 2000 он



Нийслэл хот, Төвийн бус нутагт хүн ам харьцангуй шигүү суурьшсан нь дараах зургаас (**Зураг 2.2**) илүү тодорхой харагдаж байна. Улаанбаатар хот бол хамгийн том хот бөгөөд Монгол Улсын хүн амын 32 хувь буюу 3 хүн тутмын нэг нь байнга оршин суудаг газар болжээ. Өөр ямар ч аймагт нийт хүн амын 5-аас илүү хувь оршин суухгүй байна. Нийслэл хотоос гадна Хөвсгөл, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Архангай аймаг хамгийн олон хүн амтай байгаа бөгөөд бүгд Төвийн бусэд оршдог. Харин хүн амынхаа тоогоор хамгийн бага аймагт Говьсүмбэр, Өмнөговь, Дорнговь, Дундговь зэрэг Өмнөд бусэд багтдаг аймгууд орж байна.

**Зураг 2.2. Нийт хүн амд аймаг, нийслэлийн хүн амын эзлэх хувь, 1989, 2000\* он**



\*Эх үүсвэр: Хүснэгт 2.5.

\*\*Говьсүмбэр 1994 онд Дорнговь аймгаас тасарч байгуулагдсан.

Сүүлийн хоёр, гурван арван жилд Монгол Улс улам бүр хотжих шинж чанартай болж, хотжилт нэмэгдсээр байна. Бусад улс орны нэг адил Монгол Улс хөдөө аж ахуйгаас үйлдвэржилт рүү шилжих үйл явцын улмаас нийслэл хот болон бусад томоохон хот, суурин газрын хөгжиж байгаа нь хүн амын суурьшилтад хүчтэй нөлөө үзүүлэв. Эдгээр хот, суурин газар нь эрүүл мэнд, боловсрол болон бусад үйлчилгээ, хамгийн гол нь ажлын байр бий болгох төв болж, бусад газраас хүмүүсийг татаж, хотжилтын үйл явцыг улам бүр өргөжүүлсээр байна.

2000 онд нийт хүн амын 57 хувь буюу 1345 мянган хүн хотод, өөрөөр хэлбэл нийслэл Улаанбаатар хот, 21 аймгийн төв, 22 тосгонд (**Бүлэг 1-д** тодорхойлолт өгөгдсөн) амьдарч байна.

Аймгууд хотжилтын түвшний хувьд хоорондоо нилээд ялгаатай байна. Хотын дэд бүтэц, жишээлбэл янз бүрийн түвшний сургууль, үйлдвэр, харилцаа холбоо аймагт илүү хөгжиж, тооллого хоорондын хугацаанд шилжигсдийн сонирхлыг

татаж, аймгийн хүн амд хотын хүн амын эзлэх хувийн жинг өсгөжээ. Хамгийн хотжилт өндөртэй аймгуудад төмөр замын дагуу Орхон, Дархан-Уул, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дорнод аймгууд орж байгааг харж болно. 2000 оны байдлаар эдгээр аймгийн хүн амын талаас илүү хувь нь хотод амьдарч, хотжих үйл явц үргэлжилж байгааг харуулж байна.

Хамгийн олон хүн амтай бус нутаг заавал хотжилт хамгийн өндөртэй байх алbagүй юм. Хүн ам ихтэй Архангай, Өвөрхангай зэрэг аймгийн хүн амын 80 гаруй хувь хөдөөд амьдарч байна. Энэ нь эдгээр аймгийн байгаль, нутаг дэвсгэрийн таатай нөхцөлтэй холбоотой бөгөөд эдгээр аймаг төмөр зам байхгүй юм. Төв аймаг өөрийн гэсэн онцлогтой. Нийслэл хот өргөжих тутам түүний хил хязгаар өөрчлөгдсөн ч Төв аймгийн хөдөөгийн шинж төрх хэвээрээ хадгалагдсан байна.

**Хүснэгт 2.2. Монгол Улсын хот, хөдөөгийн хүн ам, аймаг,  
нийслэлээр, 2000 он**

Аймаг, нийслэл	Хот		Хөдөө	
	Хүн ам	Эзлэх хувь	Хүн ам	Эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>1344516</b>	<b>56.6</b>	<b>1028977</b>	<b>43.4</b>
Улаанбаатар	760077	100.0	-	-
Орхон	68310	95.5	3215	4.5
Дархан-Уул	65791	79.0	17480	21.0
Говьсүмбэр	8983	73.5	3247	26.5
Сэлэнгэ	56446	56.5	43504	43.5
Дорнод	41714	55.3	33659	44.7
Дорноговь	25210	49.8	25365	50.2
Хэнтий	27853	39.3	43093	60.7
Баян-Өлгий	28060	30.8	63008	69.2
Өмнөговь	14183	30.3	32675	69.7
Ховд	26023	30.0	60808	70.0
Увс	26319	29.2	63718	70.8
Говь-Алтай	18023	28.3	45650	71.7
Дундговь	14517	28.2	37000	71.8
Завхан	24276	27.0	65723	73.0
Сүхбаатар	15133	26.9	41033	73.1
Хөвсгөл	31489	26.4	87574	73.6
Булган	16239	26.3	45537	73.7
Баянхонгор	22066	26.0	62713	74.0
Архангай	18519	19.1	78572	80.9
Өвөрхангай	19058	17.1	92362	82.9
Төв	16227	16.3	83041	83.7

40000-с дээш хүн амтай дөрвөн хотод 2000 оны байдлаар нийтдээ 936 мянган хүн буюу нийт хүн амын 39 хувь нь амьдарч байна. Энд Улаанбаатар (760 мянга), Эрдэнэт (68 мянга), Дархан (66 мянга), Чойбалсан (42 мянга) орж байгаа юм.

Хүн амын тооллого нь хүн амын тоо, хотжилтын хоорондын ярвигтай харилцааг харуулж байна. Хэдийгээр хүн амын суурьшилт сийрэг, цөөн хүн амтай боловч Зүүн бүс нутаг нь Улаанбаатар хотын зэрэгцээ хотжилт хамгийн өндөртэй бүс нутаг болж байна. Баруун бүс нутаг харьцангуй олон хүн амтай, суурьшлын хувьд тийм сийрэг биш ч гэсэн хотжилтоор хамгийн доогуур байна. Төвийн болон Өмнөд бүс нутаг хүн амын тоо болон суурьшлын төрхөөрөө өөр хоорондоо адилгүй ч, хотжилтын түвшингээрээ адил байна. Аймгууд хот, суурин газар шинж чанарын хувьд нэлээд ялгаатай байгаа бөгөөд түүнд тодорхой тайлбар болохуйц шалтгаан байгаа юм. Төвийн бүсийн томоохон аймгийн төв, хот, суурин газраас Өмнөд болон Зүүн бүс нутгийн дэд бүтэц болон бусад нөхцөл муутай жижиг аймгийн төв, тосгон ялгаатай байгаа юм. Жишээлбэл, Өмнөговь, Дорноговь, Дундговь аймгийн төвийн хүн ам аймгийнхаа нийт хүн амын 28-аас илүү хувийг бүрдүүлж байна. Эдгээр аймгийн төвүүд хотод хамрагддаг ч нөхцөл, бололцооны хувьд нийслэл хот болон бусад том хоттой адил байж чадахгүй байна.

**Хүснэгт 2.3. Хот, хөдөөгийн хүн ам, бүс нутгаар, 2000 он**

Бүс нутаг	Хот		Хөдөө		
	Хот, тосгоны тоо	Хүн ам, мян.хүн	Тухайн бүсийн хүн амд эзлэх хувь	Хүн ам, мян.хүн	Тухайн бүсийн хүн амд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>44</b>	<b>1344.5</b>	<b>56.6</b>	<b>1029.0</b>	<b>43.4</b>
Төв	16	292.0	39.3	451.3	60.7
Зүүн	8	84.7	41.8	117.8	58.2
Баруун	12	144.8	28.6	361.6	71.4
Өмнөд	7	62.9	39.0	98.3	61.0
Улаанбаатар	1	760.1	100.0	-	-

**Хүн амын нягтрал**


2000 онд Монгол Улсын нэг квадрат километр нутаг дэвсгэрт 1.5 хүн ногдож (хүн амын нягтрал), Монгол Улс дэлхийн хамгийн сийрэг суурьшилтай орнуудын тоонд орж байна.

**Хүснэгт 2.4. Хүн амын нягтрал, бүс нутгаар, 2000 он**

Бүс нутаг	Хүн ам		Нутаг дэвсгэр		1 км <sup>2</sup> -т ногдох хүн
	мян. хүн	Эзлэх хувь	мян.км <sup>2</sup>	Эзлэх хувь	
<b>Монгол Улс</b>	<b>2373.5</b>	<b>100.0</b>	<b>1564.2</b>	<b>100.0</b>	<b>1.5</b>
Төвийн	743.3	31.3	386.8	24.7	1.9
Зүүн	202.5	8.5	286.2	18.3	0.7
Баруун	506.4	21.4	531.3	34.0	1.0
Өмнөд	161.2	6.8	355.1	22.7	0.5
Улаанбаатар	760.1	32.0	4.7	0.3	161.7

Монгол Улсын хувьд Улаанбаатар хот хүн амын нягтралаараа хамгийн өндөр юм. **Хүснэгт 2.4-өөс** харахад Улаанбаатар хотын нэг квадрат километр нутаг дэвсгэрт 162 хүн ногдож байна. Улаанбаатар хотын хүн амын нягтрал өндөр гэдгийг харуулж байгаа өөр нэг зүйл бол Улаанбаатар хот Монгол Улсын бүх нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг атлаа хүн амын 32 хувь нийслэл хотод амьдардаг юм. Бусад бүс нутгийн хүн амын нягтрал харьцангуй сийрэг байгаа ч хоорондоо нилээд ялгаатай. Ерөнхийдөө Монгол Улсын Төвийн болон Баруун бүс нутаг Өмнөд болон Зүүн бүс нутгийг бодвол харьцангуй нягтрал ихтэй байна. Жишээлбэл, Төвийн бүс нутаг хот, хот маягын суурин олонтой, хүн амын нягтралаараа хамгийн өндөр бөгөөд нэг квадрат километр нутагт 1.9 хүн ногдож байна. Энэ нь нягтралаараа түүний дараагийн байранд орж, нэг квадрат километр нутагт нь нэг хүн ногдож байгаа Баруун бүс нутгаас хоёр дахин их байна. Хүмүүсийн сонирхолыг бага татдаг Зүүн, Өмнөд бүс нутагт нягтрал сийрэг, нэг квадрат километрт нэг хүн ч ногдохгүй байна.

### Зураг 2.3. Хүн амын нягтрал, аймаг, нийслэлээр, 2000 он



### Эх үүсвэр: Хүснэгт 2.5.

Аймгийн түвшний хүн амын нягтрал нь суурьшлын нэн сонирхолтой дүр төрхийг харуулж байна. Улаанбаатар хотоос гадна Орхон (нэг квадрат километрт 85 хүн), Дархан-Уул аймгийн (нэг квадрат километрт 25 хүн) нягтрал бусад аймгаас хамгийн өндөр байна. Хотжилтын түвшин нь аймаг, нийслэл хот доторхи асар их ялгааг далдалж байгаа нь мэдээж юм.

Хүн амын нягтралаар дээрх хот, аймгийн дараа тэдгээртэй харьцуулахад хамаагүй бага нягтралтай, нэг квадрат км нутаг дэвсгэрт 2.4 хүн ногдож байгаа Сэлэнгэ аймаг орж байна. Өмнө тэмдэглэснээр Сэлэнгэ аймгийн нутгаар төмөр зам дайран өнгөрдөг бөгөөд энд хотжилт өссөөр байгаа юм. Архангай, Эвөрхангай аймгууд хүн амын нягтралаар улсын дунджаас дээгүүр байна. Говьсүмбэр аймгийн хүн амын нягтрал дээрх хотуудтай харьцуулахад тийм өндөр биш ч газар нутгийн хувьд жижиг учраас дунджаас дээш нягтралтай

байна. Казах үндэстэн голлон оршин суудаг Баян-Өлгий аймгийн хүн амын нягтрал мөн дунджаас дээгүүр байна. Харин Зүүн болон Өмнөд бус нутагт орших Өмнөговь, Дорноговь, Дорнод болон Баруун бүсийн Говь-Алтай аймагт хүн амын нягтрал хамгийн сийрэг, нэг квадрат километр нутаг дэвсгэрт нэг хүн ногдохгүй байна.

### Хүн амын нягтралын өөрчлөлт, 1989, 2000 он

Монгол Улсын хүн амын нягтрал 1989 онд нэг квадрат километр нутаг дэвсгэрт 1.3 хүн ногдож байсан бол 2000 онд 1.5 болж өссөн байна. Үндэсний түвшинд ийнхүү гарсан өөрчлөлтөд хүн амын ердийн цэвэр өсөлт болон гадаад шилжих хөдөлгөөн нөлөөлсөн юм. **Хүснэгт 2.5**-д үзүүлсэн хүн амын нягтралын өөрчлөлтөд дээр дурдсан хүчин зүйлсээс гадна дотоод шилжих хөдөлгөөн нөлөөлсөн байна. Үүнийг Улаанбаатар хот, Орхон аймгийн 1989, 2000 оны тооноос харж болно. 1989-2000 оны хооронд Улаанбаатар хотын хүн амын нягтрал 39 хувь, Орхон аймгийнх 27 хувиар тус тус өсчээ. Улаанбаатар хот, Орхон аймгийн хүн амын нягтралын энэ өсөлт тооллого хоорондын хүн амын өсөлтөөс харьцангуй өндөр байгаа нь эдгээр аймаг, хотод хүмүүс бусад аймгаас шилжиж ирж байнсныг харуулж байна. Дотоод шилжих хөдөлгөөний талаархи бүлэг энэ тайлбарыг баталж, тэнд сүүлийн үеийн шилжих хөдөлгөөний чиглэл, дүр төрх, түвшингийн талаар илүү тодорхой бичигдсэн болно.

**Хүснэгт 2.5. Хүн амын тоо болон нягтрал, аймаг, нийслэлээр, 1989 болон 2000 он**

Аймаг, нийслэл	1989			2000		
	мян.хүн	Дүнд эзлэх хувь	Хүн/km <sup>2</sup>	мян.хүн	Дүнд эзлэх хувь	Хүн/km <sup>2</sup>
<b>Монгол Улс</b>	<b>2044.0</b>	<b>100.0</b>	<b>1.3</b>	<b>2373.5</b>	<b>100.0</b>	<b>1.5</b>
Архангай	84.5	4.1	1.5	97.1	4.1	1.8
Баян-Өлгий	90.9	4.4	2.0	91.1	3.8	2.0
Баянхонгор	74.6	3.6	0.6	84.8	3.6	0.7
Булган	51.9	2.5	1.1	61.8	2.6	1.3
Говь-Алтай	62.8	3.1	0.4	63.7	2.7	0.5
Дорноговь	57.1	2.8	0.5	50.6	2.1	0.5
Дорнод	81.1	4.0	0.7	75.4	3.2	0.6
Дундговь	49.3	2.4	0.7	51.5	2.2	0.7
Завхан	88.5	4.3	1.1	90.0	3.8	1.1
Өвөрхангай	96.5	4.7	1.5	111.4	4.7	1.8
Өмнөговь	42.4	2.1	0.3	46.9	2.0	0.3
Сүхбаатар	50.8	2.5	0.6	56.2	2.4	0.7
Сэлэнгэ	87.0	4.3	2.1	100.0	4.2	2.4
Төв	100.1	4.9	1.4	99.3	4.2	1.3
Увс	84.0	4.1	1.2	90.0	3.8	1.3
Ховд	76.6	3.7	1.0	86.8	3.7	1.1
Хөвсгөл	101.8	5.0	1.0	119.1	5.0	1.2
Хэнтий	73.8	3.6	0.9	70.9	3.0	0.9
Дархан-Уул	85.7	4.2	26.1	83.3	3.5	25.4
Улаанбаатар	548.4	26.8	116.7	760.1	32.0	161.7
Орхон	56.1	2.7	66.8	71.5	3.0	85.1
Говьсүмбэр	-	-	-	12.2	0.5	2.2

---

Ийм томоохон хот, суурин газарт чиглэсэн шилжих хөдөлгөөний шууд үр дүнд хотжилт багатай олон аймгийн хүн амын өсөлт улсын дунджаас доогур байна. **Хүснэгт 2.5-аас** харахад хүн ам нь олноор шилжин явж байгаа аймгуудын хүн амын нягтрал өнгөрсөн хугацаанд маш бага өсч зарим аймагт буурсан байна.


### Бүлэг 3.

### ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

#### Хүн амын өсөлт

Тооллого хоорондын хүн амын өсөлт нь тухайн үеийн улс төр, нийгмийн байдалтай ихээхэн холбоотой байлаа. 1918-1935, 1935-1944 оны тооллого хоорондын хүн амын өсөлт бага байгаа нь дотоод, гадаадад болсон хэд хэдэн дайн, тулалдаан болон хүн амын дунд тархсан өвчлөлтэй холбоотой нас баралт ихэсч, төрөлт буурсан, хувьсгал, дотоодын тэмцэл, хөдөлгөөний үеэр хүн амын зарим хэсэг гадаадад дүрвэн гарсан, 1930-аад оны их хэлмэгдүүлэлтэд олон мянган хүн амь наасаа алдсан зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой юм. 1956-аас 1989 оны хооронд хүн амын жилийн дундаж өсөлт 2.5-3.0 хувь байж, харьцангуй бага хэлбэлзэж байв. Харин 1989-2000 оны тооллого хоорондын хүн амын жилийн дундаж өсөлт 1.4 хувь болсон нь өмнөх 10 жилийнхээс 1.1 пүнктээр буурчээ.

**Зураг 3.1. Хүн амын жилийн дундаж өсөлт, хувиар, 1918-2000 оны тооллогоор**



Монгол Улсад 1989-2000 онд гарсан хүн ам зүйн өөрчлөлтүүд өвөрмөц онцлогтой бөгөөд тооллогоос гадна нарийн судалгаа шаардана. Хүн амын өсөлтөд нөлөөлдөг гол хүчин зүйлс нь хүн амын ердийн цэвэр өсөлт, гадаад шилжих хөдөлгөөн байдаг. 1989 оноос төрөлт буурч, 1000 хүнд ногдох төрөлтийн түвшин 1989 онд 36.5 байсан бол 1999 онд 20.4 болж, 40 гаруй хувиар буурчээ. Хүн амын төрөлт ихээхэн буурсан нь шилжилтийн үеийн эдийн засгийн хүндрэл бэрхшээл, хүн амын амьжиргааны түвшиний доройтол, эмэгтэйчүүд жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийг өргөн ашигладаг болсон түүнчлэн 1990 оны эхээр хуучин хуулиар хатуу хяналтын дор хийгддэг байсан үр хөндөлтийг чөлөөтэй болгосон зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой. Харин энэ хугацаанд гадаад шилжих хөдөлгөөн нэмэгдэж 1989 онд Монгол Улсад ажиллаж, амьдарч байсан хуучин Зөвлөлт Холбоот Улсын 50 гаруй мянган иргэн

нутаг буцаж, 1992 оноос 60 гаруй мянган казах иргэд Казахстан Улсад хөдөлмөрийн гэрээтэй ажиллахаар шилжин суурьшсаны зэрэгцээ олон мянган залуучууд гадаадад гарч хөдөлмөр эрхэлж, суралцах болсонтой холбоотой. Сүүлийн 11 жилд Монгол Улсын нийгэм, эдийн засагт гарсан өөрчлөлтөөс шалтгаалан бий болсон эдгээр өөрчлөлт нь тооллого хоорондын хүн амын жилийн дундаж өсөлтөд нөлөөлж байгаа гол хүчин зүйл болж байгаа юм.


**Хүснэгт 3.1-т** 1979-1989, 1989-2000 оны хүн амын жилийн дундаж өсөлтийг аймаг, нийслэлээр харуулав. Тооллого хоорондын хүн амын жилийн дундаж өсөлт аймгаар харьцангуй их ялгаатай байгаа бөгөөд энэ ялгааны дүр төрх 1989-2000 онд 1979-1989 оныхоос өөр байна.

Аймаг, нийслэл	1989/1979		Жилийн дундаж өсөлт (%)	
	2000/1989 (%)	1979-1989 (%)	1979-1989	1989-2000
<b>Бүгд</b>	<b>128.2</b>	<b>116.1</b>	<b>2.51</b>	<b>1.37</b>
Архангай	109.0	114.9	0.86	1.27
Баян-Өлтий	127.5	100.2	2.46	0.02
Баянхонгор	118.4	113.7	1.70	1.17
Булган	122.9	119.0	2.08	1.59
Говь-Алтай	112.4	101.4	1.17	0.13
Дорнговь	137.2	88.6	3.22	-1.10
Дорнод	138.5	93.0	3.31	-0.66
Дундговь	126.9	104.5	2.41	0.40
Завхан	110.7	101.7	1.03	0.15
Өвөрхангай	117.1	115.4	1.59	1.31
Өмнөговь	128.9	110.4	2.57	0.90
Сүхбаатар	117.8	110.5	1.65	0.91
Сэлэнгэ	136.7	114.9	3.17	1.27
Төв	125.3	99.2	2.28	-0.07
Увс	116.7	107.2	1.55	0.64
Ховд	122.3	113.4	2.04	1.15
Хөвсгөл	115.1	116.9	1.41	1.43
Хэнтий	141.8	96.1	3.55	-0.36
Дархан-Уул	192.4	97.1	6.77	-0.26
Улаанбаатар	142.6	138.6	3.61	3.01
Орхон	356.0	127.4	13.54	2.23
Говьсүмбэр	-	-	-	-

1989-2000 онуудын хүн амын жилийн дундаж өсөлтийг өмнөх 10 жилийнхтэй харьцуулахад зөвхөн Архангай (0.86-гаас 1.27), Хөвсгөл (1.41-ээс 1.43) аймагт нэмэгджээ.

Бусад аймаг, Улаанбаатар хотын хувьд хүн амын жилийн дундаж өсөлт буурсан байна. Өөрөөр хэлбэл, эдгээр аймгийн хүн ам 1989-2000 онд нэмэгдсэн хэдий ч 1979-1989 оныхтой харьцуулахад өсөлтийн хувь доогур байжээ. Харин Дорноговь, Дорнод, Төв, Хэнтий, Дархан-Уул зэрэг таван аймгийн хүн ам 1989-2000 онд буурсан байна.

**Зураг 3.2. Аймаг, нийслэлийн хүн амын жилийн дундаж өсөлт,  
хувиар, 1989-2000 он**



Зураг 3.2-оос харахад сүүлийн 11 жилд аймаг, нийслэлийн хүн амын өсөлтөд шилжих хөдөлгөөн голлох нөлөө үзүүлсэн нь харагдаж байна. Улаанбаатар хот, Орхон, Булган, Хөвсгөл аймгуудын хүн амын жилийн дундаж өсөлт улсын дунджаас дээгүүр байна. Ялангуяа Улаанбаатар хот, Орхон аймгийн хүн амын жилийн дундаж өсөлт сүүлийн 11 жилд улсын дунджаас 1.6-2.2 дахин их байгаа нь эдгээр томоохон хот суурин газар уруу шилжин суурьших явдал нэмэгдснийг харуулж байна. Энэ хугацаанд шилжих хөдөлгөөнөөс гадна хүн амын өсөлтийг тодорхойлдог төрөлт, нас бааралт аймаг, нийслэлээр их ялгаагүй байв. Харин Дорноговь аймгийн хүн ам сүүлийн 11 жилд, жилд дунджаар 1.1 хувиар буурсан байна. Мөн Баян-Өлгий (0.02%), Говь-Алтай (0.13%), Завхан (0.15%) аймгуудын хүн ам сүүлийн 11 жилд бараг өсөөгүй байна. Энэ нь 1989 оноос хойш хүн амын дотоод болон гадаад шилжих хөдөлгөөн нэмэгдэж эдгээр аймгуудаас олон тооны хүмүүс шилжин явсантай холбоотой юм.

Шилжих хөдөлгөөний талаархи дэлгэрэнгүй мэдээллийг **Бүлэг 5-аас** харна уу.

### Хүн амын нас, хүйсний бүтэц

**Хүснэгт 3.2-д** хүн амын нас, хүйсний бүтцийг харуулав. 2000 оны тооллогоор гарсан насны бүтцийн хамгийн онцгой шинж бол 0-4 болон 5-9 насны хүн амын тоо 10-14 насны хүн амтай харьцуулахад буурсан явдал юм.

Хүйсийн харьцаа нас дээшлэх тутам мэдэгдэхүйцээр буурч байгаа нь зүй ёсны үзэгдэл бөгөөд тооллогын мэдээллийн чанар сайн байгааг харуулж байна. Дэлхийн хүн ам зүйн олон жилийн судалгааны үр дүнгээс үзэхэд төрөх үеийн хүйсийн харьцаа аль ч оронд 104-106 хооронд байдаг зүй тогтолтой. Үүнтэй харьцуулахад 0-4 насны бүлэгт хүйсийн харьцаа 102 байгаа нь харьцангуй доогур байна. Үүнийг амьдралын эхний жилүүдэд эрэгтэй хүүхдийн нас баралт илүү байдагтай холбон тайлбарлаж болох юм. Насны бүтцийг нарийн ажиглавал энэ дүгнэлтийг баталж байна (**Хавсралт 1-ийн Хүснэгт 1-ийг хар**). **Тооллогоос төрөлтөд** хамгийн ойрхон нас бол нэг хүртэлх нас бөгөөд энэ насанд хүйсийн харьцаа 104 байгаа нь төрөх үеийн хүйсийн харьцаатай ойролцоо байна. Хүйсийн харьцаа нэг настайд 104, 1-4 настайд 102 болж буурч, ихэнхи насанд нийтлэг зүй тогтолтой тохирсон үзүүлэлт гарч байна (**Хавсралт 1-ийн**

**Хүснэгт 3.2. Хүн амын нас, хүйсний бүтэц, хүйсийн харьцаа, мян.хүн, 2000 он**


Насны бүлэг	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Хүйсийн харьцаа <sup>1</sup>
<b>Бүгд</b>	<b>1178.0</b>	<b>1195.5</b>	<b>2373.5</b>	<b>98.5</b>
0-4	124.5	121.5	246.0	102.4
5-9	144.3	141.4	285.7	102.1
10-14	159.3	158.1	317.4	100.8
15-19	133.3	130.0	263.3	102.5
20-24	118.0	117.7	235.7	100.3
25-29	108.0	108.7	216.7	99.4
30-34	92.5	95.4	187.9	97.0
35-39	84.8	87.8	172.6	96.6
40-44	62.6	64.6	127.2	96.9
45-49	40.6	42.3	82.9	96.0
50-54	27.7	30.1	57.8	92.0
55-59	27.4	28.5	55.9	96.1
60-64	20.8	21.5	42.3	96.7
65-69	16.0	19.4	35.4	82.5
70+	18.2	28.5	49.7	64.0

<sup>1</sup> 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо  
**Хүснэгт 1-ийг хар**.


Хүйсийн харьцаа нас дээшлэх тутам буурч байгаа нь эрэгтэйчүүдийн дунд нас баралт харьцангуй илүү байгаагийн үр дүн бөгөөд үүнийг өндөр насны бүлэгт, жишээлбэл 70, түүнээс дээш насанд хүйсийн харьцаа 64 болж огцом буурч байгаагаас харж болно. Хүснэгтэд өндөр насны бүлгийг задалж үзүүлсэн бол нас улам бүр дээшлэх тутам хүйсийн харьцаа тогтмол буурч байгаа нь харагдах юм. Насны бүлэг дэх хүйсийн харьцаа нь төрөх үеийн хүйсийн харьцаа, нас баралтаас гадна хүйсийн ялгаатай шилжих хөдөлгөөнөөс мөн шалтгаалж байгаа. Гадаад шилжих хөдөлгөөний цар хүрээ ихсэж байгаа хэдий ч хүйсийн харьцааны өөрчлөлтөд гол нөлөө үзүүлэхүйц хэмжээнд хүрээгүй юм. **Хавсралт 1-ийн Хүснэгт 2-т** хүн амын нас, хүйсний бүтцийг аймаг, нийслэлээр харуулав.

Насны бүтэц өөрөө төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний өөрчлөлтийн түвшингийн үр дүн юм. Эрэгтэй, эмэгтэй хүн амын бүтцийг **Зураг 3.3-оос** (суврагатай адил хэлбэртэй тул энэ зургийг хүн амын суврага гэж нэрлэдэг) харж болно.

### Зураг 3.3. Хүн амын нас, хүйсний суврага, 1989, 2000 оны тооллогоор



тооллогоор



Үнэн хэрэгтээ 15-аас доош насны бүлэг дэх өөрчлөлтөөс шалтгаалж 2000 оны тооллогын суврага нь суврага хэлбэрээ алдсан байна. Өндөр наснаас 15-19 насны бүлэг хүртэл суврага өргөсч, таван насны үелрэл нэг бүр дэх хүн ам өсч байгааг харуулж байна. Харин өнгөрсөн 15 жилд

суврагын суурь мэдэгдэхүйц нарийссан байна. Энэ нь төрөлт тогтмол буурч байгаагын үр дүн бөгөөд төрөлтийг тооллогоор биш харин саяхан явагдсан ХАНУЭМС-гаар судалсан.

Суврагад хамрагдаж байгаа хугацааны ихэнхид төрөлт өндөр байсан, тиймээс ч суврага дээшлэх тутам нарийсч байгаа нь зөвхөн төрөлтийн нөлөө төдийгүй мөн нас нэмэгдэх тутам нас баралт өсч байгаагаас шалтгаалж байна. Суврагын дээд хэсэгт төрөлтийн түвшин, шилжих хөдөлгөөний нөлөөлөх нөлөө нь нялхас, залуучуудын хүйсийн харьцаанд нөлөөлж байгаатай харьцуулахад бага юм. Ерөнхийд нь тэмдэглэхэд суврагын 40, түүнээс дээш насан дахь хэлбэр нь дээр тэмдэглэсэн хүчин зүйлсээс хамаарч байгаа ч эдгээр насны хүн амын нас баралтыг харуулж байна. Бидний өмнө тэмдэглэнээр өндөр насны эмэгтэйчүүдийн нас баралт эрэгтэйчүүдийнхээс харьцангуй бага байна. Энэ нь өндөр насанд суврагын эмэгтэйчүүдийн тал эрэгтэйчүүдийнхийг бодвол арай бага

### Хүснэгт 3.3. Хүн амьн насны бүтэц, хувиар, 1979, 1989, 2000 он

Насны бүлэг	1979	1989	2000
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
0-14	44.3	41.9	35.8
15-64	50.7	54.1	60.7
65+	5.0	4.0	3.5

буурч байгаагаас харагдаж байна.

**Хүснэгт 3.3-д** хүн амын насны бүтцийг сүүлийн 3 тооллогоор харуулав. Энд харагдаж байгаа гол өөрчлөлт нь сүүлийн 30 жилд 15-64 насны буюу хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь тогтвортой нэмэгдэж, харин 0-14 насны хүүхдүүдийн эзлэх хувь буурч байгаа явдал юм.

### Гэрлэлт

### Хүснэгт 3.4. 15, түүнээс дээш насны хүн амьн гэрлэлтийн байдал, 1979, 1989, 2000 он

Гэрлэлтийн байдал	1979		1989		2000	
	Мян.хүн	Дүнд эзлэх хувь	Мян.хүн	Дүнд эзлэх хувь	Мян.хүн	Дүнд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>778.7</b>	<b>100.0</b>	<b>1052.0</b>	<b>100.0</b>	<b>1524.4</b>	<b>100.0</b>
Огт гэр бүл бороогүй	179.8	23.1	265.5	25.3	505.1	33.1
Гэр бүлтэй <sup>1</sup>	509.1	65.4	692.5	65.8	880.4	57.8
Салсан <sup>2</sup>	14.4	1.8	17.1	1.6	41.5	2.7
Бэлбэсэн	75.4	9.7	76.9	7.3	97.4	6.4

<sup>1</sup> баттуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

<sup>2</sup> цуцалсан болон тусгаарласан хүмүүсийг оруулсан.

Монгол Улсад гэрлэлт дэлхийн ихэнхи улс орныхой адил байдаг. Гэрлэхдээ нэг хүнтэй гэрлэдэг, насанд хүрсэн бараг бүх хүмүүс гэр бүл болдог. 50 орчим насны хүн амын зөвхөн гурав орчим хувь огт гэрлэж байгаагүй байна.

эрлэлт бол нийгэм, соёл, уламжлалтай нягт холбоотой үзэгдэл тул тийм хурдан өөрчлөгддөггүй. Түүний үндсэн төрх тооллого хоорондын жилүүдэд хөндөгдөөгүй хэвээр үлдсэн ч улам бүр нарийвчлан үзэхээр олон сонирхолтой үзэгдэл харагдаж байна. Хамгийн мэдэгдэхүйц өөрчлөлт бол огт гэрлээгүй хүмүүсийн эзлэх хувь 1979 онд 23 хувь байснаа 2000 онд 33 хувь болж өсөв. Энэ нь залуучууд хожуу гэрлэдэг болсонтой холбоотой юм. (Хүснэгт 3.6-г хар.) Тэмдэглэн хэлэхэд зүйтэй өөр чухал үзэгдэл бол гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан хүний эзлэх хувь өсч, бэлбэсэн хүн амын эзлэх хувь буурсан явдал юм. **Хүснэгт**

#### **Хүснэгт 3.5. Гэрлэлтийн байдал, хүйсээр, 2000 он**

Гэрлэлтийн байдал	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	Мян.хүн	Дунд эзлэх хувь	Мян.хүн	Дунд эзлэх хувь	Мян.хүн	Дунд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>749.9</b>	<b>100.0</b>	<b>774.5</b>	<b>100.0</b>	<b>1524.4</b>	<b>100.0</b>
Огт гэр бүл бoloогүй	274.4	36.6	230.7	29.8	505.1	33.1
Гэр бүлтэй <sup>1</sup>	438.6	58.5	441.8	57.1	880.4	57.8
Салсан <sup>2</sup>	15.8	2.1	25.7	3.3	41.5	2.7
Бэлбэсэн	21.1	2.8	76.3	9.8	97.4	6.4

<sup>1</sup> батгуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

<sup>2</sup> цуцалсан болон тусгаарласан хүмүүсийг оруулсан.

#### **3.5-д 2000 оны тооллогоор гарсан гэрлэлтийн байдлыг хүйсээр үзүүлэв.**

2000 оны тооллогын үед огт гэр бүл болоогүй эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол харьцангуй залуудаа гэрлэдэг, тиймээс ч анхны гэрлэлтийн нас ялгаатай байдгийг харуулж байна. Анхны гэрлэлтийн дундаж нас гэсэн үзүүлэлтийг гэрлэх үеийн насны хүйсийн ялгаатай байдлыг харуулах зорилгоор тооцов.

#### **Хүснэгт 3.6. Анхны гэрлэлтийн дундаж нас, 1989 болон 2000 он**

Тооллого	Эрэгтэй	Эмэгтэй
1989	23.3	21.1
2000	25.7	23.7

1989, 2000 оны хоёр тооллогод хоёуланд нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн насны ялгаа ойролцоогоор хоёр насны зөрүүтэй байна. 1989 оны тооллогоос хойшхи хугацаанд эрэгтэй, эмэгтэйчүүдийн гэрлэлтийн нас хоёр жил хагасаар нэмэгдсэн байна.

Сүүлийн хорь гаруй жилд салсан, бэлбэсэн хүн амын эзлэх хувь өөрчлөгджэй, 2000 оны тооллогоор эдгээр эзлэх хувь эмэгтэйчүүдийн хувьд эрэгтэйчүүдийг бодвол өндөр болжээ.

Гэрлэх үзэгдэл, гэрлэлтийн байдал амьдралын хугацаа, насжилтын үйл явцтай нягт холбоотой тул гэрлэлтийн дүр төрхийг зөвхөн насаар авч үзсэний үндсэн дээр судлах боломжтой юм. 15-24 насны хүн амын, ялангуяа эрэгтэйчүүдийн дийлэнхи нь гэрлээгүй байна. Нас дээшлэх тутам хүмүүс гэр бүл болж, огт гэр бүл болоогүй хүний эзлэх хувь буурч байна. 65, түүнээс дээш насны бүлэг дэх эрэгтэйчүүдийн нэгээс бага хувь, эмэгтэйчүүдийн нэгээс ялигүй илүү хувь огт гэрлээгүй байна. Гэрлэлтийн байдлын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг (насны бүлэг, хүйс, суурьшилаар) **Хавсралт 1-ийн Хүснэгт 3-аас** харна уу.


Насны бүлэг	Эрэгтэй				Эмэгтэй			
	Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй <sup>1</sup>	Салсан <sup>2</sup>	Бэлбэсэн	Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй <sup>1</sup>	Салсан <sup>2</sup>	Бэлбэсэн
<b>Бүгд</b>	<b>274.5</b>	<b>438.6</b>	<b>15.8</b>	<b>21.1</b>	<b>230.6</b>	<b>441.8</b>	<b>25.7</b>	<b>76.4</b>
15-24	215.0	35.7	0.6	0.1	183.6	62.2	1.6	0.3
25-34	46.2	148.4	5.2	0.7	32.3	159.3	9.5	3.1
35-44	8.8	131.0	5.9	1.8	8.9	125.3	9.8	8.3
45-54	2.2	61.2	2.3	2.6	2.7	54.4	3.3	12.1
55-64	1.4	40.0	1.2	5.5	1.7	28.3	1.1	19.0
65+	0.9	22.3	0.6	10.4	1.4	12.3	0.4	33.6

<sup>1</sup> батлуулагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

<sup>2</sup> цуцалсан болон тусгаарласан хүмүүсийг оруулсан.


Гэрлэлтээ цуцлуулах үед салж байгаа эрэгтэй, эмэгтэй хүний тоо тэнцүү байхад салсан эмэгтэйчүүдийн тоо өндөр байгаа нь эхлээд хараход гайхалтай байж болно (Зураг 3.4). Энд хоёр боломжийн шалтгаан бий. Нэгдүгээрт, эмэгтэйчүүдийн дундаж наслалт өндөр байдаг тул урд өмнө нь салсан олон эмэгтэйчүүд тооллогын үед амьд байгаатай холбоотой. Гэхдээ энэ тайлбар гэр бүлээ цуцалсан, тусгаарласан гэж хариулсан харьцангуй залуу насны олон тооны эмэгтэйчүүдийн хувьд ямар ч хамаагүй юм. Үнэн хэрэгтээ өндөр насандаа хүйсийн ялгаатай байдал залуу насныхтай харьцуулахад харьцангуй бага юм. Тиймээс хамгийн тохиромжтой тайлбар бол гэр бүл салсан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг бодвол дахин гэрлэх магадлал илүү байдаг юм.

### Зураг 3.4. Салсан хүн ам, насны бүлэг, хүйсээр, 2000 он



Гэр бүл цуцлуулсан, тусгаарласан хүн амын тоо 25-44 насны бүлэгт хамгийн их байхад (Зураг 3.4) бэлбэсрэлт нь нас ахиснаас илүү их шалтгаалдаг (Зураг 3.5). Дахин гэрлэлт ямар нэг хэмжээгээр байдаг ч бэлбэсрэлтийн түвшин нь нас баралтын хүйсийн ялгаатай түвшинг илүү тусгадаг.

### Зураг 3.5. Бэлбэсэн хүн ам, насны бүлэг, хүйсээр, 2000 он



Зураг 3.5-аас харахад нас ахих тутам бэлбэсэн эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс илүү өсч байна. 65, түүнээс дээш насны бүлэгт бэлбэсэн эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийн тооноос 23 мянга гаруйгаар илүү байна. Энэ нь мөн өндөр насны бүлгүүдэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс урт насалж байгаагаар тайлбарлагдана.

## Бүлэг 4. УЛСЫН ХАРЬЯАЛАЛ, ЯС ҮНДЭС

Тооллогоор Монгол Улсад оршин сууж байгаа бүх хүмүүсээс аль улсын харьяат болохыг асуусан. **Зураг 4.1** нь Монгол Улсын харьяат гэж хариулсан бүх хүнээс яс, үндсийн тухай асуултыг үргэлжлүүлж асуусан байдлыг харуулж байна.

### Зураг 4.1. Улсын харьяалал, яс үндэс, 2000 он



### Харьяалал

Монгол Улсад байнга оршин сууж байгаа хүн амын 99 гаруй хувь нь Монгол Улсын харьяат байна. Үлдсэн хүн амын ихэнхи нь тооллогын үед Монгол Улсад байнга оршин сууж байсан гадаадын иргэд байснаас гадна Монгол Улс болон өөр аль ч орны харьяалалгүй цөөн тооны хүмүүс байгаа юм.

Гадаадын 30 гаруй орны харьяат хүн ам Монгол Улсад байнга оршин сууж байна. Эдгээрийн хамгийн том бүлэг нь гадаадын харьяат нийт иргэдийн 42 хувийг эзэлж байгаа Оросын Холбооны Улсын иргэд, 25 хувийг эзэлж байгаа Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэд байна. 1989 оноос хойш гадаадын иргэдийн тоо огцом буурсан нь илт мэдэгдэж байна. 1989 оны тооллогын үед бараг 57 мянган гадаадын иргэд (хүн амын 2.8 хувь) Монгол Улсад байнга оршин сууж байсан бол 2000 онд гадаадын харьяат 8128 хүн (хүн амын 0.3 хувь) оршин сууж байна. **Энэ нь тооллогоо хоорондын хүн амын өсөлтийн хурдац буурахад нөлөөлсөн юм.**

Гадаадын иргэдийн тооны энэ огцом бууралт хуучин Зөвлөлт Холбоот Улсын харьяат иргэдийн 1989 оноос хойшхи цэвэр шилжин явалтаас голлон шалтгаалсан нь **Хүснэгт 4.1-ээс** харагдаж байна. Монгол Улсад 1989 онд хуучин Зөвлөлт Холбоот Улсын нийтдээ 54.5 мянган иргэд амьдарч байв. Харин 2000 оны байдлаар Оросын Холбооны Улсын харьяат 3.4 мянган иргэн, хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан бусад улсын харьяат цөөн хүн Монгол Улсад байнга оршин сууж байв.

**Хүснэгт 4.1. Гадаадын иргэд, харьят улс орноор, 1989 болон 2000 он**

Улс орнууд	1989		2000	
	мян.хүн	Дүнд эзлэх хувь	мян.хүн	Дүнд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>56.7</b>	<b>100.0</b>	<b>8.1</b>	<b>100.0</b>
Оросын Холбооны Улс	54.5 *	96.0 *	3.4	41.5
Бүгд Найрамдах Хятад Ард Улс	1.4	3.0	2.0	24.8
Казахстан Улс	- **	- **	0.6	8.0
Бүгд Найрамдах Солонгос Улс	-	-	0.3	4.2
Бусад	0.8	1.0	1.8	21.5

\*Хуучин ЗХУ-ын иргэд

\*\*1989 онд Казахстан Улс хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан.

Гадаадын иргэдийн ихэнхи нь хот, суурин газарт амьдарч байгааг **Хүснэгт 4.2-т** үзүүлэв. Гадаадын харьят иргэдийн талаас илүү хувь нь Улаанбаатар хотод амьдарч байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 32 хувь Улаанбаатарт амьдарч байгаатай харьцуулахад өндөр байна. Улаанбаатар, Орхон, Дархан-Уул гэсэн тус орны хамгийн томоохон хот газарт нийт гадаадын иргэдийн бараг 83 хувь амьдарч байна. Харин нийт хүн амын 39 хүрэхгүй хувь нь дээрхи гурван газар амьдарч байгаа билээ.

**Хүснэгт 4.2. Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын  
иргэд, зарим аймаг, нийслэлээр, 2000 он**

Аймаг, нийслэл	Байнга суугаа гадаадын иргэд	
	Тоо	Дүнд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>8128</b>	<b>100.0</b>
Улаанбаатар	4566	56.2
Орхон	1842	22.7
Хэнтий	580	7.1
Дархан- Уул	326	4.0
Сэлэнгэ	225	2.8
Төв	217	2.7
Бусад	372	4.6

Гадаадын иргэдийн насны бүтцийг Монгол Улсын хүн амын насны бүтэцтэй харьцуулахад ялгаатай байгаа нь Хүснэгт 4.3-аас харагдаж байна. Монгол Улсад амьдарч байгаа гадаадын иргэд харьцангуй өндөр настай байна. Гадаадын иргэдийн 53 хувийг 35, түүнээс дээш насны хүн ам эзэлж байхад Монгол Улсын нийт хүн амын 26 хувийг энэ насны хүн ам эзэлж байна. Энэ нь гадаадын иргэдийн дийлэнхи нь хөдөлмөрийн насны хүн ам байгааг харуулж байна. Харин гадаадын иргэдийн дунд 0-14, 15-24 насны хүн амын эзлэх хувь нийт хүн амтай харьцуулахад бага байна.

**Хүснэгт 4.3. Гадаадын харьяат иргэд болон нийт хүн амын эзлэх хувийн жин насны бүлэг, хүйсээр, 2000 он**

Насны бүлэг	Гадаадын иргэд			Нийт хүн ам	Хүйсийн харьцаа
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд		
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>125.1</b>
0-14	15.5	19.5	17.3	35.8	99.3
15-24	13.2	14.3	13.7	21.0	115.5
25-34	16.3	16.7	16.5	17.1	121.9
35-44	25.1	24.0	24.6	12.6	131.0
45-54	20.7	15.9	18.5	5.9	162.7
55+	9.2	9.6	9.4	7.6	120.5

**Яс үндэс**

Монгол Улсын иргэдээс тэдний яс үндсийг асуусан. Энэ асуултын хариултаас 30 ястан, үндэстний төлөөлөгч гарсан.

**Хүснэгт 4.4**-д яс үндсийн байдлыг 1989, 2000 оны тооллогоор харьцуулж харуулав. Ястан, үндэстний хамгийн том бүлэг нь бүх хүн амын 81.5 хувийг эзэлж байгаа халхчууд юм. Үлдсэн бүлгүүдээс халх ястны дараа нийт хүн амын 4.3 хувийг эзэлж байгаа казах орж байна. Бусад ястан, үндэстний бүлгээс дөрвөд, баяд, буриад, дариганга, захчин, урианхай зэрэг ястан Монгол Улсад байнга оршин суугаа бүх хүний 1.1-2.8 хувийг тус бүр эзлэж байна. Монгол Улсын ястан, үндэстний бүрэн төлөөллийг хүйс, байршилаар **Хавсралт 1-ийн Хүснэгт 4**-өөс харна уу.


<b>Хүснэгт 4.4. Монгол Улсын иргэд, яс үндсээр, 1989 болон 2000 он</b>					
Ястан, үндэстэн	1989		2000		
	мян.хүн	Дүнд эзлэх хувь	мян.хүн	Дүнд эзлэх хувь	
<b>Бүгд</b>	<b>2044.0</b>	<b>100.0</b>	<b>2373.5</b>	<b>100.0</b>	
<b>Монгол Улсын иргэд</b>	<b>1987.3</b>	<b>97.2</b>	<b>2365.4</b>	<b>99.7</b>	
Халх	1610.4	78.8	1934.7	81.5	
Казах	120.5	5.9	103.0	4.3	
Дөрвөд	55.2	2.7	66.7	2.8	
Баяд	39.2	1.9	50.8	2.1	
Буриад	35.4	1.7	40.6	1.7	
Дариганга	29.0	1.4	31.9	1.3	
Захчин	23.0	1.1	29.8	1.3	
Урианхай	21.3	1.0	25.2	1.1	
Бусад ястан, үндэстэн	53.1	2.6	82.6	3.5	
<b>Гадаадын иргэд</b>	<b>56.7</b>	<b>2.8</b>	<b>8.1</b>	<b>0.3</b>	

1989 оноос хойш ястан, үндэстний бүтцэд өөрчлөлт оржээ. Казах иргэдийн тоо бараг 20000-аар буурсан байна. Энэ нь 1990-ээд оны эхээр Бүгд Найрамдах Казахстан Улс руу олон тооны казах иргэд шилжин явснаас шалтгаалж байгаа юм. Казах болон гадаадын харьятат хүн амын тоо буурснаар халх ястны нийт хүн амд эзлэх хувь 1989 онд 79 хувь байсан бол 2000 онд 82 хувь болж өсчээ.

Хүн амын дийлэнхи нь болох халх ястны суурьшилт **Бүлэг 2-т** харуулсан нийт хүн амын суурьшилттай адил байгаа юм. Гэхдээ ястан, үндэстний зарим бүлгийн тархан суурьшилт өөр өөр байна.

Хамгийн тод жишээ бол казах хүн амын тархан суурьшилт юм. **Зураг 4.2-**оос казах хүн амын тархан суурьшилтын талаархи нарийн мэдээллийг харж болно. Казах хүн амын ихэнхи буюу 78.4 хувь нь Баруун бүс нутагт, ялангуяа Казахстан Улстай хил залган оршдог Баян-Өлгий аймагт амьдарч байна. Казахууд Баян-Өлгий аймгийн бүх суманд суурьшжээ. Үүнээс гадна Баян-Өлгий аймгийн нийт хүн амын 88.7 хувь нь казах үндэстнүүд байна. Монгол Улсын казах хүн амын бараг 10 хувь нь Ховд аймагт амьдарч байна. Казах хүн амын дийлэнхи нь уламжлалт, хамгийн баруун аймгуудад амьдарч байгаа ч сүүлийн үед нийслэл хот уруу буюу зүүн зүг үрүү чиглэсэн шилжих хөдөлгөөн эдгээр нутагт, ялангуяа Улаанбаатар хотод байгаа казах хүн амын тоог өсгөжээ. 2000 оны тооллогын үед нийт казах хүн амын 6.3 хувь нь Улаанбаатар хотод амьдарч, Дархан-Уул, Төв, Сэлэнгэ, Орхон, Хэнтий, Увс аймагт мэдэгдэхүйц олноор суурьшсан байна.

#### Зураг 4.2. Казах иргэдийн суурьшилт, 2000 он



Ястан үндэстнүүдийн насны бүтэц хоорондоо ялгаатай байна. Тухайлбал, казах иргэдийн дунд 15 хүртэлх насны хүүхэд 43 хувь эзлэж байгаа нь бусад ястан үндэстний бүлэгтэй харьцуулахад казахууд хамаагүй залуу насны

бүтэцтэй байна. Энэ нь казах иргэдийн дунд төрөлт өндөр байгаатай холбоотой юм. Харин буриад ястан харьцангуй өндөр настай байна. Эдгээр мэдээлэл нь хүн ам зүйн төрх байдлаас гадна хүмүүс өөрсдийгөө ямар ястан үндэстний бүлэгт хамрагддаг гэж тодорхойлсныг мөн тусгаж байгааг ястан үндэстний талаархи судалгаанд анхаарах нь зүйтэй.

Ястан, үндэстэн	Насны бүлэг						
	0-14	15-24	25-34	35-44	45-54	55+	Бүгд
Бүгд	35.8	21.0	17.1	12.6	5.9	7.6	100.0
Монгол Улсын иргэд	35.8	21.1	17.0	12.6	5.9	7.6	100.0
Халх	35.5	21.2	17.3	12.7	5.9	7.4	100.0
Казах	42.5	20.6	15.5	10.1	4.6	6.7	100.0
Дөрвөд	36.8	20.0	16.5	12.5	6.2	8.0	100.0
Буриад	30.6	19.6	15.8	14.6	8.2	11.2	100.0
Баяд	37.1	19.7	16.8	12.5	6.1	7.8	100.0
Бусад ястан, үндэстэн	36.4	20.3	16.0	12.2	6.2	8.9	100.0
Гадаадын иргэд	17.3	13.7	16.5	24.6	18.5	9.4	100.0

## Бүлэг 5: ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, ХОТЖИЛТ


Шилжих хөдөлгөөн бол хүн ам зүйн бусад үйл явцтай адилгүй юм. Төрөлт, нас барагтын ойлголтыг ойлгоход амархан, тэдгээрийг тооцдог хэмжигдэхүүн олон улсын түвшинд зөвшөөрөгдсөн шалгууруудтай нийцдэг. Харин шилжих хөдөлгөөний асуудал бол тухайн нөхцөл байдлаас шалтгаалж тусгайлан тодорхойлж байхыг шаарддаг. Хүмүүс байнгын хөдөлгөөнд оршдог бөгөөд янз бүрийн шалтгаанаар шилжин суурьших нь амьдралын шаардлага юм. Шилжих хөдөлгөөнийг тодорхойлохын тулд түүнийг тодорхой цаг хугацаа, орон зайнд авч үзэх хэрэгтэй. Шилжих хөдөлгөөнийг, ялангуяа дотоод шилжих хөдөлгөөнийг ийнхүү тодорхойлсноор энэ нь тухайн улс орны хувьд өвөрмөц болж, олон улсын харьцуулалт хийхэд тохиromжгүй юм.

Хүн амын тооллого шилжих хөдөлгөөнийг хэмжихдээ дотоод шилжих хөдөлгөөнд гол анхаарлаа хандуулдаг. Гадаад шилжих хөдөлгөөнийг тооллогоор хэмжих оролдлого урд өмнө хийж байсан ч тэр бүр амжилттай болдоггүй. Гадаад шилжих хөдөлгөөнийг хэмжих өөр арга байдаг бөгөөд түүнийг энэ тайлангийн хүрээнд тайлбарлах боломжгүй билээ.

Шилжих хөдөлгөөнийг хэмжихэд цаг хугацаа, орон зайлт тодорхойлох нь чухал ач холбогдолтой тул нэг эх үүсвэрээс шилжих хөдөлгөөний хоорондоо ялгаатай, олон төрлийн үнэн зөв мэдээллийг гарган авч болох юм. Энэ бүлгийн зорилго дотоод шилжих хөдөлгөөний асуултыг нягтлан харах, эдгээрээс тооцсон зарим чухал ач холбогдолтой үзүүлэлтүүдийг танилцуулахад оршино.

Шилжилт дээр биш харин шилжигсэд дээр үндэслэсэн дотоод шилжих хөдөлгөөний гурван өөр аргыг тооллогод хэрэглэсэн. Бид тухайн хугацаанд нэг газар байнга оршин сууж байгаад өөр газарт шилжин суурьшсан хүн амын буюу шилжигсдийн тоог гаргаж байгаа бөгөөд харин тухайн хугацааны шилжих хөдөлгөөний тоог гаргаагүй юм. Эхнийх нь төрсөн газрын асуулт дээр үндэслэсэн байв (Зураг 5.1).


Зураг 5.1. Төрснөөс хойши дотоод шилжих хөдөлгөөн, 2000 он



Амьдралынхаа ямар нэг үед төрсөн газраасаа (аймаг, нийслэл) өөр газарт (аймаг, нийслэл) байнга оршин сууж байсан хүмүүсийг *төрснөөс хойш шилжигсэд* гэж үзсэн. Эдгэр шилжигсэд орон зайн хэмжүүр болох аймгийн хил хязгаарыг гатлан, цаг хугацааны хэмжүүр болох амьдралынхаа хугацаанд ямар нэг үед шилжих хөдөлгөөнд орсон байна.

Шилжих хөдөлгөөнийг хэмжих хоёр дахь арга байнга оршин сууж байгаа хугацааг үндэслэсэн байв (**Зураг 5.2**). Тооллогын үед байнга оршин сууж байсан аймаг, нийслэлд шилжиж ирсэн хүн нэг бүрээс байнга оршин сууж байгаа хугацаа, урд нь байнга оршин сууж байсан аймаг, нийслэлийн нэрийг асуусан. Энэ тайланд зөвхөн сүүлийн жил (1999 онд) тухайн аймаг, нийслэлд шилжиж ирсэн хүмүүсийг судалсан. Гэхдээ байнга оршин суусан өөр, өөр хугацаагаар хүснэгт гаргаж, судалгаа хийх боломжтой.

**Зураг 5.2. Сүүлийн нэг жилийн дотоод шилжих хөдөлгөөн (байнга оршин сууж байгаа хугацаан дээр үндэслэсэн), 2000 он**



Байнга оршин сууж байгаа хугацааны асуулт шилжих хөдөлгөөний хугацаанаас хамаарлтай цаг хугацааны үргэлжилсэн үзүүлэлтийг гаргаж өгдөг. Харин үүний эсрэгээр гурав дахь аргаар (**Зураг 5.3**) цаг хугацааны тогтмол зайд хэрэглэж, яг таван жилийн өмнө байнга оршин сууж байсан газрыг асуусан. Нэг асуултаас тогтмол зайн үзүүлэлтийг гаргаж авахад тулгардаг хүндрэлтэй асуудал бол зөвхөн хамгийн сүүлийн шилжилтийн мэдээллийг авдагт оршино. Ингэснээр хэрэв тухайн хүн олон удаа шилжих хөдөлгөөнд орсон бол өмнөх шилжилтүүдийн талаархи мэдээллийг авч чадахгүй юм. Зөвхөн тооллогын үе болон өнгөрсөн тодорхой хугацааны хоорондох цэвэр шилжих хөдөлгөөнийг хэмжих зорилгоор цаг хугацааны тогтмол зайд хэрэглэснээр зөвхөн сүүлийн шилжилтийг авах өрөөсгөл байдлаас татгалзана. Энэ тохиолдолд таван жилийн өмнө байнга оршин сууж байсан газар хамгийн сүүлд оршин сууж байсан газар биш байсан ч гэсэн зөвхөн үүнийг мэдээлдэг. Гэхдээ энэ тайланд өнгөрсөн нэг жилийн хугацааг хэрэглэснээр олон дахин шилжсэн шилжих хөдөлгөөний нөлөөллийг багасгаж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Тав хүртэлх насны хүүхдүүд тооллого явуулахаас таван жилийн өмнө төрөөгүй байсан тул шилжих хөдөлгөөнийг тодорхой хугацааны аргаар (таван жилийн өмнөх байнга сууж байсан газар) тодорхойлоход зөвхөн тав, түүнээс дээш насны хүмүүсийг оруулсан.

### Зураг 5.3. Сүүлийн таван жилийн дотоод шилжих хөдөлгөөн, 2000 он



Дээрх товч тайлбараас үзэхэд тооллогод хэрэглэсэн гурван аргад төрснөөс хойш, сүүлийн нэг жил, таван жилийн өмнө гэсэн гурван өөр цаг хугацааны хэмжигдэхүүн хэрэглэсэн гэдэг нь харагдаж байна. Шилжих хөдөлгөөнийг орон зайгаар тодорхойлоход засаг захиргаа, газар зүйн хоёр түвшинг хэрэглэсэн. Эхнийх нь аймаг бөгөөд тухайн хүн аймгийн хил хязгаарыг давж, нэг аймгаас нөгөө аймагт шилжиж ирсэн бол түүнийг шилжих хөдөлгөөнд орсон гэж үзнэ. Орон зайн хоёр дахь түвшин бол бус нутаг юм (Бус нутгийн ангилалыг **хуудас 30-аас хар**). Энэ ангиллыг хэрэглэхэд шилжин явсан бус нутаг шилжин ирсэн бус нутгаас өөр байх ёстой. Шилжих хөдөлгөөний судалгааг энгийн болгохын тулд зөвхөн бус нутаг хоорондын шилжих хөдөлгөөнийг авч үзсэн болно. Гэхдээ аймаг хоорондын шилжих хөдөлгөөний судалгааг зарим хэмжээгээр хийж, хотжилтын судалгаанд ашиглав.

Хүснэгт 5.1. Шилжигсдийн тоо, цаг хугацаа, орон зайгаар, мян.хүн, 2000 он		
Цаг хугацаа	Орон зай	
	Аймаг	Бус
Төрснөөс хойшхи	491.8	403.5
Сүүлийн таван жил	181.4	149.1
Сүүлийн нэг жил	79.0	64.9

Хүснэгт 5.1-д харуулснаар цаг хугацаа, орон зайгаар авч үзэхэд шилжих хөдөлгөөнд орсон хүний тоо 65 мянгаас 492 мянгын хооронд хэлбэлзэж байна. Цаг хугацааны зай урт, орон зайн нэгж бага байх тутам шилжигсдийн тоо олон байх өрөнхий зарчимтай нь харагдаж байна. Хүснэгт 5.1-ээс харахад бус нутаг хоорондын шилжих хөдөлгөөн, аймаг хоорондын шилжих хөдөлгөөнөөс зөвхөн 18 хувиар доогуур байна. Энэ нь хамгийн олон хүн шилжин ирж, суурьшиж байгаа Улаанбаатар хот дангаараа нэг бус нутаг болж байгаатай холбоотой.

## Төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөн

Төрсөн газрыг үндэслэн тодорхойлогдох төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөн бол олон талын ач холбогдолтой юм. Үүний зарчмын ялгаа нь төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөнд амьдралынхаа аль нэг хугацаанд төрсөн газраасаа шилжсэн бүх хүмүүсийг хамруулж байгаад оршино. Энэ нь тухайн нутаг дэвсгэрээс өөр газар төрсөн бүх хүмүүсийг тэдний шилжин ирсэн хугацааг үл харгалзан шилжин ирэгсэд гэж үздэг тул социологийн тодорхойлолтын хувьд их ач холбогдолтой юм.

Төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний мэдээллийг ашиглахад дутагдалтай талын нэг бол шилжих хөдөлгөөний хугацаа тодорхой бус байдаг явдал юм. Бидний мэдэж байгаа зүйл бол шилжигсэд амьдралынхаа аль нэг хугацаанд шилжих хөдөлгөөнд орсон явдал юм. Төрснөөсөө хойш шилжих хөдөлгөөнд орсон хүмүүсийг ядаж нэг удаа шилжих хөдөлгөөнд орсон, мөн шилжих хөдөлгөөний хугацааг тухайн хүний настай холбоотойгоор ямар нэг хэмжээгээр хязгаарлагдсан байх зэргээс өөр, жишээлбэл хамгийн сүүлд шилжих хөдөлгөөнд орсон хугацаа, шилжих хөдөлгөөнд хэдэн удаа орсон талаар мэдэх зүйл бага юм. Харин цэвэр нөлөөг харж болно.

**Хүснэгт 5.2-д** төрснөөс хойш тухайн бүс нутагт шилжин ирэгсэд, тухайн бүс нутгаас шилжин явагсад, мөн түүнчлэн төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд ороогүй, өөрөөр хэлбэл тооллогын үед тухайн газартай төрснөөс хойш байнга оршин сууж байсан хүмүүсийн тоог харуулж байна. Эдгээр хүмүүс бүс нутаг дотроо шилжих хөдөлгөөнд орсон байж болно. Харин бүс нутаг хооронд шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүс юм. **Хүснэгт 5.2-ын** эцсийн баганад тооцож гаргасан цэвэр шилжих хөдөлгөөнийг, өөрөөр хэлбэл төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний үр дүнд гарсан бүс нутаг нэг бүрийн хүн амын тооны өсөлт, бууралтыг

**Хүснэгт 5.2. Төрснөөс хойшхи шилжигсэд, бүс нутгаар, 2000 он**

Бүс нутаг	Хүн ам бүгд	Төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний байдал			Цэвэр шилжих хөдөлгөөн (+/-)
		Шилжих хөдөлгөөнд ороогүй	Шилжин ирэгсэд <sup>1</sup>	Шилжин явагсад	
Бүгд	2373493	1970016	403477	403477	0
Төвийн	757439	638752	104612	118687	-14075
Зүүн	230064	191432	11053	38632	-27579
Баруун	674112	502206	4181	171906	-167725
Өмнөд	177834	146537	14643	31297	-16654
Улаанбаатар	526235	491089	268988	35146	233842
Гадаад	7809	ГБ	ГБ	7809 <sup>2</sup>	-7809

<sup>1</sup> гадаадаас шилжин ирэгсэд энд орсон

<sup>2</sup> гадаадаас Монгол Улсад шилжин ирэгсэд

ГБ-тоологоор гадаадад төрсөн, гадаадад амьдарч байгаа хүмүүсийг тоолоогүй.

харуулав.

Нийт хүн амын 17 хувь буюу 403477 хүн төрснөөс хойш бүс нутаг хооронд шилжих хөдөлгөөнд оржээ. Харин аймаг хоорондын шилжих хөдөлгөөнөөр авч үзвэл энэ хувь 21-д хүрч байна. (Хавсралт 1-ийн Хүснэгт 5-ыг харна уу.) Үүнийг шилжих хөдөлгөөний сэдэвчилсэн судалгаагаар илүү нарийвчлан авч үзэх болно.

Тодорхойлолтын дагуу дотоодын шилжигсэд (энд гадаадад төрсөн 7809 хүн ороогүй) гэдэг нь амьдарч байсан бүс нутгаасаа шилжиж, өөр бүс нутагт амьдрах болсон хүмүүсийг хэлнэ. Тиймээс шилжих хөдөлгөөнд орж байгаа хүмүүс тодорхой нэгэн цагт шилжин ирэгсэд, явагсад болж байгаа тул шилжин явагсад, ирэгсдийн тоо тэнцүү байдаг. Үүнээс үүдэн гарч ирэх бас нэг ойлголтын чанартай чухал асуудал бол Монгол Улсын хувьд дотоод цэвэр шилжих хөдөлгөөн гадаадад төрсөн 7809 хүнийг хасаад тэтгэй тэнцүү байна гэсэн үг.

Төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний төрхийг авч үзвэл Улаанбаатараас бусад бүх бүс нутагт цэвэр шилжин явалт давамгайлж, өөрөөр хэлбэл шилжин явагсдын тоо шилжин ирэгсдийнхээс давсан байна. Харин Улаанбаатар хотын хувьд цэвэр шилжин ирэгсэд 233842 болжээ. Бусад бүс нутгаас шилжин явагсад бүгдээрээ зөвхөн нийслэл хот руу ирээгүй нь ойлгомжтой. Бусад бүс нутгаас нийтдээ 360522 хүн шилжин явснаас 268988 хүн Улаанбаатар хотод, 91534 хүн нийслэл хотоос бусад бүс нутаг хооронд шилжин суурьшсан байна. **Хүснэгт 5.3-т** бүс нутаг хоорондын, **Хавсралт 1-ийн Хүснэгт 6-д** аймаг хоорондын шилжих хөдөлгөөний урсгалыг харуулав.

Хүснэгт 5.3. Хүн амын тоо, төрсөн болон тооллогын үед байнга оршин сууж байсан газраар, 2000 он							
Төрсөн газар	Тооллогын үед байнга оршин сууж байсан газар						Шилжин явагсад
	Бүгд	Төвийн	Зүүн	Баруун	Өмнөд	Улаанбаатар	
<b>Бүгд</b>	<b>2373493</b>	<b>743364</b>	<b>202485</b>	<b>506387</b>	<b>161180</b>	<b>760077</b>	-
Төвийн	757439	<b>638752</b>	2971	1615	4889	109212	<b>118687</b>
Зүүн	230064	6059	<b>191432</b>	276	2390	29907	<b>38632</b>
Баруун	674112	62442	2703	<b>502206</b>	3199	103562	<b>171906</b>
Өмнөд	177834	6953	1608	266	<b>146537</b>	22470	<b>31297</b>
Улаанбаатар	526235	26527	2903	1709	4007	<b>491089</b>	<b>35146</b>
Гадаад	7809	2631	868	315	158	3837	<b>7809 *</b>
<b>Шилжин ирэгсэд</b>	-	<b>104612</b>	<b>11053</b>	<b>4181</b>	<b>14643</b>	<b>268988</b>	<b>403477</b>

\*годаадаас Монгол Улсад шилжин ирэгсэд

Баруун бүс нутгийн хүн амын нилээд хэсэг өөр бүс нутагт шилжжээ. Одоогоор Баруун бүс нутагт төрсөн 171906 хүн өөр бүс нутагт амьдарч байна. Энэ тоо нь тухайн бүс нутагт тооллогын үед байгаа нийт хүн амын бараг гуравны нэгтэй тэнцүү байна. Хэрэв Баруун бүс нутгаас бусад бүс нутаг руу шилжсэн хүмүүс дээр гадаадад шилжсэн хүмүүсийг нэмж тооцвол тус бүс нутгийн тооллого хоорондын хүн амын өсөлт бага байгаа

нь ойлгомжтой болох юм (тооллого хоорондын өсөлтийг **Хүснэгт 3.1-ээс хар**).

Сийрэг суурьшилтай Зүүн болон Өмнөд бүсийн хүн амын өсөлтөд шилжих хөдөлгөөн харьцангуй бага нөлөө үзүүлсэн. Эдгээр бус нутгийн цэвэр шилжих хөдөлгөөн тооллогын үеийн хүн амын бараг 10-15 хувь нь болж байна. Төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд орсон хүний эзлэх энэ хувиас харахад түүний жилийн дундаж хүн амд нөлөөлөх нөлөө тийм их биш байна. Төвийн бүсийн хүн амд шилжих хөдөлгөөн нөлөөлсөн нь илт бөгөөд тус бус нутгийн хүн ам цэвэр шилжих хөдөлгөөний үр дүнгээс шалтгаалан буурсан байна. Төвийн бус нутгийн хот, суурин газруудыг хөгжихөд Улаанбаатар хотыг бусад бус нутаг, улс оронтой холбосон зам, төмөр зам илүү боломж бий болгосон байна. Иймээс Төвийн бус нутаг руу шилжин ирэгсэд нийслэл хот руу шилжин ирэгсэдтэй нэгэн адил шалтгаанаар татагдсан байна (**Хүснэгт 5.3**). Гэхдээ Төвийн бус нутаг нийслэл хот биш учраас харьцангуй олон хүмүүс Төвийн бус нутгаас Улаанбаатар хот руу шилжсэн байна. Тооллогын үед Төвийн бус нутагт сууж байгаа хүн амын гурваас бага хувийг цэвэр шилжигсэд өзэлж байгаа ч Төвийн бус болон Улаанбаатар хотын эдийн засаг, нийгмийн хөгжилд шилжих хөдөлгөөн нөлөөлсөн гэдэг нь тодорхой.

**Хүснэгт 5.3-аас** харахад Улаанбаатар хотын хүн амын өсөлтөд шилжин ирэгсэд бодитойгоор нөлөөлсөн байна. Тооллогын үеийн хүн амын 35.4 хувь нь өөр бус нутагт төрсөн хүмүүс байв. Улаанбаатар хотын шилжих хөдөлгөөний шинж төрх Төвийн бус нутгийнхаас ялгаатай байна. Нийслэл хотоос шилжин явагсдын тоо шилжин ирэгсдийн тоотой харьцуулахад цөөн байна. Хэрэв дотоод шилжих хөдөлгөөн үе шаттайгаар явагдаж байна гэж үзвэл, түр хугацаагаар хүлээн авах газар нь Төвийн бус нутаг болж, Улаанбаатар хот шилжих хөдөлгөөний эцсийн цэг болж байна. Гэхдээ Төвийн бус нутагт шилжин ирсэн 104612 хүн Төвийн бүсийн нийт хүн амын 14 хувьолж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Хүснэгт 5.4-т төрснөөс хойшхи шилжигсдийн урсгалыг бус нутаг, дунд эзлэх хувиар харууллаа. Хүснэгт 5.4-ийн эхний хэсэгт хүн амын эзлэх хувийг төрсөн газраар нь гаргав. Төрсөн бус нутагтаа төрснөөс хойш амьдарч байгаа хүн амын эзлэх хувь Улаанбаатар хотод (93.3 хувь) хамгийн өндөр байна. Улаанбаатар хотод төрөөд, 2000 оны тооллогоор тоологдсон бүх хүн амын 5.0 хувь нь Төвийн бус, 0.8 хувь нь Өмнөд бус рүү шилжин суурьшсан нь Улаанбаатар хотод төрсөн хүн амыг хамгийн их татдаг бус нутаголж байна. Төрсөн бус нутагтаа төрснөөс хойш амьдарч байгаа хүн амын эзлэх хувиараа Улаанбаатар хотын дараа хамгийн өндөр нь Төвийн бус нутаголж байна. Төвийн бус нутагт төрөөд, 2000 оны тооллогод тоологдсон бүх хүн амын 14.4 хувь нь Улаанбаатар хотод, 0.7 хувь нь Өмнөд, 0.4 хувь нь Зүүн, 0.2 хувь нь Баруун бус нутагт тус тус шилжин суурьшжээ. Харин Улаанбаатар, Төвийн бус нутагтай харьцуулахад Баруун бус нутагт төрснөөс хойш амьдарч байгаа хүн амын эзлэх хувь хамгийн бага (74.5 хувь) байна.

Хүснэгт 5.4. Хүн амын эзлэх хувь, төрсөн болон тооллогын үед байнга оршин сууж байсан газраар, 2000 он						
Төрсөн газар	Тооллогын үед байнга оршин сууж байсан газар					
	Бүгд	Төвийн	Зүүн	Баруун	Өмнөд	Улаанбаатар
<b>A. Бүгд</b>	<b>100.0</b>	<b>31.3</b>	<b>8.5</b>	<b>21.4</b>	<b>6.8</b>	<b>32.0</b>
Төвийн	<b>100.0</b>	<b>84.3</b>	0.4	0.2	0.7	14.4
Зүүн	<b>100.0</b>	2.6	<b>83.2</b>	0.1	1.1	13.0
Баруун	<b>100.0</b>	9.2	0.4	<b>74.5</b>	0.5	15.4
Өмнөд	<b>100.0</b>	3.9	0.9	0.2	<b>82.4</b>	12.6
Улаанбаатар	<b>100.0</b>	5.0	0.6	0.3	0.8	<b>93.3</b>
Гадаад	<b>100.0</b>	33.7	11.1	4.0	2.0	49.2
<b>Төрсөн газар</b>	<b>Бүгд</b>	<b>Төвийн</b>	<b>Зүүн</b>	<b>Баруун</b>	<b>Өмнөд</b>	<b>Улаанбаатар</b>
<b>B. Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Төвийн	31.9	<b>85.9</b>	1.5	0.3	3.0	14.4
Зүүн	9.7	0.8	<b>94.6</b>	0.1	1.5	3.9
Баруун	28.4	8.4	1.3	<b>99.2</b>	2.0	13.6
Өмнөд	7.5	0.9	0.8	0.0	<b>90.9</b>	3.0
Улаанбаатар	22.2	3.6	1.4	0.3	2.5	<b>64.6</b>
Гадаад	0.3	0.4	0.4	0.1	0.1	0.5

Хүснэгт 5.4-ийн дараагийн хэсэгт хүн амын эзлэх хувийг 2000 оны тооллогын үед байнга оршин сууж байсан бүс нутгаар харуулав. 2000 оны тооллогын үед Улаанбаатарт байнга оршин сууж байсан бүх хүн амын зөвхөн 64.6 хувь Улаанбаатар хотод төрсөн байна. Үүний эсрэгээр Баруун бүс нутагт тоологдсон бүх хүн амын 99.2 хувь нь Баруун бүс нутагт төрсөн, харин дөнгөж 0.8 хувь нь бусад нутгаас шилжин ирж суурьшжээ.

#### Таван жилийн өмнөхтэй харьцуулсан шилжих хөдөлгөөн

Төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөн цаг хугацааны хувьд тодорхой бус байдаг бол таван жилийн өмнө байнга оршин сууж байсан газрын талаархи асуулт цаг хугацааг мэдэгдэхүйц тодорхой болгож байгаа юм.

Таван жилийн шилжих хөдөлгөөний судалгаа төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний судалгаатай нэгэн адил хийгдэх бөгөөд харин харьцангуй богино, таван жилийн хугацаанд байнга оршин суудаг газраа өөрчилсөн хүний тоо цөөн юм. Таван жилийн шилжих хөдөлгөөний байдлыг аймаг, нийслэл болон хүйсээр **Хавсралт 1-ийн Хүснэгт 7-д** харуулав.

**Хүснэгт 5.5. Таван жилийн өмнөхтэй харьцуулсан шилжих хөдөлгөөнд  
оролцогсод бүс нутгаар, 2000 он**

Бүс нутаг	5, түүнээс дээш насын нийт хүн ам	1995 оны 1-р сартай харьцуулахад			Цэвэр шилжих хөдөлгөөн (+/-)
		Шилжих хөдөлгөөнд ороогүй	Шилжин ирэгсэд <sup>1</sup>	Шилжин явагсад	
Бүгд	2127470	1978396	149074	149074	0
Төвийн	674200	626942	36709	47258	-10549
Зүүн	192242	176319	4629	15923	-11294
Баруун	482787	435646	5212	47141	-41929
Өмнөд	147663	135812	7089	11851	-4762
Улаанбаатар	623755	603677	95435	20078	75357
Гадаад	6823	ГБ	ГБ	6823 <sup>2</sup>	-6823

<sup>1</sup>годаадаас шилжин ирэгсэд энд орсон

<sup>2</sup>годаадаас Монгол Улсад шилжин ирэгсэд

ГБ-тоологоор гадаадад төрсөн, гадаадад амьдарч байгаа хүмүүсийг тоолоогүй.

Таван жилийн өмнөхтэй харьцуулсан шилжих хөдөлгөөний төрх төрснөөс хойшиши шилжих хөдөлгөөнийхтэй төстэй байгаа юм. Нийслэл хотоос бусад бүх бүс нутагт цэвэр гадагш шилжих хөдөлгөөнтэй байна. Баруун бүс нутаг бусад бүс нутаг руу хүмүүсээ алдаж, цэвэр гадагш шилжсэн хөдөлгөөн Баруун бүс нутагт хамгийн их байна. Бусад бүс нутагт цэвэр гадагш шилжсэн хөдөлгөөн тийм ч их биш байгаа юм. Гэхдээ Төвийн бүс нутгаас шилжин явсан болон ирсэн хүн ам тус бүс нутгийн тооллогын үеийн хүн амын 12-оос илүү хувьтай тэнцүү байна. **Хүснэгт 5.6-д** таван жилийн хөдөлгөөнд оролцогсдын урсгалыг бүс нутгаар, **Хүснэгт 5.7-д** таван жилийн шилжих хөдөлгөөнд оролцогсдын урсгалыг бүс нутаг, дунд эзлэх хувиар харуулав.

**Хүснэгт 5.6. Таван жилийн өмнөхтэй харьцуулсан шилжих хөдөлгөөнд оршинаар бий болсон тооллогын үед байнга оршин сууж байсан газраар, 2000 он**

1995 оны 1-р сард байнга оршин сууж байсан газар	5, түүнээс дээш насын нийт хүн ам	Тооллогын үед байнга оршин сууж байсан газар					Шилжин явагсад
		Төвийн	Зүүн	Баруун	Өмнөд	Улаанбаатар	
Бүгд	2127470	663651	180948	440858	142901	699112	-
Төвийн	674200	626942	1040	1250	2259	42709	47258
Зүүн	192242	2199	176319	153	1109	12462	15923
Баруун	482787	17305	290	435646	733	28813	47141
Өмнөд	147663	2285	903	213	135812	8450	11851
Улаанбаатар	623755	12969	1964	2276	2869	603677	20078
Гадаад	6823	1951	432	1320	119	3001	6823 *
Шилжин ирэгсэд	-	36709	4629	5212	7089	95435	149074

\*годаадаас Монгол Улсад шилжин ирэгсэд

**Хүснэгт 5.7-ийн** эхний хэсэгт таван жилийн шилжигсдийн урсгалыг 1995 оны 1-р сард байнга оршин сууж байсан газраар, дунд эзлэх хувиар харуулав. Улаанбаатар хотод 1995 оны 1-р сард байнга оршин сууж

байсан бүх хүн амын 96.8 хувь нь Улаанбаатар хотод үлдсэн байна. Харин 1995 оны 1-р сард Баруун бүс нутагт байнга сууж байсан нийт хүн амын 90.2 хувь нь тооллогын үед тус бүс нутагт амьдарч, 9.8 хувь нь бусад бүс нутаг уруу шилжин явсан байна. Баруун бүс нутгаас сүүлийн таван жилд шилжин явагсдын 60 орчим хувь нь Улаанбаатар хот уруу, 40 хүрэхгүй хувь нь Төвийн бүс нутаг уруу шилжсэн байна.

**Хүснэгт 5.7-ийн** хоёрдахь хэсэгт таван жилийн шилжигсдийн урсгалыг 2000 оны тооллогын үед байнга оршин сууж байсан газраар, дунд эзлэх хувиар харуулав. Улаанбаатар хотод тоологдсон бүх хүн амын 86.4 хувь нь 1995 оны 1-р сард Улаанбаатарт байнга сууж байжээ. Төвийн болон Өмнөд бүс нутагт сүүлийн таван жилд хамгийн их шилжин ирэгсэдтэй байна. 2000 оны тооллогоор Төвийн бүс нутагт тоологдсон бүх хүн амын 94.5 хувь нь 1995 оны 1-р сард Төвийн бүс нутагт байнга оршин сууж байсан бол 2.6 хувь нь Баруун бүс нутгаас, 2.0 хувь нь Улаанбаатар хотоос шилжин иржээ. 2000 оны тооллогоор Өмнөд бүс нутагт тоологдсон бүх хүн амын 95 хувь нь Өмнөд бүс нутагт яг таван жилийн өмнө байнга оршин сууж байжээ. Ийнхүү 2000 оноос өмнөх таван жилийн хугацаанд Өмнөд бүс нутаг бусад бүс нутгаас хүмүүсийг татсан дараагийн (Улаанбаатар, Төвийн бүсийн дараа) бүс нутаг болсон байна. Энэ нь БНХАУ-тай хиллэдэг Замын-Үүдийн хөгжилтэй холбоотой байж болно.

**Хүснэгт 5.7. Хүн амын эзлэх хувь, 1995 оны 1-р сард болон тооллогын үед байнга оршин сууж байсан газраар, 2000 он**

1995 оны 1-р сард байнга оршин сууж байсан газар	Бүгд	Тооллогын үед байнга оршин сууж байсан газар				
		Төвийн	Зүүн	Баруун	Өмнөд	Улаанбаатар
<b>A. Бүгд</b>	<b>100.0</b>	<b>31.3</b>	<b>8.5</b>	<b>21.4</b>	<b>6.8</b>	<b>32.0</b>
Төвийн	100.0	93.0	0.2	0.2	0.3	6.3
Зүүн	100.0	1.1	91.7	0.1	0.6	6.5
Баруун	100.0	3.6	0.1	90.2	0.1	6.0
Өмнөд	100.0	1.6	0.6	0.1	92.0	5.7
Улаанбаатар	100.0	2.1	0.3	0.3	0.5	96.8
Гадаад	100.0	28.6	6.3	19.4	1.7	44.0
<b>1995 оны 1-р сард байнга оршин сууж байсан газар</b>		<b>Бүгд</b>	<b>Төвийн</b>	<b>Зүүн</b>	<b>Баруун</b>	<b>Өмнөд</b>
<b>B. Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Төвийн	31.7	94.5	0.6	0.3	1.6	6.1
Зүүн	9.1	0.3	97.4	0.0	0.8	1.8
Баруун	22.7	2.6	0.2	98.8	0.5	4.1
Өмнөд	6.9	0.3	0.5	0.1	95.0	1.2
Улаанбаатар	29.3	2.0	1.1	0.5	2.0	86.4
Гадаад	0.3	0.3	0.2	0.3	0.1	0.4

Таван жилийн хугацаа тодорхой учраас жилийн шилжих хөдөлгөөнийг тооцож болох юм<sup>1</sup>.

**Хүснэгт 5.8. Шилжих хөдөлгөөний жилийн дундаж коэффициент, 1995 оны 1-р сараас 2000 оны 1-р сар**

Бүс нутаг	Хүн ам (мян.хүн)		Шилжих хөдөлгөөний жилийн дундаж коэффициент (+/-)*
	Шилжих хөдөлгөөнийг оруулсан	Шилжих хөдөлгөөнийг оруулаагүй	
Бүгд	2120.6	2120.6	0.0
Төвийн	696.1	623.8	2.2
Зүүн	180.5	192.2	-1.9
Баруун	439.6	482.7	-1.2
Өмнөд	142.8	147.6	-0.7
Улаанбаатар	661.6	674.3	-0.4

\* $(\text{Log } \frac{P_2}{P_1})/n$  гэсэн томъёогоор тодорхойлсон, энд  $P_2$  – шилжих хөдөлгөөнийг оруулсан онолын хүн ам,  $P_1$  – шилжих хөдөлгөөнийг оруулаагүй онолын хүн ам,  $n$  – таван жил

Хүн амын жилийн дундаж өсөлт нь хүн амын суурьшилт, бүс нутгийн өсөлтэд дотоод шилжих хөдөлгөөний үзүүлж байгаа нөлөөллийг харуулж байна. Үүнийг янз бүрийн бүс нутгийн тооллого хоорондын өсөлтөөр илүү тод үзүүлж болно. Эхлээд тооллого хоорондын өсөлт тухайн цаг хугацаанд жигд тархсан гэж төсөөльье. Тэгвэл Улаанбаатар хотын хүн ам жилд дунджаар 3.6 хувиар өсчээ. Энэ өсөлтийн 64 хувь нь бусад бүс нутгаас цэвэр шилжин ирэгсдийн шууд үр дүн байв. Улаанбаатар хотоос бусад бүс нутаг, ялангуяа Баруун бүс нутгийн тооллого хоорондын хүн амын өсөлт бага байгаа нь их хэмжээний шилжин явалтаас шалтгаалж байгаа юм.

### Нэг жилийн шилжих хөдөлгөөн

Байнга оршин суусан хугацааны асуулт шилжих хөдөлгөөнийг тодорхой хугацаагаар судлах боломжийг олгож байна. Шилжих хөдөлгөөний богино хугацаанд дээр дурдсантай адил өрөөсгөл тал байхгүйгээс гадна олон удаа шилжих хөдөлгөөнд орсон хүмүүс цөөн, мөн тухайн цаг хугацааны шилжих хөдөлгөөний тохиолдлын ихэнхи нь ордог. Гэхдээ өөр төрлийн хүндрэлтэй асуудлууд гарч ирдэг. Богино хугацааны шилжих хөдөлгөөнд орсон хүмүүсийн ихэнхи нь тодорхой бус нөхцөлд, өөрөөр хэлбэл удаан хугацааны шилжих хөдөлгөөнд орж байгаа эсэх нь тодорхойгүй байдаг. Жишээлбэл, Улаанбаатар хотод бусад аймгаас ажил хайж ирсэн хүмүүсийн зарим нь мөнгөгүйн улмаас бүртгүүлж чадахгүй, ажил олоогүйн улмаас аймаг руугаа буцаж явж байгаа.

<sup>1</sup>Шилжих хөдөлгөөний жилийн дундаж коэффициентийг тооцохын тулд хүн амын хоёр өөр тоог гаргаж авах хэрэгтэй. Нэг нь шилжих хөдөлгөөний нөлөөг оруулсан, нөгөө нь оруулаагүй. Шилжих хөдөлгөөнд ороогүй хүн ам, шилжин явагсдын нийлбэр онолын хувьд шилжих хөдөлгөөнийг оруулаагүй хүн ам болж, шилжих хөдөлгөөнд ороогүй хүн ам, шилжин ирэгсдийн нийлбэр шилжих хөдөлгөөний нөлөөг оруулсан хүн ам болно.

Тооллогын үед зургаан сарын дотор аймаг руугаа буцахгүй гэсэн хүмүүсийг сүүлийн нэг жилийн шилжих хөдөлгөөнд оруулж авсан. Шилжих хөдөлгөөний байдлаас үзэхэд шилжигсдийн тоонд тодорхой бус түр хугацаагаар ирсэн хүмүүс, үүний дотор таван жилийн хугацаанд нутаг руугаа буцаж болзошгүй шилжигсдийг оруулж, энд хамрагдах хүний тоог нэмэгдүүлж байгаа учир түүнийг таван жилийн шилжих хөдөлгөөнтэй шууд харьцуулах боломжгүй юм.

Хүснэгт 5.9. Сүүлийн нэг жилийн шилжих хөдөлгөөн, бус нутгаар, 2000 он						
Бус нутаг	Сүүлийн нэг жилд					
	Бүгд	Шилжих хөдөлгөөнд ороогүй	Шилжин ирэгсэд <sup>1</sup>	Шилжин явагсад	Цэвэр шилжих хөдөлгөөн	
Бүгд	2373493	2308538	64955	64955	0	
Төвийн	750470	728357	15007	22113	-7106	
Зүүн	207314	200358	2127	6956	-4829	
Баруун	523403	504043	2344	19360	-17016	
Өмнөд	162656	157688	3492	4968	-1476	
Улаанбаатар	727399	718092	41985	9307	32678	
Гадаад	2251	ГБ	ГБ	2251 <sup>2</sup>	-2251	

<sup>1</sup>гадаадаас шилжин ирэгсэд энд орсон

<sup>2</sup>гадаадаас Монгол Улсад шилжин ирэгсэд

ГБ-тооллоогор гадаадад төрсөн, гадаадад амьдарч байгаа хүмүүсийг тоолоогүй

Сүүлийн нэг жилийн шилжих хөдөлгөөний тоо мэдээ нь Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөний шинж төрхийг мөн баталж байна. Тооллогын үеийн хүн амын төрснөөс хойши шилжих хөдөлгөөний урсгалын чиглэл сүүлийн нэг жилд ч хадгалагдаж байгаа нь тодорхой байна. Хүн амаа ихээр гадагш алдаж байгаа бус нутагт Баруун бус нутаг, түүний дараа Зүүн бус нутаг орж байна. Төвийн бус нутгаас хүн ам шилжин явахаасаа илүү ирж суурьшиж байгаа тул уг бус нутгийн шилжих хөдөлгөөний төрх олон талаараа бусад бус нутгийнхаас ялгаатай юм. Жишээлбэл, сонирхуулж тэмдэглэхэд Төвийн бус нутгаас бусад бус нутаг руу шилжин явагсад, Төвийн бус нутаг руу бусад бус нутгаас шилжин ирэгсдээс гадна 9355 хүн энэ бус нутаг дотор аймаг хоорондын шилжих хөдөлгөөнд орсон байна. **Хавсралт 1-ийн Хүснэгт 8-д** сүүлийн нэг жилийн шилжих хөдөлгөөнийг аймаг, нийслэлээр, хүйсээр харуулав.

Улаанбаатар хотын хүн амын өсөлт тасралтгүй үргэлжилсэн шилжин ирэгсдээс хангагдаж байна. Тооллогын өмнөх нэг жилд Улаанбаатар хотын хүн амын өсөлт ямар байсныг хэлэхэд хүндрэлтэй. Улаанбаатар хотын хүн амын өсөлт нь гадаад шилжих хөдөлгөөнийг тооцохгүйгээр, харин мэдээжээр дотоод шилжих хөдөлгөөнөөс дөрвөөс дээш хувийн өссөн гэж үзээд мөн ердийн цэвэр өсөлтийг оруулаад таваас дээш хувь болохоор байна. Гэхдээ гадаад шилжих хөдөлгөөн өсч байгаа бөгөөд гадаадад явж байгаа хүний дийлэнх нь Улаанбаатар хотоос явж байгаа юм. Улаанбаатар хотын хүн амын өсөлт өндөр хэвээр байна гэж хэлж

болно. Монгол Улсын, мөн Улаанбаатар хотын хүн амын суурьшлын төрх хэлбэрт дотоод шилжих хөдөлгөөн мэдэгдэхүйц нөлөө үзүүлсээр байна.

**Хүснэгт 5.10. Хүн амын тоо, сүүлийн нэг жилд болон тооллогын үед байнга оршин сууж байсан газраар, 2000 он**

Жилийн өмнө байнга сууж байсан газар	Тооллогын үед байнга оршин сууж байсан газар						Шилжин явагсад
	Бүгд	Төвийн	Зүүн	Баруун	Өмнөд	Улаанбаатар	
Бүгд	2373493	743364	202485	506387	161180	760077	-
Төвийн	750470	728357	541	538	1178	19856	22113
Зүүн	207314	779	200358	16	619	5542	6956
Баруун	523403	7051	160	504043	346	11803	19360
Өмнөд	162656	882	411	71	157688	3604	4968
Улаанбаатар	727399	5872	958	1154	1323	718092	9307
Гадаад	2251	423	57	565	26	1180	2251 *
<b>Шилжин ирэгсэд</b>	<b>-</b>	<b>15007</b>	<b>2127</b>	<b>2344</b>	<b>3492</b>	<b>41985</b>	<b>64955</b>

\*годаадаас Монгол Улсад шилжин ирэгсэд

**Хүснэгт 5.10-т өнгөрсөн жилд шилжих хөдөлгөөнд оролцогсдын урсгалыг бус нутгаар харуулав. Нийтдээ 64955 хүн өнгөрсөн жилд бус нутаг хооронд шилжин суурьшжээ.**

**Хүснэгт 5.11. Хүн амын эзлэх хувь, сүүлийн нэг жилд болон тооллогын үед байнга оршин сууж байсан газраар, 2000 он**

Жилийн өмнө байнга сууж байсан газар	Тооллогын үед байнга оршин сууж байсан газар					
	Бүгд	Төвийн	Зүүн	Баруун	Өмнөд	Улаанбаатар
<b>A. Бүгд</b>	<b>100.0</b>	<b>31.3</b>	<b>8.5</b>	<b>21.4</b>	<b>6.8</b>	<b>32.0</b>
Төвийн	100.0	97.0	0.1	0.1	0.2	2.6
Зүүн	100.0	0.4	96.6	0.0	0.3	2.7
Баруун	100.0	1.3	0.0	96.3	0.1	2.3
Өмнөд	100.0	0.5	0.3	0.1	96.9	2.2
Улаанбаатар	100.0	0.8	0.1	0.2	0.2	98.7
Гадаад	100.0	18.8	2.5	25.1	1.2	52.4
	<b>Бүгд</b>	<b>Төвийн</b>	<b>Зүүн</b>	<b>Баруун</b>	<b>Өмнөд</b>	<b>Улаанбаатар</b>
<b>B. Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Төвийн	31.6	98.0	0.3	0.1	0.7	2.6
Зүүн	8.7	0.1	98.9	0.1	0.4	0.7
Баруун	22.1	0.9	0.1	99.5	0.2	1.5
Өмнөд	6.9	0.1	0.2	0.0	97.8	0.5
Улаанбаатар	30.6	0.8	0.5	0.2	0.8	94.5
Гадаад	0.1	0.1	0.0	0.1	0.1	0.2

**Хүснэгт 5.11-ийн эхний хэсэгт сүүлийн нэг жилийн шилжигсдийг өмнө нь оршин сууж байсан газар, дүнд эзлэх хувиар харуулав. Өнгөрсөн жилд**

Улаанбаатар хотод байнга оршин сууж байсан бүх хүний 98.7 хувь нь Улаанбаатар хотод үлдэж, зөвхөн 1.3 хувь нь бусад бүс нутагт шилжин явжээ. Эдгээрийн дийлэнх нь (63.1%) Төвийн бүс нутагт шилжсэн байна. Харин өнгөрсөн жилд Баруун бүс нутагт байнга оршин сууж байсан бүх хүн амын 96.3 хувь нь Баруун бүс нутагтаа үлдэж, 3.7 хувь нь бусад бүс нутагт шилжин суурьшсан байна. Баруун бүс нутгаас сүүлийн нэг жилийн хугацаанд бусад бүс нутагт шилжигсдийн 61.0 хувь нь Улаанбаатар хотод, 36.4 хувь нь Төвийн бүс нутагт шилжин суурьшжээ. Бүс нутаг бүрээс шилжин явагсдын ихэнхи нь, тухайлбал Төвийн бүсийн 89.8, Зүүн бүсийн 79.7, Өмнөд бүсийн 72.5, Баруун бүсийн 61.0 хувь нь тус тус Улаанбаатар хотод шилжин суурьшжээ.

**Хүснэгт 5.11-ийн** хоёр дахь хэсэгт өнгөрсөн жилийн шилжигсдийн урсгалыг 2000 онд байнга оршин сууж байсан газар, дүнд эзлэх хувиар харуулав. 2000 оны тооллогоор Улаанбаатар хотод байнга оршин сууж байсан бүх хүн амын 94.5 хувь нь өмнө байнга оршин сууж байсан бол 5.5 хувь нь бусад бүс нутгаас Улаанбаатарт шилжин иржээ. Өнгөрсөн жилд Улаанбаатар хотод шилжин ирсэн бүх хүний 47.3 хувь нь Төвийн, 13.2 хувь нь Зүүн, 28.1 хувь нь Баруун, 8.6 хувь нь Өмнөд бүс нутгаас, 2.8 хувь нь гадаадаас шилжин иржээ. Таван жилийн шилжих хөдөлгөөний нэг адил, өнгөрсөн жилд хамгийн олон шилжин ирэгсдийг хүлээн авсан бүс нутагт Улаанбаатар, Төвийн болон Өмнөд бүс нутаг багтаж байна. 2000 оны тооллогоор Төвийн бүс нутагт тоологдсон бүх хүн амын 98.0 хувь нь сүүлийн нэг жилд Төвийн бүс нутагтаа амьдарч байсан бол 0.9 хувь нь Баруун бүс, 0.8 хувь нь Улаанбаатар хотоос тус тус шилжин ирсэн байна. Төвийн бүс нутагт шилжин ирэгсдийн дийлэнхи нь Баруун бүс, Улаанбаатар хотоос шилжин ирсэн байхад, Өмнөд бүс нутагт шилжин ирэгсдийн дийлэнхи нь Төвийн бүс нутаг болон Улаанбаатар хотоос шилжин ирсэн байна. Өнгөрсөн жилд Өмнөд бүс нутагт шилжин ирсэн бүх хүн амын 33.7 хувь нь Төвийн, 17.7 хувь нь Зүүн, 9.9 хувь нь Баруун бүс нутгаас, 37.9 хувь нь Улаанбаатар, 0.7 хувь нь гадаадаас шилжин иржээ. 2000 оны тооллогын үед байнга оршин сууж байсан газраар авч үзэхэд, таван жилийн шилжих хөдөлгөөнд Улаанбаатар хотын дараа Төвийн бүс шилжигсдийг хамгийн их татсан бүс нутаг байсан бол өнгөрсөн жилийн шилжих хөдөлгөөнд Өмнөд бүс Улаанбаатар хотын дараа орж байна. Гэхдээ шилжин ирэгсдийн тоог авч үзвэл Төвийн бүсэд шилжин ирэгсдийн тоо Өмнөд бүс нутгийнхаас олон байна (**Хүснэгт 5.10**).

### Шилжигсдийн шинж төрх


Энэ хэсэгт шилжигсдийн зөвхөн нас, хүйсийн бүтцийн талаар дурдлаа. Шилжигсдийн талаархи үзүүлэлтүүдийг тайлбарлахаас өмнө шилжих хөдөлгөөний тодорхойлолттой холбоотойгоор шилжих хөдөлгөөний нөхцлийг урьдчилан тодорхойлох хэрэгтэй. Шилжих хөдөлгөөний хугацаа, орон зай өөрчлөгдөхөд шилжигсдийн шинж төрх мөн өөрчлөгднө. Өөр нэг анхаарал хандуулах шаардлагатай зүйл бол шилжин очиж байгаа газарт байнга оршин суух хугацааны үзүүлэх нөлөө юм. Шилжигсэд шилжин очиж байгаа газраа удаан хугацаагаар оршин суувал түүний талаархи шинж төрхүүд, жишээлбэл орон сууц, боловсрол, ажил эрхлэлт зэрэг үзүүлэлтүүд өөрчлөгдөх юм.

**Хүснэгт 5.12. Сүүлийн нэг жилд шилжигсэд, насны бүлэг, хүйсээр, 2000 он**

Насны бүлэг	Шилжигсэд						Нийт хүн ам	
	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд			
	мян. хүн	Дүнд эзлэх хувь	мян. хүн	Дүнд эзлэх хувь	мян. хүн	Дүнд эзлэх хувь		
<b>Бүгд</b>	<b>42.9</b>	<b>100.0</b>	<b>36.1</b>	<b>100.0</b>	<b>79.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	
0-4	2.5	5.8	2.5	6.9	5.0	6.3	10.4	
5-9	3.4	7.9	3.4	9.4	6.8	8.7	12.1	
10-14	3.4	7.9	3.5	9.7	6.9	8.6	13.4	
15-19	9.4	21.9	7.4	20.5	16.8	21.3	11.2	
20-24	9.0	21.0	5.9	16.3	14.9	19.0	10.0	
25-29	4.3	10.0	3.7	10.3	8.0	10.1	9.0	
30-34	3.3	7.7	2.7	7.5	6.0	7.6	7.8	
35-39	2.5	5.9	2.0	5.5	4.5	5.7	7.2	
40-44	1.7	4.0	1.4	3.9	3.1	3.9	5.3	
45 +	3.4	7.9	3.6	10.0	7.0	8.8	13.6	

Шилжих хөдөлгөөнд оролцсон эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс бараг долоон мянгаар илүү байгаа нь эрэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд давамгайлж байгааг харуулж байна. Зураг 5.4-т харуулснаар эрэгтэйчүүдийн давамгайлах явдал шилжих хөдөлгөөнд хамгийн өртөмтгийн нас болох 15-25 насанд их байна.


**Зураг 5.4. Сүүлийн нэг жилд шилжигсэд, насны бүлэг, хүйсээр, 2000 он**



Зураг 5.5-с хараад шилжих хөдөлгөөнд аль насныхан давамгайлж байгаа нь ойлгомжтой байна. Нийт хүн амтай харьцуулахад 15-19 насны хүмүүсийн шилжин суурьшилт хамгийн өндөр байгаа нь сургуульд үргэлжлүүлэн суралцах хэрэгцээтэй холбоотой нь тодорхой юм. Тооллогоор цэрэг, хоригдолыг байгаа аймгийн хүн амд нь оруулсан учраас шилжих хөдөлгөөнд тодорхой нөлөө үзүүлж байгаа юм. Сүүлийн

нэг жилд ийм шалтгаанаар залуу насны эрэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд илүү хэмжээгээр орсон байж болно. 20-25 насны хувьд боловсрол мён чухал хүчин зүйл болох талтай. Гэхдээ шилжин очиж байгаа газарт ажил олдох боломжтой байдаг нь бас нэг шалтгаан болно.


### Зураг 5.5. Нийт хүн ам болон шилжигсдийн эзлэх хувь, насны бүлгээр, 2000 он



### Хотжилт

Хотжилтын ойлголт шилжих хөдөлгөөний судалгаатай маш их уялдаа, холбоотой юм. Шилжих хөдөлгөөнд оролцогсдын ихэнхи хэсэг боловсролоо дээшлүүлэх, ажил эрхлэх боломж олох зэргээр хот, суурин газрыг зорьдог. **Тиймээс ч хот, суурин газрын хүн амын өсөлтийн нилээд хэсгийг шилжих хөдөлгөөн бурдүүлж байна.**

### Зураг 5.6. Улаанбаатар хот уруу цэвэр шилжин ирэгсэд, бүс нутгаар, мян.хүн, 1995-2000 он




Улаанбаатар хот бол Монгол Улсын хамгийн том хот юм. Тооллогоос таван жилийн өмнө ямар нэг газар оршин сууж байсан 2127.5 мянган хүний 149.1 мянга нь Улаанбаатар хот болон бусад бус нутгийн хооронд шилжих хөдөлгөөнд орсон байна. Эдгээрийн 64.0 хувь буюу 95.4 мянган хүн Улаанбаатар хотод шилжин ирсэн нь хот руу шилжих хөдөлгөөн их байгааг харуулж байна. Бусад бус нутгаас, ялангуяа Баруун болон Зүүн бус нутгаас нийслэл хот руу чиглэсэн урсгалыг **Зураг 5.6**-аас харж болно.

Бус нутгийн түвшинд нэгтгэн харуулсан энэ зураг явагдаж ирсэн, мөн явагдаж байгаа хотжилтын үйл явцыг харуулахад учир дутагдалтай байж болно. Бус нутаг дотроо хамгийн хотжсон аймаг руу шилжих хөдөлгөөн хотжих үйл явцын нэг хэсэг мөн юм. Мөн аймаг дотор ч хотын хөгжил, тэндхийн таатай нөхцөл, бололцоонд татагдан sumaас аймгийн төв рүү шилжих хөдөлгөөн байгаа нь илт тодорхой юм.

Хотжилтод шилжих хөдөлгөөний үзүүлсэн нөлөөг **Зураг 5.7**-оос харж болно. Улаанбаатар хотын хүн амын хурдан өсөлт Монгол Улсын бусад бус нутгаас шилжин ирэгсдээс шалтгаалж байгаа нь тодорхой. Үүнээс гадна хотжилтын үр дүнд бусад хот, суурин газрын хүн ам өссөн байна. Хот, суурин газар, жишээлбэл Монгол Улсын төмөр замын дагуу орших хот, тосгоны хүн ам өсч, хотжилтын үйл явц явагдаж байгаа нь харагдаж байна. Нийслэл хотоос гадна Өмнөд бус нутагт орших Дорноговь аймаг, Төвийн бүсийн хойд хэсгийн Дархан-Уул, Орхон аймаг тухайн нутаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөн ихтэй аймагт орж байна. Дорноговь аймаг БНХАУ-тай хиллэдэг бөгөөд түүний нутаг дэвсгэрээр төмөр зам дайрч өнгөрдөг. Хилийн боомт хот Замын-Үүд бус нутгийн хамгийн тохиромжтой худалдааны төв болон өргөжсөөр байна.

### **Зураг 5.7. Шилжих хөдөлгөөний жилийн дундаж коэффициент, аймаг, нийслэлээр, 1995-2000 он**



Монгол Улсын хойд хэсэгт ижил төрлийн нөхцөл байдал үүссэн байна. Дархан-Уул аймаг Улаанбаатар хотоос гадна хүн ам нь өсч байгаа цөөн газрын нэг юм. Дархан-Уул аймаг, түүнтэй зэргэлдээ оршдог Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрээр Монгол Улс, Оросын Холбооны Улсыг холбосон төмөр зам дайран өнгөрдөг. Орхон аймагт хүмүүс олноор шилжин ирж суурьшсан нь ажиглагдаж байна. Орхон аймгийн төв болох Эрдэнэт хот олон улсын төмөр зам дайран өнгөрдөггүй ч дотоодын төмөр замаар Улаанбаатартай холбогддог.

## Бүлэг 6: БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Тооллогоор боловсролын талаархи мэдээллийг цуглуулж авах нь хамгийн чухал байдаг. Боловсрол бол үндэсний хүний хүчин чадавхийг хөгжүүлэх зарчмын чухал хэрэглүүр юм. Тийм ч учраас энэ нь зөвхөн боловсрол төдийгүй, ажиллах хүч, шилжих хөдөлгөөн, орон сууц зэрэг үндэсний төлөвлөлтийн бусад сэдвүүдийг судлахад чухал үзүүлэлт болдог.

Хүн амын сүүлийн хэдэн тооллогод боловсролын талаархи асуулт бусад үзүүлэлтийг бодвол их өөрчлөгдөөгүй байна. 2000 оны тооллогоор хоёр асуулт асуусан. Эхний асуулт эзэмшсэн боловсролын дээд түвшинтэй холбоотой. Энэ асуултыг 7, түүнээс дээш насны бүх хүмүүсээс асуусан. Хоёр дахь асуулт бол 7-29 насны бүх хүмүүсээс тооллогын үед боловсрол олгох ямар нэг шатны сургуульд суралцаж байсан эсэхийг асуусан.

1995 оны 6-р сарын 22-нд батлагдсан “Бага, дунд боловсролын тухай” Монгол Улсын хуулинд бага боловсролыг 4, суурь боловсролыг 8, бүрэн дунд боловсролыг 10 жилд тус тус эзэмшигүүлнэ, мөн түүнчлэн техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшигүүлэх хугацаа нь боловсролын түвшин, мэргэжлийн ялгаа онцлогоос хамааран 1-4 жил байна гэж заажээ. 1995 оны 6-р сарын 22-нд батлагдаж, 1998 оны 7-р сарын 23-нд шинэчлэн найруулсан “Дээд боловсролын тухай” Монгол Улсын хуулиар дээд боловсрол эзэмшигүүлэх дипломын сургалт 90 кредит цагаас доошгүй байх бөгөөд өмнөх сургалтын кредит цагийг оролцуулан тооцон бакалаврын сургалт 120 кредит цагаас, магистрын сургалт 150 кредит цагаас, докторын сургалт 210 кредит цагаас тус тус доошгүй байна.

### Боловсролын түвшин

Боловсролын түвшинг тухайн хүний эзэмшсэн боловсролын дээд түвшингээр авсан. 1989, 2000 оны тооллогын боловсролын ангилал ижил биш ч гэсэн хариултын ангиллуудыг нэгтгэж арав, түүнээс дээш насны хүмүүсийг харьцуулсан хүснэгт гаргав. Бага боловсрол эзэмшээгүй хүмүүсийг боловсролгүй хүн амд оруулсан.

Хүснэгт 6.1. Арав, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь, боловсролын түвшин, хүйсээр, 1989 болон 2000 он

Боловсролын түвшин	1989			2000		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	9.8	13.8	11.8	11.7	11.5	11.6
Боловсролтой	90.2	86.2	88.2	88.3	88.5	88.4
Бага боловсролтой	29.7	31.2	30.5	23.8	23.1	23.4
Дунд, техник мэргэжлийн	46.4	39.4	42.9	51.3	48.3	49.8
Тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд	6.1	9.7	7.8	5.7	9.4	7.6
Дээд	8.0	5.9	7.0	7.6	7.7	7.6

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг хамтад нь авч үзэхэд 10, түүнээс дээш насны хүмүүсийн боловсрол сайжирсан мэт харагдаж байна. **Хүснэгт 6.1**-ээс харахад дээд боловсролтой хүмүүсийн эзлэх хувь 1989 онд 7.0 байснаа 2000 онд 7.6 хувь болж өсч, харин боловсролгүй хүмүүсийн эзлэх хувь 11.8 хувиас 11.6 хувь хүртэл, бага боловсролтой хүмүүсийн эзлэх хувь 30.5 хувиас 23.5 хувь хүртэл буурсан байна. Энэ хоёр өөрчлөлт хоёулаа боловсролын түвшин сайжирсныг харуулж байна. Гэхдээ өмнөх тооллогоос хойш нас барсан хүмүүс өмнөх тооллогын үед өндөр насны бүлэгт багтаж байсан гэдгийг ойлгох хэрэгтэй. Мөн өндөр насны хүмүүс харьцангуй бага боловсролтой байсан гэдэг нь харагдана. Тийм учраас, өнгөрсөн арван жилд нас дэвшилтээс шалтгаалан боловсрол багатай настайчуудыг түрж, боловсрол сайтай залуучууд орж ирж байгаагаар боловсролын тувшний ерөнхий байдал сайжирсныг тайлбарлаж болно.

1989 онд боловсролгүй эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийг бодвол илүү байсан байна. Харин 1989-2000 онд боловсролгүй эмэгтэйчүүдийн эзлэх хувь буурч, боловсролгүй эрэгтэйчүүдийн эзлэх хувь өсч 2000 он гэхэд ижил түвшинд хүрчээ. Мөн хугацаанд, ялангуяа эмэгтэйчүүдийн дунд бага боловсролтой хүмүүсийн эзлэх хувь буурч, дээд боловсролтой хүмүүсийн эзлэх хувь өссөн байна. **Хавсралт 1-ийн Хүснэгт 9**-д долоо, түүнээс дээш насны хүн амын боловсролын тувшиг аймаг, нийслэлээр харуулав.

2000 оны байдлаар боловсролын бүх тувшиг авч үзэхэд бага, дунд, техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшсэн эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс ялигүй илүү байна. Харин боловсролын өндөр түвшинд, тухайлбал тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд, дээд боловсролын түвшинд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс илүү байна. Тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд боловсролтой 88 мянган эмэгтэй байхад 52 мянган эрэгтэй байна. Ийнхүү эмэгтэйчүүд давамгайлсан байдал дээд боловсролтой хүмүүсийн хувьд байгаа ч тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд боловсролын түвшинд хүрэхгүй байна. Тооллогоор 71 мянга гаруй эмэгтэйчүүд, 69 мянга хүрэхгүй эрэгтэйчүүд дээд боловсролтой гэсэн дүн гарсан байна (**Хавсралт 1-ийн Хүснэгт 10**-ыг харна уу).

Хүснэгт 6.2. Арав, түүнээс дээш насны хүн ам, боловсролын тувшин, хүйс, байршил, дунд эзлэх хувиар, 2000 он									
Боловсролын түвшин	Хот			Хөдөө			Бүгд		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	8.5	8.4	8.4	16.0	16.1	16.1	11.7	11.5	11.6
Бага	17.3	17.6	17.5	32.6	31.2	31.9	23.8	23.1	23.5
Дунд, техник мэргэжлийн болон тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд	62.5	62.3	62.4	49.4	51.0	50.2	56.9	57.7	57.3
Дээд	11.7	11.7	11.7	2.0	1.7	1.8	7.6	7.7	7.6

Боловсролын бүх тувшин хот, хөдөөгөөр ялгаатай байсан бөгөөд энэ ялгаа боловсролын өндөр түвшинд бүр их байсан (**Хүснэгт 6.2**-ыг харна уу). Боловсролгүй, бага боловсролтой эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тоо хөдөөд хотынхаас бараг хоёр дахин олон байна. Дунд, техник мэргэжлийн болон тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд боловсролын түвшинд хот хөдөөгийн ялгаа бага, эрэгтэйчүүдийн хувьд 13.1 пүнкт, эмэгтэйчүүдийн хувьд 11.3 пүнкт байна.

**Хүснэгт 6.2** хотод боловсролын тувшин хүйсийн хувьд төдийлөн ялгаагүй байгааг харуулж байна. Харин хөдөөд дунд, техник мэргэжлийн болон тусгай

мэргэжлийн дунд, бүрэн бус дээд боловсролтой эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс олон байгаа ч ялгаа нь бага байна.

**Хүснэгт 6.3-т** 2000 оны тооллогын арав, түүнээс дээш насны хүн амыг боловсролын түвшин, насны бүлэг, дунд эзлэх хувиар, харуулав.

**Хүснэгт 6.3. Арав, түүнээс дээш насны хүн ам, боловсрольн түвшин, насны бүлэг, дунд эзлэх хувиар, 2000 он**


Насны бүлэг	Боловсролгүй	Бага боловсролтой	Бүрэн бус, бүрэн дунд	ТМД болон тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд	Дээд	Бүгд
<b>Бүгд</b>	<b>11.6</b>	<b>23.5</b>	<b>46.1</b>	<b>11.2</b>	<b>7.6</b>	<b>100.0</b>
10-14*	41.0	57.5	1.5	-	-	100.0
15-19	7.7	28.3	63.1	0.9	-	100.0
20-24	2.7	12.2	72.0	6.8	6.3	100.0
25-29	1.8	4.1	67.1	17.7	9.3	100.0
30-34	2.2	4.4	61.4	21.4	10.6	100.0
35-39	2.7	7.4	54.0	21.4	14.5	100.0
40-44	2.3	12.7	48.9	20.9	15.2	100.0
45-49	2.8	18.7	42.3	20.8	15.4	100.0
50-54	3.8	23.7	36.0	18.9	17.6	100.0
55-59	7.9	33.6	29.0	14.5	15.0	100.0
60 +	25.8	41.8	16.6	8.0	7.8	100.0

\*10-12 насны хүүхдүүд бага сургуульд суралцаж байгаа.

Боловсролын түвшинг насаар авч үзэхэд зарим сонирхолтой дүр зургийг харуулж байна. Насны бүлэг бол түүхийн хугацааг ойролцоогоор харж болох үзүүлэлт юм. Насны бүлэг бол түүхийн хугацааны өмнө боловсрол эзэмшсэн байна гэсэн үг. Ихэнхи тохиолдолд 60, түүнээс дээш насны хүмүүс хамгийн наад зах нь 30 жилийн өмнө боловсрол олж авсан байгаа. Өндөр насны хүмүүсийн боловсролын түвшин ерөнхийдөө доогуур, тэдний гуравны хоёр нь бага боловсролтой байгаа нь бага боловсрол тухайн үеийн боловсролын хамгийн түгээмэл түвшин байсныг харуулж байна. Боловсролын дундаж түвшин тогтмол өсч 25-29 насны бүлэгт хамгийн өндөр болсон байна. Эдгээр насны хүмүүсийн бараг 94 хувь нь багаас дээш боловсролтой, эсвэл дунд сургуулийн дараах мэргэжил олгох сургууль төгссөн байна.

Залуучуудын боловсролын түвшин буурсаар байна. 1990 онд эхэлсэн мал хувьчлал олон хүүхдийн, ялангуяа хөвгүүдийн сургуульд хамрагдалтад сөрөг нөлөө үзүүлсэн юм. 20-24 насны залуучуудын 15 хувь нь боловсролгүй эсвэл бага боловсролтой гэж хариулсан байна. 15-19 насны хүн амын 64 хувь нь бүрэн бус болон бүрэн дундаас дээш боловсролтой боловч 36 хувь нь бага боловсролтой эсвэл боловсролгүй байгаа нь анхаарал татах асуудлын нэг юм. Харин 10-14 насны хүүхдүүдийн хувьд байдал өөр юм. Учир нь 10-12 насны бага сургуульд суралцаж байгаа хүүхдүүд боловсролгүй гэсэн бүлэгт хамрагдаж байгаа юм.

### Зураг 6.1. Дээд боловсролтой хүн амын эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр, 2000 он



Одоогийн байдлаар дээд боловсрол эзэмших нь эмэгтэйчүүдийн хувьд эрэгтэйчүүдийнхээс илүү байгааг өмнө дурдсан. Энэ байдал үргэлж хадгалагдаж байгаагүй нь Зураг 6.1-ээс харагдаж байна. Энэ зураг цаг хугацааны явцад бий болсон хоёр өөрчлөлтийг үзүүлж байна. Эхний өөрчлөлт болох боловсролын түвшин сүүлийн үед, ялангуяа сүүлийн арван жилд буурч байгааг насны бүлэг дэх хувиарлалтын ерөнхий төрх баталж байна. Жишээлбэл, эрэгтэйчүүдийн хувьд 50-54 насныхны 22,3 хувь нь дээд боловсрол эзэмшсэн нь хамгийн өндөр байна. Энэ хувь нь түүнээс бага насны эрэгтэйчүүдийн хувьд үргэлжлэн буурч, тухайлахад 30-34 настай эрэгтэйчүүдийн арав хүрэхгүй хувь нь дээд боловсрол эзэмшжээ. 30-34 наснаас залуу насны эрэгтэйчүүдийн боловсролын түвшин буурах хандлагатай байгаа хэдий ч тэдний олонхи нь одоогоор дээд сургууль, коллежид суралцаж байж болох учир үр дүнг бүрэн гүйцэд тайлбарлах боломжгүй юм.


Хоёр дахь өөрчлөлт нь эмэгтэйчүүдийн давуу байгааг харуулсан хүйсийн ялгаатай байдалтай холбоотой. Зураг 6.1-ээс харахад өнгөрсөн 30 жилд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн боловсролын байдал хоорондоо ялгаатай байгаа нь тодорхой байна. Зурагт үзүүлсэн хугацааны эхний арван жилд эрэгтэйчүүдийн хувьд боловсролын түвшин дээшилж байсан үе байв. Боловсролын түвшингийн хүйсийн ялгаатай байдал өндөр настай хүмүүсийн хувьд их байсан бөгөөд энэ нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алиных нь бараг ижил түвшинд дээшлэх хүртэл хадгалагдсаар байсан. 50-иас доош настай хүмүүсийн хувьд өөрчлөлтийн төрх байдал өөр болж эхэлсэн. Эмэгтэйчүүдийн боловсролын түвшингийн дээшлэлт эрэгтэйчүүдийнхийг бодвол илүү хурдан байв. 15 жилийн туршид, өөрөөр хэлбэл 35-54 насны хүмүүсийн дунд дээд боловсрол эзэмшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь өсч, харин эрэгтэйчүүдийнх буурсаар иржээ. Өндөр настай хүмүүсийн хувьд дээд боловсрол эзэмшсэн эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс өндөр байсан, харин залуучуудын хувьд байдал эсэргээр эргэж дээд боловсрол эзэмшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс давсан огтлолцол 40-44 насны бүлэгт байна.

Эндээс ажигласнаар өнгөрсөн арван жилд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алиных нь боловсролын түвшин буурсан байна. Эмэгтэйчүүдийн боловсролын түвшингийн бууралт эрэгтэйчүүдийнхээс харьцангуй бага байгаа нь хүйсийн ялгаатай байдалд эмэгтэйчүүдийн давуутай талыг улам нэмэгдүүлж байна.

## Бичиг үсгийн мэдлэг

Бичиг үсгийн мэдлэгийн тодорхойлолтын талаархи НҮБ-ын зөвлөмжийг 2000 оны тооллогод үндсэнд нь баримталсан юм. Аль нэг хэлээр энгийн өгүүлбэрийг ойлгоцтойгоор уншиж, бичиж чаддаг хүнийг бичиг үсэг мэддэг хүн гэж үзсэн. 2000 оны тооллогод бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшингийн асуултыг тусад нь асуусан. Гэхдээ бичиг үсгийн мэдлэгийн асуултыг зөвхөн боловсролгүй буюу бага боловсрол эзэмшээгүй хүмүүсээс асуусан. Тооллогоор асуусан боловсрол, бичиг үсгийн мэдлэгийн талаархи асуултыг **зураг 6.2-т** харуулав.

### Зураг 6.2. Бичиг үсгийн мэдлэгийн талаархи асуулт, 2000 он



Бичиг үсгийн мэдлэгийн талаархи асуултыг долоо, түүнээс дээш насын бүх хүмүүсээс асуусан юм. Олон улсын жишгээр 15, түүнээс дээш насын хүн амын бичиг үсгийн мэдлэгийн байдлыг **Хүснэгт 6.4-т** харуулав.

**Хүснэгт 6.4. Арван тав, түүнээс дээш насын хүн амын бичиг үсгийн мэдлэг, байршил,  
хүйсээр, 2000 он**


Бичиг үсгийн мэдлэг	Хүйс				Байршил				Бүгд	
	Эрэгтэй		Эмэгтэй		Хот		Хөдөө			
	мян.хүн	эзлэх хувь	мян.хүн	эзлэх хувь	мян.хүн	эзлэх хувь	мян.хүн	эзлэх хувь		
Бүгд	749.9	100.0	774.5	100.0	898.7	100.0	625.7	100.0	100.0	
Бичиг үсэг мэддэг	735.0	98.0	755.4	97.5	888.4	98.9	602.0	96.2	97.8	
Бичиг үсэг мэддэггүй	14.9	2.0	19.1	2.5	10.3	1.1	23.7	3.8	2.2	

Монгол Улсын 15, түүнээс дээш насын хүн амын 97,8 хувь нь бичиг үсэг мэдэж байгаа нь олон улсын стандартаар авч үзэхэд өндөр байна. Бичиг үсгийн мэдлэгийн хувьд хүйсийн ялгаа их биш байгаа бөгөөд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алиных нь гурваас бага хувь нь бичиг үсэг мэддэггүй байна. Харин хот, хөдөөгийн хувьд ялгаа их байгаа юм. Хотын бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь хөдөөгийнхөөс гурав дахин бага бөгөөд хотын

15, түүнээс дээш насны хүн амын ойролцоогоор нэг хувь нь бичиг үсэг мэдэхгүй байна.

Бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувийг насаар авч үзэхэд боловсролын түвшингийн байдалтай ижил дүгнэлт гарч байна. 55, түүнээс дээш насандаа бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь харьцангуй өндөр, ялангуяа 60, түүнээс дээш насандаа 9 хувиас илүү байна. Энэ нь гуч гаруй жилийн өмнө албан ёсны боловсрол эзэмшиж хүмүүсийн төрх байдлыг харуулж байна. 20-24-өөс 50-54 насандаа буюу энэ 30 жилийн хугацаанд бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь харьцангуй бага хэлбэлзлэлтэй байв. Гэхдээ 15-19 насны бүлэгт бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь харьцангуй өндөр болж 3-аас илүү хувьд хүрч, залуучуудын дунд бичиг үсэг үл мэдэх явдал газар авч эхэлснийг харуулав. Энэ нь бодлого боловсруулагчид, төлөвлөгчдийн санаа зовох асуудлын нэг болж байна.

### Зураг 6.3. Арван тав, түүнээс дээш насны хүн амд бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь, насны бүлгээр, 2000 он



Арав, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэгийн байдлыг насны бүлэг, хүйс, байршилаар **Хавсралт 1-ийн Хүснэгт 11-д**, аймаг нийслэл, хүйсээр **Хавсралт 1-ийн Хүснэгт 12-т** харуулав.

### Сургуульд суралцаж байгаа эсэх

7-29 насны бүх хүмүүсийн 47,8 хувь нь ямар нэг шатны боловсрол олгох сургуульд суралцаж байна. Монгол Улсын “Бага, дунд боловсролын тухай” хуулиар ерөнхий боловсролын сургуульд найман настай хүүхдийг элсүүлэхээр заасан байдаг. **1998 оны 7-р сарын 23-нд хийгдсэн нэмэлт өөрчлөлтийн дагуу 6-7 насны хүүхдийг тодорхой нөхцөл, бололцоо бурдсэн тохиолдолд ерөнхий боловсролын сургуульд анги, бүлгээр элсүүлэн суралцуулж болно гэж заажээ. Хүснэгт 6.5-аас хараад найман настай бүх хүүхдийн 84,8 хувь сургуульд суралцаж байна. Сургуульд орох нас долоо, ес хоёрын хооронд хэлбэлзэж байна. Долоон настай хүүхдийн 29,4 хувь нь сургуульд суралцаж байгаа ба энэ хувь есөн насандаа 93,3 хувь болж өссөн байна.**

**Хүснэгт 6.5. 7-29 наасныхүн амьн сургуульд суралцаж байгаа эсэх, нас, хүйсээр, 2000 он**

Нас	Сургуульд суралцаагүй			Сургуульд суралцаж байгаа			Бүгд		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
	эзлэх хувь	эзлэх хувь	эзлэх хувь	эзлэх хувь	эзлэх хувь	эзлэх хувь	мян.хүн	мян.хүн	мян.хүн
7-29	<b>55.5</b>	<b>48.9</b>	<b>52.2</b>	<b>44.5</b>	<b>51.1</b>	<b>47.8</b>	<b>612.1</b>	<b>606.4</b>	<b>1218.5</b>
7	72.8	68.3	<b>70.6</b>	27.2	31.7	<b>29.4</b>	29.3	28.5	<b>57.8</b>
8	16.7	13.7	<b>15.2</b>	83.3	86.3	<b>84.8</b>	30.9	30.7	<b>61.6</b>
9	7.5	5.8	<b>6.7</b>	92.5	94.2	<b>93.3</b>	33.3	32.7	<b>66.0</b>
10	7.6	5.5	<b>6.6</b>	92.4	94.5	<b>93.4</b>	33.9	33.6	<b>67.5</b>
11	10.1	6.4	<b>8.2</b>	89.9	93.6	<b>91.8</b>	32.2	31.9	<b>64.1</b>
12	14.6	8.4	<b>11.6</b>	85.4	91.6	<b>88.4</b>	31.6	31.0	<b>62.6</b>
13	19.5	11.0	<b>15.2</b>	80.5	89.0	<b>84.8</b>	31.4	31.5	<b>62.9</b>
14	25.5	14.2	<b>19.9</b>	74.5	85.8	<b>80.1</b>	30.2	30.1	<b>60.3</b>
10-14	15.2	9.0	<b>12.1</b>	84.8	91.0	<b>87.9</b>	159.3	158.1	<b>317.4</b>
15	34.3	20.0	<b>27.2</b>	65.7	80.0	<b>72.8</b>	29.6	28.8	<b>58.4</b>
8-15	16.6	10.4	<b>13.5</b>	83.4	89.6	<b>86.5</b>	253.1	250.3	<b>503.4</b>
15-19	59.6	45.7	<b>52.7</b>	40.4	54.3	<b>47.3</b>	133.3	130.0	<b>263.3</b>
20-24	87.7	81.0	<b>84.4</b>	12.3	19.0	<b>15.6</b>	118.0	117.7	<b>235.7</b>
25-29	96.0	93.8	<b>94.9</b>	4.0	6.2	<b>5.1</b>	108.0	108.7	<b>216.7</b>

Сургуульд хамрагдалтын хувь 10 нааснаас эхлэн буурч байгаа нь анги дээшлэх тутам сургууль завсардалт өсч байгааг харуулж байна. Энэ үзүүлэлт 15 буюу бүрэн бус дунд боловсрол эзэмших насанд 72.8 хувь хүртэл буурсны дотор эрэгтэй хүүхдүүдийн хувьд бүр ч илүү буурч байгаа нь анхаарал татаж байна. Бүрэн бус дунд боловсролыг бүх нийтээр албан ёсоор эзэмших ёстой хэдий ч улсын хэмжээнд 2000 оны эхний байдлаар 8-15 насны 68.2 мяняган хүүхэд сургуульд суралцаагүйн 42.1 мянга буюу 61.7 хувь нь хөвгүүд, 26.1 мянга буюу 38.3 хувь нь охид байна. 10-14 насанд сургуульд суралцаж байгаа хүүхдийн эзлэх хувь 87.9 хувь байснаа 15-19 насны бүлэгт 47.3 хувь болж огцом буурсан нь энэ насны хүн ам бүрэн бус дунд боловсрол эзэмшиж, хөдөлмөрийн насанд орж байгаатай холбоотой (**16 нас бол суурь боловсрол эзэмших нас**). 20-24 насны бүлгийн бүх хүмүүсийн 15.6 хувь нь суралцаж байна.

Суралцагсад бүх насны бүлэгт хот, хөдөөд амьдарч байгаагаараа нилээд ялгаатай байна. Дүнгээр нь авч үзэхэд хотод амьдарч байгаа 7-29 насны бүх

**Хүснэгт 6.6. Сургуульд суралцаж байгаа 7-29 наасныхүн амьн эзлэх хувь, насын бүлэг, байршил, хүйсээр, 2000 он**


Нас	Хот			Хөдөө			Бүгд		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
<b>Бүгд</b>	<b>53.6</b>	<b>59.5</b>	<b>56.6</b>	<b>32.8</b>	<b>39.3</b>	<b>35.9</b>	<b>44.5</b>	<b>51.1</b>	<b>47.8</b>
7	38.1	43.9	41.0	15.2	17.9	16.6	27.2	31.7	29.4
8	90.6	92.8	91.7	74.3	78.4	76.4	83.3	86.3	84.8
9	96.4	97.2	96.8	87.5	90.2	88.8	92.5	94.2	93.3
10-14	94.0	96.7	95.4	72.9	83.4	78.1	84.8	91.0	87.9
15-19	56.9	69.8	63.5	19.2	30.2	24.4	40.4	54.3	47.3
20-24	20.9	30.8	26.0	1.5	1.9	1.7	12.3	19.0	15.6
25-29	6.6	10.0	8.3	0.7	0.7	0.7	4.0	6.2	5.1

хүний 57 хувь сургуульд суралцаж байхад хөдөөд амьдарч байгаа ийм насны хүмүүсийн 36 хувь сургуульд суралцаж байна. Хот, хөдөөгөөр ялгаатай байдал 15, түүнээс дээш насны хүмүүсийн хувьд хамгийн их байгаа нь хөдөөд мэргэжлийн сургууль цөөн, нөгөө талаас бүрэн бус дунд сургууль төгсөгчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллахаар олноороо гарч байгаатай холбоотой. Хөдөөнөөс олон хүүхэд хот руу шилжиж сургуульд үргэлжлүүлэн суралцдаг тул хот, хөдөөгийн хувьд ийм их ялгаа гарах бас нэг нөхцөл юм.

Бүх насны бүлэгт, өөрөөр хэлбэл 7-29 насанд сургуульд суралцаж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс долоон пүнктээр илүү байгаа нь эмэгтэйчүүд суралцагсдын дотор давамгайлж байгааг харуулж байна. Эмэгтэйчүүдийн энэ давуутай тал хот, хөдөөд аль алинд нь харагдаж байна. Нас ахих тутам буюу боловсролын түвшин дээшлэх тутам эмэгтэйчүүдийн давамгай тал мөн өссөөр байгаа нь анхаарал татаж байна. Сургуульд суралцаж байгаа эсэхийг насны бүлэг, байршил, хүйсээр **Хавсралт 1-ийн Хүснэгт 13-т**, аймаг, нийслэл, хүйсээр **Хавсралт 1-ийн Хүснэгт 14-т** харуулав.

Энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол зөвхөн сургуульд орохдоо төдийгүй мөн сургуульд орсныхоо дараа ч бүх шатны сургуульд сургуулиас завсардахгүй, сургуулиа үргэлжлүүлэхдээ давуутай байгааг харуулж байна.

#### Зураг 6.4. Сургуульд суралцагч 100 эрэгтэйд ногдох эмэгтэйчүүд, насны бүлгээр, 2000 он




Сургуульд суралцаж байгаа 100 эрэгтэйд ногдох эмэгтэйчүүдийн харьцааг тооцож **Зураг 6.4-т** харуулав. Хүйсийн харьцаа 100-тай тэнцүү байхад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд адил хэмжээгээр сургуульд суралцаж байна гэсэн үг. 20-24, 25-29 насны бүлэгт хүйсийн харьцаа хурдан өсч, 150 болж байгаа нь бүрэн дундаас дээш түвшинд суралцагсдын хүйсийн ялгаа ихсэж байгааг харуулж байна. Ийнхүү эрэгтэйчүүд боловсролын хувьд харьцангуй тааруу байгаа шалтгааныг тооллогын материалаас гаргаж авах боломжгүй бөгөөд үүний тулд илүү нарийн судалгаа хийх шаардлагатай.

## Бүлэг 7. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИ

Эдийн засгийн идэвхийн талаархи мэдээллийг тооллогоос гаргаж авах нь нилээд төвөгтэй юм. Ажил эрхлэлтийн түүвэр судалгаагаар олон асуулт асууж, мэдээллийг дэлгэрэнгүй гаргах боломжтой байхад тооллогоор ажил эрхлэлтийн талаар цөөн асуулт асууж, мэдээлэл авахыг зорьдог. 2000 оны тооллогоор зөвхөн таван асуултаар эдийн засгийн идэвхи, ажил эрхлэлтийн мэдээллийг цуглуулсан.


**Зураг 7.1-д** 2000 оны тооллогод ашигласан эдийн засгийн идэвхийн талаархи ойлголт, тодорхойлолт, цуглуулсан мэдээллийг зураглан харуулав.

### Зураг 7.1. Эдийн засгийн идэвхийн ойлголт, 2000 он



Өөр нэг хүндрэлтэй асуудал бол төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа энэ үед эдийн засгийн талаархи мэдээллийн хэрэгцээ шаардлага цаг хугацааны аясаар өөрчлөгдж байна. Энэ нь 1989, 2000 оны тооллогод хэрэглэсэн аргачлалын ялгаатай байдал, өнгөрсөн арван жилийн хугацаанд явагдсан өөрчлөлтийг судлахад хэрэглэгчид ямар хүндрэлтэй учирч болохыг нягтлан үзэхэд мэдэгдэх болно. Тооллогоор эдийн засгийн идэвхийг гаргахын тулд богино хугацаанд, долоо хоногт хамааралтай *тухайн үеийн идэвхи* гэсэн аргыг хэрэглэсэн. Тухайн хүн тооллогын товын өмнөх долоо хоногт нэг цаг ажилласан байсан ч ажил хийсэн гэж үзсэн тул тухайн үеийн арга нь ажил эрхлэлтийг илүү тодорхой болгож байгаа юм. Тооллогоор асуусан ажил эрхлэлтийн талаархи асуултын бүдүүвчийг **Зураг 7.2-т** үзүүлэв.

### Зураг 7.2. Ажил эрхлэлтийн ойлголт, 2000 он



Харин 1989 онд хэрэглэсэн арга наад зах нь хоёр гол зүйлээр ялгаатай байсан. Эхнийх нь 1989 оны тооллогоор асуусан эдийн засгийн идэвхийн талаархи асуулт тодорхой бус ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн амыг үнэн зөв тодорхойлоход учир дутагдалтай байсан. Хоёрдугаарт 1989 оны тооллогод байнгын идэвхийн арга дээр үндэслэсэн ойлголтыг хэрэглэсэн. Байнгын идэвхийн арга нь жилийн ихэнхи хугацаанд ажил эрхэлсэн байдлыг харуулдаг. Монгол Улсын хувьд хамарагдах хугацаа нь өнгөрсөн нэг жил байсан. Энэ талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн **Бүлэг 1**, Тооллого зохион явуулсан тухай тайлангийн **Бүлэг 3**-аас харна уу.


Ийнхүү сүүлийн 2 тооллогод хоёр өөр арга хэрэглэсэн тул энэхүү тайланд хоёр тооллогын эдийн засгийн идэвхийн мэдээллийг харьцуулахыг зорьсонгүй.

### Эдийн засгийн идэвхийн байдал

Арван тав, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхийн байдлыг хэд хэдэн аргаар ангилж болно. Хамгийн түгээмэл нь ажиллах хүч (зарим тохиолдолд эдийн засгийн идэвхитэй хүн амтай тохирдог), эдийн засгийн идэвхигүй хүн ам хоёрыг тооцож гаргах юм. Ажиллах хүчинд ажил эрхэлж байгаа хүн ам болон ажилгүйчүүдийг оруулдаг учраас эдийн засгийн бодлого боловсруулагч нарт чухал байдаг. Энэ нь тухайн үед ажиллаж байгаа болон ажил эрхлэхэд бэлэн хүмүүсийн тоог тодорхойлдог. 2000 оны тооллогоор 15, түүнээс дээш насны хүн амын 62 хувь нь ажиллах хүчинд багтаж байна. Энэ хувийг ихэнхи тохиолдолд ажиллах хүчиний оролцооны түвшин гэж нэрлэдэг. Үлдсэн 38 хувь нь ажиллах хүчнээс гаднах үйл ажиллагаа эрхэлдэг байна.

#### Зураг 7.3. Арван тав, түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчиний оролцооны түвшин, хувиар, 2000 он

Нийт хүн амын ойролцоогоор 62 хувь нь ажиллах хүчинд хамрагдаж байгааг өмнө тэмдэглэсэн. Гэхдээ ажиллах хүчиний оролцооны түвшин нас, хүйс, байршил зэргээр өөр өөр байна. **Хүснэгт 7.1**-ээс харахад эрэгтэйчүүдийн 69 хувь ажиллах хүчинд багтаж байгаа нь эмэгтэйчүүдийнхээс (56%) өндөр байна. Энэ ялгаатай байдал хот, хөдөөд хоёуланд нь байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алиных нь ажиллах хүчиний оролцоо хөдөөд хотынхоос өндөр байв. Хөдөөд, ялангуяа эрэгтэйчүүдийн 80 гаруй хувь нь сүүлийн долоо хоногт ажил эрхэлсэн эсвэл ажил хайж байна гэж хариулсан байна.



Хүснэгт 7.1. Ажиллах хүчний оролцооны түвшин, байршил, хүйсээр, 2000 он										
Эдийн засгийн идэвхийн байдал	Хот			Хөдөө			Бүгд			
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ажиллах хүчний оролцооны түвшин	60.2	47.9	53.8	80.1	66.9	73.6	68.6	55.5	61.9	
Эдийн засгийн идэвхигүй хүн амын эзлэх хувь	39.8	52.1	46.2	19.9	33.1	26.4	31.4	45.5	38.1	

Ажил эрхлэлтэд бусад зүйлээс гадна нас бас нөлөө үзүүлсэн. **Хүснэгт 7.2-**т ажиллах хүчний оролцоог хүйс, насны бүлгээр харуулав. Ажиллах хүчнийг насны бүлгээр авч үзэхэд мэдэгдэхүйц ялгаатай байна. 15-24 насны эмэгтэйчүүдийн талаас бага хувь нь ажиллах хүчинд багтаж байхад эрэгтэйчүүдийн 60 гаруй хувь нь хамрагдаж байна. Бүх хүн амын ажиллах хүчний оролцоо 25-54 насанд хамгийн өндөр, эрэгтэйчүүдийн хувьд насны бүх бүлэгт өндөр байна. Энэхүү эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо өндөр байгаа нь 55, түүнээс дээш насанд ч илүү мэдэгдэхүйц байна. Энэ нь эмэгтэйчүүд (55 нас) эрэгтэйчүүдийг бодвол эрт тэтгэвэрт гардагтай зарим талаар холбоотой. Энэ насны бүлгийн 98 мянган эмэгтэйчүүдээс 12 мянга хүрэхгүй нь сүүлийн долоо хоногт ажил эрхэлсэн, эсвэл ажил хайж байгаа гэж хариулжээ. Хэдийгээр энэ насны бүлгийн нийт эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийнхээс цөөн байсан ч 26.7 мянган эрэгтэй ажил эрхэлсэн, эсвэл ажил хайж байгаа гэж хариулсан байна.


Хүснэгт 7.2. Эдийн засгийн идэвхи, насны бүлэг, хүйс, дунд эзлэх хувиар, 2000 он															
Насны бүлэг	Ажиллах хүч						Эдийн засгийн идэвхигүй хүн ам						Бүгд		
	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд				
	мян.хүн	хувь	мян.хүн	хувь	мян.хүн	хувь	мян.хүн	хувь	мян.хүн	хувь	мян.хүн	мян.хүн			
Бүгд	514.2	68.6	429.9	55.5	944.1	61.9	235.7	31.4	344.6	44.5	580.3	38.1	749.9	774.5	1524.4
15-19	63.9	48.0	44.7	34.4	108.6	41.2	69.4	52.0	85.4	65.6	154.7	58.8	133.3	130.0	263.4
20-24	88.0	74.5	71.6	60.8	159.6	67.7	30.1	25.5	46.1	39.2	76.2	32.3	118.0	117.7	235.8
25-34	162.4	81.0	146.9	72.0	309.3	76.5	38.0	19.0	57.2	28.0	95.2	23.5	200.4	204.1	404.5
35-44	120.5	81.7	116.2	76.3	236.7	78.9	27.0	18.3	36.2	23.7	63.2	21.1	147.5	152.4	299.8
45-54	52.7	77.1	38.6	53.3	91.3	64.9	15.6	22.9	33.8	46.7	49.4	35.1	68.3	72.5	140.7
55-59	17.0	62.0	6.4	22.3	23.3	41.8	10.4	38.0	22.2	77.7	32.6	58.2	27.4	28.5	55.9
60 +	9.7	17.7	5.6	8.0	15.3	12.3	45.3	82.3	63.7	92.0	109.0	87.7	55.0	69.3	124.3

Эдийн засгийн идэвхийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт 1-ийн Хүснэгт 15, 16-аас харна уу. Хүснэгт 15-д** эдийн засгийн идэвхийг насны бүлэг, хүйс, байршилаар, **Хүснэгт 16-д** аймаг, нийслэлээр харуулав.

### Ажиллах хүч


Ажиллах хүчний ойлголт бол тухайн хамааралтай үед ажил хийж байсан, мөн ажил хайж байсан ажилгүй хүмүүсийг хамруулсан нилээд төвөгтэй ойлголтуудын нэг юм. Тухайн хамааралтай долоо хоногт ажил хийгээгүй хүмүүсээс ажил хийгээгүй шалтгааныг асуусан. Ажил идэвхитэй хайж байсан гэж хариулсан хүмүүсийг ажилгүйчүүд гэж ангилсан. **Зураг 7.4-д** тооллогын ажиллах хүчний талаархи асуултыг харуулав.

#### Зураг 7.4. Ажиллах хүчний асуулт, 2000 он



Урд өмнө дурдсанаар тооллогын товын өмнөх долоо хоногт ажил хийсэн гэж хариулсан хүмүүсийг ажил эрхэлдэг хүн амд оруулав. Гэхдээ тооллого нэгдүгээр сарын эхээр явагдсан учраас өвлүүн улиралд түр хугацаагаар ажлаа хийгээгүй ч ажилтай гэж хэлсэн хүмүүс олон байгаа. Тиймээс хэрэв тухайн хүн ямар нэгэн шалтгаанаар тооллогын өмнөх долоо хоногт ажил эрхлээгүй байвал түүний ажил эрхлэлтийг үнэн зөв тодорхойлохын тулд ер нь ажилтай эсэх, ажилдаа буцаж орох эсэхийг тодруулж асуусан. Өвчтэй, амралттай, улирлын ажилтай зэрэг шалтгааны улмаас түр хугацаагаар ажил хийгээгүй хүмүүсийг тухайн хамааралтай хугацаанд ажил эрхэлсэнтэй адил авч үзсэн. Энэ нь тухайн хүн ажил идэвхитэй хайж байснаас голлон үндэслэж ажилгүйдлийг тодорхойлох аргатай тохирч байгаа юм. Ажилдаа эргэн орох хүмүүс бол ажил хайж байгаа хүмүүс биш юм.

#### Зураг 7.5. Эдийн засгийн идэвхийн байдал, 2000 он




Ажиллах хүчний нийт 62 хувиас 51 хувь нь тооллогын товын өмнөх долоо хоногт ажил эрхэлсэн байхад үлдсэн 11 хувь нь ажилгүйчүүд байна. Гэхдээ эдгээр хувь нь 15, түүнээс дээш насны бүх хүн амд харьцуулсан үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, үлдсэн 10.8 хувь нь 15, түүнээс дээш насны нийт хүн амд ажилгүй байгаа хүн амын эзлэх хувь тул үүнийг ажиллах хүчнийг үндэслэн тооцдог ажилгүйдлийн түвшинтэй адил мэт ойлгож болохгүй юм.

Ажиллах хүчний насны дүр төрх бусад улс орныхтой төстэй байна (**Зураг 7.6**). Янз бүрийн шалтгааны улмаас 15-19 насны залуучууд нэлээд, 20-24 насны залуучуудын зарим хэсэг нь ажиллах хүчинд хамрагдахгүй байна. Өндөр насны хувьд нас ахих тутам хүмүүсийн хөдөлмөрийн чадвар буурч байгаа

бөгөөд 60, түүнээс дээш насын хүн амын дөнгөж 12 хувь ажиллах хүчинд хамрагдаж байна (**Хүснэгт 7.2**).

### Зураг 7.6. Ажиллах хүчний оролцооны түвшин, насын бүлэг, хүйсээр, 2000 он



### Ажил эрхэлдэг хүн ам

Ажил эрхэлж байгаа хүмүүст тооллогын товын өмнөх долоо хоногт ажил эрхэлсэн бүх хүмүүс мөн өвчтэй, ээлжийн амралттай, улирлын ажилтай зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд түр ажил эрхлээгүй хүмүүс орсон. Бүх ажил эрхэлдэг хүмүүсээс тэдний ажил эрхлэлтийн талаар гурван асуултыг асуусан. Энд эрхэлдэг ажил, үйл ажиллагааны үндсэн чиглэл, ажил эрхлэлтийн байдал орно.

2000 оны тооллогоор 15, түүнээс дээш насын хүн амын 51 хувь ажил эрхэлж байна (**Хүснэгт 7.3**). Гэхдээ энэ дундаж хувь нь зарим ялгаатай байдлыг, ялангуяа хот, хөдөөгийн хоорондын ялгааг далдалж байгаа юм. Хөдөөд 15, түүнээс дээш насын хүн амын 66 хувь ажил эрхэлж байхад хотод 40 хувиас ялигүй илүү нь ажил эрхэлж байна. Харин хөдөөд (сумын төв ороогүй) энэ үзүүлэлт 78 хувь хүртэл өсч байна. Хөдөөд амьдарч байгаа хүн амын ажил эрхлэлт ийнхүү өндөр байгаа нь гол төлөв мал аж ахуйн салбарт олноороо ажил эрхлэж байгаатай холбоотой нь тодорхой. Хөдөө амьдарч байгаа хүн амын хувьд хотынхоной харьцуулахад сургуульд суралцсан, мал аж ахуйгаас өөр тохиromжтой ажил хайх, тодорхой насанд тэтгэвэрт гарах боломж, шаардлага бага юм.

### Хүснэгт 7.3. Арван тав, түүнээс дээш насын ажил эрхэлдэг хүн ам, хүйс, байршилаар, 2000 он

Хүйс	Хот		Хөдөө		Бүгд	
	мян.хүн	хувь*	мян.хүн	хувь*	мян.хүн	хувь*
<b>Бүгд</b>	<b>366.0</b>	<b>40.7</b>	<b>413.1</b>	<b>66.1</b>	<b>779.1</b>	<b>51.1</b>
Эрэгтэй	193.0	44.5	227.4	72.0	420.4	56.1
Эмэгтэй	173.0	37.2	185.7	60.1	358.7	46.3

\*15, түүнээс дээш насын хүн амд ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь

Хүйсийн ялгаатай байдал байршлынхтай адил их биш хэдий ч ялгаа байгаа нь харагдаж байна. Хот, хөдөөгийн аль алинд ажил эрхэлж байгаа эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс өндөр, хот, хөдөөгийн дүнгээр 10 хувийн ялгаатай байна.

**Хүснэгт 7.4. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, насны бүлэг, хүйсээр, 2000 он**

Насны бүлэг	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	мян.хүн	эзлэх хувь	мян.хүн	эзлэх хувь	мян.хүн	эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>420.4</b>	<b>100.0</b>	<b>358.7</b>	<b>100.0</b>	<b>779.1</b>	<b>100.0</b>
15-19	48.4	11.5	32.5	9.1	80.9	10.4
20-24	69.1	16.4	57.0	15.9	126.0	16.2
25-34	131.0	31.2	121.3	33.8	252.3	32.4
35-44	99.9	23.8	99.8	27.8	199.6	25.6
45-54	46.5	11.1	36.3	10.1	82.8	10.6
55-59	16.0	3.8	6.3	1.8	22.3	2.9
60+	9.7	2.3	5.5	1.5	15.2	2.0

**Хүснэгт 7.4**-т үзүүлсэн ажил эрхэлдэг хүн амын насны бүтэц ажиллах хүчнийхтэй адил байна. 55 нас хүртэл эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт бараг адил байгаа бөгөөд ажил эрхэлдэг хүн амын гуравны нэгийг 25-34 насны хүмүүс бүрдүүлж байгаа нь хамгийн өндөр байна. 55, түүнээс дээш насны ажиллагсдын тоо ерөнхийдөө буурсан ч ажил эрхэлж байгаа эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс бараг хоёр дахин илүү байна

Ажил эрхэлдэг бүх хүмүүсийн хийж байгаа гол ажлыг Монгол Улсын ажил мэргэжлийн ангилалын кодоор кодлосон. Энэ ангиллын дагуу гаргасан үр дүнг хүйсээр **Хүснэгт 7.5**-д харуулав

**Хүснэгт 7.5. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, эрхэлдэг ажил, хүйсээр, 2000 он**

Ажил мэргэжил	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	мян.хүн	эзлэх хувь	мян.хүн	эзлэх хувь	мян.хүн	эзлэх хувь
<b>Ажил эрхэлдэг хүн ам</b>	<b>420.4</b>	<b>100.0</b>	<b>358.7</b>	<b>100.0</b>	<b>779.1</b>	<b>100.0</b>
Хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын албан тушаалын ажилтан, менежер	26.9	6.4	11.6	3.3	38.5	5.0
Мэргэжилтэн	26.0	6.2	49.0	13.7	75.0	9.6
Инженер техникийн ажилтан	12.1	2.9	23.5	6.6	35.6	4.6
Туслах ажилтан	4.3	1.0	12.3	3.4	16.6	2.1
Үйлчилгээний ажилтан ба дэлгүүр зах зээл дээр худалдаа эрхлэгч	24.7	5.9	44.5	12.4	69.2	8.9
Хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилчин	198.8	47.3	161.2	44.9	360.0	46.2
Үйлдвэрийн ба худалдааны ажилчин	39.7	9.4	24.8	6.9	64.5	8.3
Машин тоног төхөөрөмжийн операторч, угсрагч	47.4	11.3	4.4	1.2	51.8	6.6
Энгийн ажил мэргэжил, бусад ажиллагсад	40.5	9.6	27.4	7.6	67.9	8.7

Эмэгтэйчүүд боловсролын түвшингийн хувьд давамгайлж байгаа мөртлөө улс төрийн дээд түвшин дэх тэдний төлөөлөл бага байгааг харж болно. Жишээлбэл, хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын албан тушаалын ажилтан, менежер нарын 30 хувь нь эмэгтэйчүүд байна. Харин мэргэжилтэн, инженер, техникийн ажилтнуудын дийлэнхи нь эмэгтэйчүүд байна. Эмэгтэй ажиллагсдын 14 хувь мэргэжилтэн байхад эрэгтэй ажиллагсдын хувь дөнгөж 6 хувь байна. Үүнтэй төстэй төрхийг инженер техникийн ажилтнуудаас харж болно. Эдгээр ажил эрхэлдэг эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс бараг хоёр дахин илүү байна.

Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад бичиг хэргийн болон үйлчилгээний ажлыг илүү эрхэлж байна. Эрэгтэйчүүд зарим уламжлалт ажил эрхлэх талаар давамгайлсан хэвээр байна. Хөдөө аж ахуйн ажил эрхэлдэг эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс бараг 38 мянгаар олон байна. Машин тоног төхөөрөмжийн операторч, угсралгын эрэгтэйчүүдийн дунд хамгийн өндөр хувийг эзэлж байгаа юм. Нийт ажил эрхэлдэг эрэгтэйчүүдийн 11,3 хувь нь энэ бүлэгт багтдаг ажил эрхэлж байхад эмэгтэйчүүдийн 1,2 хувь нь эрхэлж байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алинд нь хөдөө аж ахуйн ажилгын хувийг эзэлж байна. Хөдөөд нийт ажиллагсдын бараг 84 хувь нь хөдөө аж ахуйн ажил эрхэлж байна (**Хавсралт 1-ийн Хүснэгт 17-г** харна уу).

Нийт ажил эрхэлдэг хүн амыг тэдний ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлээр ангилсан. Улсын хэмжээнд нийт ажиллагсдын 47 хувь нь хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт ажил эрхэлдэг нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Нийт ажиллагсдын бараг 20 хувь нь эрүүл мэнд, боловсрол, төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагааны салбарт ажиллаж байна.

**Хүснэгт 7.6. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хүйсээр, 2000 он**

Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	
	мян.хүн	мян.хүн	мян.хүн	Дүнд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>420.4</b>	<b>358.7</b>	<b>779.1</b>	<b>100.0</b>
1 Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй <sup>1</sup>	204.9	162.8	367.7	47.1
2 Уул уурхай, олборлох үйлдвэр	14.1	4.7	18.8	2.5
3 Боловсруулах үйлдвэр	25.7	30.9	56.6	7.3
4 Барилга	10.2	3.5	13.7	1.8
5 Цахилгаан, хий үйлдвэрлэл, ус хангамж	12.0	3.9	15.9	2.1
6 Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагаа	33.3	35.2	68.5	8.8
7 Зочид буудал, зоогийн газар	3.2	7.9	11.1	1.4
8 Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	30.3	11.8	42.1	5.4
9 Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	1.8	2.7	4.5	0.6
10 Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	5.5	4.7	10.2	1.3
11 Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	43.1	16.5	59.6	7.6
12 Боловсрол	14.8	36.7	51.5	6.6
13 Эрүүл мэнд, нийгмийн хalamж	6.1	24.5	30.6	3.9
14 Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	9.9	8.0	17.9	2.3
15 Бусад <sup>2</sup>	5.5	4.9	10.4	1.3

<sup>1</sup>загас барилт ороод


<sup>2</sup>хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй, олон улсын байгууллага, гадаадад ажиллаж байгаа, үйл ажиллагааны чиглэл нь тодорхой бус хүмүүс орсон.

Ажиллагсдын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хүйсээр авч үзэхэд сонирхолтой үр дүн гарчээ. Боловсрол, эрүүл мэнд болон зочид буудал, зоогийн газар, санхүүгийн үйл ажиллагаа зэрэг салбарт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс харьцангуй олон байгаагийн дотор эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс боловсрол, эрүүл мэндийн салбарт 40.3 мянягаар, зочид буудал, зоогийн газар, санхүүгийн салбарт 5.6 мянягаар их байна. Мөн үндэсний бүтээгдэхүүнд голлох хувь нэмэр оруулдаг боловсруулах үйлдвэр, худалдааны салбарт илүү олон эмэгтэйчүүд ажиллаж байна.

Харин хөдөө аж ахуй, уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс олноороо ажиллаж байна. Тэд барилга, зам тээвэр зэрэг салбарт ч давамгайлсан хэвээр байгаа юм. Үйлчилгээний салбаруудаас төрийн удирдлага, батлан хамгаалахын салбарт эмэгтэйчүүдийг бодвол бүр илүү олон эрэгтэйчүүд ажиллаж байна.

Тооллого хот, хөдөөгийн ялгааг тод гаргаж өгөв. **Зураг 7.7-оос** хараад хөдөө аж ахуйн салбар хөдөөд, боловсруулах үйлдвэр, барилга, эрүүл мэнд, боловсролын салбарууд хотод давамгайлж байна. **Хавсралт 1-ийн Хүснэгт 18-ыг** харна уу.

### **Зураг 7.7. Ажиллагсдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн бүлгээр, хот, хөдөөгөөр, мян.хүн, 2000 он**



Тайлбар: Бүлгийн дугаарыг **Хүснэгт 7.6-аас** харна уу.

Ажил эрхэлж байгаа хүмүүсээс тэдний ажил эрхлэлтийн байдлыг, өөрөөр хэлбэл тэд өөрсдөдөө эсвэл өөр хүнд ажиллаж байсныг асуусан. Асуултын хариултын бүлгийг **Хүснэгт 7.7-д** үзүүлэв. Ажил эрхлэлтийн байдал хүйсээр мэдэгдэхүйц ялгаатай байв. Эрэгтэйчүүдийн хувьд хамгийн том бүлэгт хувиараа ажил эрхлэгчид, үүний дараа гэрээгээр ажиллагч орж, гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч харьцангуй бага хувийг эзэлж гуравдугаарт орж байна. Эмэгтэйчүүдийн хувьд хамгийн том бүлэг бол гэрээгээр ажиллагч

### **Хүснэгт 7.7. Ажил эрхэлдэг хүн амын ажил эрхлэлтийн байдал, хүйсээр, мян.хүн, 2000 он,**

Хүйс	Ажил эрхлэлтийн байдал					
	Гэрээгээр ажил олгогч	Ажил ажиллагч	Хувиараа ажиллагч	Гэр бүлийн бизнес цалин авалгүй оролцогч	Бусад	Бүгд
Бүгд	321.4	10.0	243.2	197.5	7.0	779.1
Эрэгтэй	165.1	7.2	184.5	59.0	4.6	420.4
Эмэгтэй	156.3	2.8	58.7	138.5	2.4	358.7

бөгөөд энэ нь хувиараа ажил эрхэлдэг эмэгтэйчүүдээс 2.5 дахин олон байгаа нь эрэгтэйчүүдтэй адилгүй байна. Дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт 1-ийн Хүснэгт 19-өөс** харна уу.

Сонирхол татсан бас нэг асуудал бол харьцангуй олон хүмүүс өөрсдийгөө гэр бүлийн бизнест цалин хөлсгүй ажилладаг гэж тодорхойлсон байна. Өөр нэг сонирхол татах зүйл бол олон эмэгтэйчүүд (бараг 140 мянга) өөрсдийгөө гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч гэжээ. Эдгээр эмэгтэйчүүд гэр бүлийн бизнес, мал аж ахуйд цалин хөлс авалгүй ажилладаг байна. Үүнээс гадна эрэгтэйчүүдийн хувьд ажил олгогчид давамгайлж байгааг хараад эмэгтэйчүүд бизнесийн үйл ажиллагааг тэр болгон зохион байгуулж ажиллуулдаггүйг гэрчилж байгаа юм. Цалин хөлсгүй ажилладаг нийт хүмүүсийн бараг 15 мянга нь хотод өрхийн үйлдвэрлэлд ажиллаж байна. Харин хөдөөд 180 мянга гаруй хүмүүс хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байна.

Ажил эрхэлдэг хүн амын боловсролын түвшинг аймаг, нийслэлээр **Хавсралт 1-ийн Хүснэгт 20-д** харуулав.

### Ажилгүйчүүд

Тооллогоос ажилгүйдлийг тооцож авах нь эдийн засгийн бодлого боловсруулагчдад асар их ач холбогдолтой юм. Төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа улс орны хувьд бүтцийн ажилгүйдэл хаана байгааг ойлгож, ажлын байр бий болгох хөтөлбөр ажил хийх сонирхолтой нийцэж байх нь эдийн засгийн өсөлтийг урамшуулах гол хөшүүрэг билээ. 2000 оны тооллогод хэрэглэсэн ажилгүйдлийн ойлголт нь Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НҮБ-ын бусад байгууллагын зөвлөмжийг үндэслэсэн юм. Тооллогын товын өмнөх долоо хоногт ажил эрхлээгүй бөгөөд ажил хайж байгаа гэж хариулсан хүмүүсийг ажилгүйчүүдийн тоонд оруулж, судалгааны энэ хэсэгт ашигласан болно.

Гэхдээ ажилгүйчүүд, эдийн засгийн идэвхигүй гэсэн хоёр тодорхойлолтын ялгаа үргэлж тодорхой байдаггүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Хөдөлмөрийн зах бол үргэлж тогтвортой байдаггүй, тухайлбал тооллогын үед ажиллах хүчиний гадна байгаа олон хүмүүс тохиромжтой ажил олдвол түүнийг дуртайяа хийж болох талтай. Эдгээрээс хамгийн анхаарал татах хэсэг нь тухайн хугацаанд ажил хийгээгүй, мөн ажил идэвхитэй хайгаагүйн дээр ажил эрхлээгүй шалтгаанаа тохирох ажил олдохгүй байгаа гэж хариулсан хүмүүс юм. Нэгдсэн Үндэсний Байгууллагаас гаргасан зөвлөмжид дараах тайлбарыг оруулсан байдаг.<sup>1</sup>

*...Хөдөлмөрийн зах зээл зохион байгуулалтгүй, хязгаарлагдмал хүрээтэй, хөдөлмөрийн багтаамж хангалтгүй, ажиллах хүчиний нилээд хэсэг хувиараа хөдөлмөр эрхэлдэг нөхцөлд зөвхөн ажил хайж байгаа хүнээр ажилгүйчүүдийг тооцох уламжлалт арга нь хязгаарлагдмал бөгөөд ийм тохиолдолд ажилгүйдлийн стандарт тодорхойлолтын ажил хайж байгаа гэсэн шалгуурыг зөөлрүүлж ... хоёр үндсэн шалгуурыг “ажилгүй”, “одоогоор ажил хийхэд бэлэн” гэж авч үздэг.*

Тооллогоор асуусан ажилгүйчүүдийн талаархи асуултыг **Зураг 7.8-д** үзүүлэв.

<sup>1</sup>Хүн ам, орон сууцны тооллогын зарчим, зөвлөмж, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Эдийн засаг, нийгмийн хэлтэс, Нью-Йорк, 1998

### Зураг 7.8. Ажилгүйчүүдийн талаархи асуулт, 2000 он

Та сүүлийн 7 хоногт ажил өрхэлсэн үү?

Тийм

Үгүй

Та яагаад ажил өрхлэхгүй байна бэ?

Ажил хайж  
байгаа

Тохирох ажил  
олдохгүй  
байгаа

- Сургуульд сурдаг
- Тэтгэвэр нөхөн олговорт
- Өвчтэй, тахир дутуу
- Гэрийн ажилтай
- Бусал

Ажилгүйчүүдэд зургийн зүүн талын “ажил хайж байгаа” гэсэн бүлгийг оруулав. Харин бодлого боловсруулагчид зарим зорилгын үүднээс энэ зурагт дугуйлагдсан “тохирох ажил олдохгүй байгаа” гэж хариулсан хүмүүсийг ажилгүйчүүдэд оруулдаг учир тусгайд нь авч үзэх шаардлагатай.

Уламжлалт тодорхойлолтоор тооцсон ажилгүйдлийн түвшин, тодруулбал ажил хайж байгаа ажилгүйчүүд ажиллах хүчиний 17.5 хувийг эзэлж байв. **Хүснэгт 7.8-**д үзүүлснээр ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийн хувьд 18.2 хувь, эмэгтэйчүүдийн хувьд 16.6 хувь байгаа нь хүйсээр тийм их ялгаатай биш байна. Харин байршилаар их ялгаатай байна. Ажилгүйдлийн дундаж түвшин хотод 24.3 хувь, харин хөдөөд 10.2 хувь байна. Энэ нь хөдөөд нүүдлийн мал аж ахуй зонхилж, ажилгүйдлийн ойлголтыг харьцангуй бага хэрэглэж байгаатай холбоотой нь тодорхой. Хотод ажилгүйдлийн түвшин өндөр, хүн амын цэвэр өсөлт, хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнөөс шалтгаалан хөдөлмөрийн зах зээл үргэлж өсч байгаа нь төлөвлөгчдийн хувьд чухал бодлогын чанартай асуудлыг хөндөн гаргаж байна. Хөдөлмөрийн хамгийн идэвхитэй нас болох 24-54 насанд ажилгүйдлийн түвшин 16.1 хувь, энэ нь эрэгтэйчүүдийн хувьд 17.4, эмэгтэйчүүдийн хувьд 14.7 хувь байна (**Хавсралт 1-ийн Хүснэгт 15-г харна уу**).

#### Хүснэгт 7.8. Ажилгүйчүүд, хүйс, байршилаар, 2000 он

Хүйс	Хот		Хөдөө		Бүгд	
	мян.хүн	ажилгүйдлийн түвшин	мян.хүн	ажилгүйдлийн түвшин	мян.хүн	ажилгүйдлийн түвшин
Бүгд	117.8	24.3	47.1	10.2	164.9	17.5
Эрэгтэй	67.9	26.0	25.8	10.2	93.7	18.2
Эмэгтэй	49.9	22.4	21.3	10.3	71.2	16.6

**Хүснэгт 7.9**—өөс харахад ажилгүйдлийн түвшин насын бүлгээр ялгаатай байгаа боловч ихэнхи насын бүлэгт хүйсийн ялгаа бага байна. 35 хүртэлх насанд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин ойролцоо байна. Харин 35, түүнээс дээш насанд эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. 55, түүнээс дээш насанд эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс бараг тав дахин их байна. Энэ нь эмэгтэйчүүд (55 нас) эрэгтэйчүүдээс (60 нас) эрт тэтгэвэрт гардагтай холбоотой


**Хүснэгт 7.9. Ажилгүйдлийн түвшин, насын бүлэг, байршил, хүйсээр, 2000 он**

Насны бүлэг	Хот		Хөдөө		Бүгд				
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бүгд	26.0	22.4	24.3	10.2	10.3	10.2	18.2	16.6	17.5
15-19	47.1	51.0	48.7	12.5	15.3	13.7	24.4	27.2	25.5
20-24	33.5	31.8	32.8	11.0	11.4	11.2	21.5	20.4	21.0
25-34	27.3	22.9	25.2	10.5	10.8	10.6	19.4	17.4	18.4
35-44	21.3	17.0	19.1	11.2	9.7	10.5	17.1	14.1	15.7
45-54	15.3	8.1	12.2	7.0	3.1	5.3	11.7	6.0	9.3
55-59	9.6	2.1	7.9	2.5	0.3	1.8	5.8	0.9	4.5
60+	1.4	1.8	1.5	0.1	0.3	0.2	0.6	0.6	0.6

юм. Гэхдээ энэ насанд ажилгүйдлийн түвшин ерөнхийдөө өндөр биш, ажилгүйчүүдийн тоо залуучуудынхтай харьцуулахад хамаагүй доогуур байна.

Залуу насын бүлэгт ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь **Зураг 7.9**-өөс харагдаж байна. 15-19 насын бүлэгт ажилгүйдлийн түвшин 25 хувиас илүү байснаа дараагийн насын бүлгүүдэд буурч, 60, түүнээс дээш насанд (эрэгтэйчүүд тэтгэвэрт гарах нас) ажилгүйдэл тун бага байна. **Хүснэгт 7.9**-өөс харахад ажилгүйдэл хотод хөдөөнөөс өндөр, ялангуяа залуучуудын дунд илүү өндөр байна. Ажилгүйчүүдийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт 1**-ийн **Хүснэгт 21**-ээс харна уу.

**Зураг 7.9. Ажилгүйдлийн түвшин, насын бүлэг, хүйсээр, хувиар, 2000 он**



## Эдийн засгийн идэвхигүй хүн ам

Тухайн хугацаанд ажил эрхлээгүй 15, түүнээс дээш насны хүн амаас ажил хийгээгүй шалтгааныг асуусныг **Зураг 7.6-д** үзүүлсэн юм. Ажиллах хүчний гадна байгаа эдийн засгийн идэвхигүй хүн амд олон улсын стандарт тодорхойлолтын дагуу доорхи хүмүүсийг оруулав:

- *Тохирох ажил олдохгүй байгаа–эдийн засгийн идэвхигүй, гэхдээ боломжит ажиллах хүчинд оруулж болно*
- *Сургуульд суралцдаг*
- *Тэтгэвэр, нөхөн олговорт*
- *Өвчтэй, тахир дутуугийн группт<sup>1</sup>*
- *Гэрийн ажилтай*
- *Бусад*

Эдийн засгийн идэвхигүй хүн ам нийтдээ 580.3 мянга байв. Эрэгтэйчүүдтэй харьцуулахад харьцаангуй олон эмэгтэйчүүд ажил хийгээгүй шалтгаанаа сургуульд суралцаж байгаа гэж хариулжээ. Энэ нь дараагийн хэдэн жилд эрэгтэйчүүдээс олон эмэгтэйчүүд мэргэжлийн сургуулиа дүүргэнэ гэдгийг харуулж байна (**Бүлэг 6-г** харна уу). Өндөр насны бүлгийн тэтгэвэр, нөхөн олговорт байгаа хүн амын тоо тухайн насны бүлгийн нийт хүн амын тоотой бараг ижил байв. Тэтгэвэр, нөхөн олговорт гэж хариулсан эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс хоёр

**Хүснэгт 7.10. Арван тав, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхигүй хүн ам, ажил эрхлээгүй шалтгаан, хүйсээр, 2000 он**

Ажил эрхлээгүй шалтгаан	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	мян.хүн	эзлэх хувь	мян.хүн	эзлэх хувь	мян.хүн	эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>235.7</b>	<b>100.0</b>	<b>344.6</b>	<b>100.0</b>	<b>580.3</b>	<b>100.0</b>
Тохирох ажил олдохгүй байгаа	53.1	22.6	37.3	10.8	90.4	15.6
Сургуульд сурдаг	71.4	30.2	99.6	28.9	171.0	29.4
Тэтгэвэр, нөхөн олговорт	53.9	22.9	109.8	31.9	163.7	28.2
Өвчтэй, тахир дутуугийн группт <sup>1</sup>	20.5	8.7	16.4	4.7	36.9	6.4
Гэрийн ажилтай	10.9	4.6	65.4	19.0	76.3	13.2
Бусад	25.9	11.0	16.1	4.7	42.0	7.2

дахин өндөр байгаа нь хуулийн дагуу эмэгтэйчүүд (55 нас) эрэгтэйчүүдийг (60 нас) бодвол тэтгэвэрт эрт гардаг болон эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс өндөр байгаатай холбоотой юм.

<sup>1</sup>Өвчтэй, тахир дутуугийн группт гэж хариулсан хүн амын талаар илүү гүнзгийрүүлсэн судалгаа хийх хэрэгтэй. 20 мянга гаруй эрэгтэйчүүд, 16 мянга гаруй эмэгтэйчүүд өвчтэй, тахир дутуугийн улмаас ажил эрхлээгүй гэж хариулжээ. Гэхдээ тооллогоор бух тахир дутуу хүмүүсийг тодорхойлох боломжгүй юм. Ажиллах хүчний талаархи асуултыг зөвхөн 15, түүнээс дээш насны хүмүүсээс асуусан. Иймээс 15-аас доош насны тахир дутуу хүмүүс энд хамрагдаагүй болно. Үүнээс гадна энэ тоо зөвхөн өвчтэй, тахир дутуугийн улмаас ажил эрхлээгүй хүн амаар хязгаарлагдаж байгаа юм. Ажил эрхэлж, эсвэл ажил хайж байгаа болон суралцаж байгаа олон тооны тахир дутуу хүмүүс энд ороогүй юм. Эдгээрийн аль нь ч дээрх хүснэгтэд харагдахгүй юм.

Олон эмэгтэйчүүд ажил эрхлээгүй шалтгаанаа гэрийн ажилтай гэж хариулсан нь эмэгтэйчүүдийн гэрийн бүлийн үүрэг, уламжлалт ёс заншилтай холбоотой юм. Харин 11 мянга орчим эрэгтэйчүүд ажил эрхлээгүй шалтгаанаа гэрийн ажилтай гэж хариулсныг тэмдэглэх хэрэгтэй. Мөн өвчтэй, тахир дутуугийн группт болон бусад гэсэн шалтгаанаар ажил эрхлээгүй гэж хариулсан эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийнхээс илүү байна.

**Хүснэгт 7.11-д** эдийн засгийн идэвхигүй хүн амыг насны бүлгээр үзүүлэв.

Хүснэгт 7.11. Арван тав, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхигүй хүн ам, насны бүлэг, ажил эрхлээгүй шалтгаанаар, мян.хүн, 2000 он							
Насны бүлэг	Эдийн засгийн идэвхигүй хүн ам						
	Тохирох ажил олдохгүй байгаа	Сургуульд сурдаг	Тэтгэвэр, нөхөн олговорт	Өвчтэй, тахир дутуу	Гэрийн ажилтай	Бусад	Бүгд
Бүгд	90.4	171.0	163.7	36.9	76.3	42.0	580.3
15-19	13.8	123.1	-	2.5	8.1	7.2	154.7
20-24	15.9	35.1	-	3.7	14.4	7.2	76.2
25-34	30.7	11.8	-	8.7	29.8	14.3	95.2
35-44	22.2	1.0	2.6	11.0	17.3	9.1	63.2
45-54	6.5	0.1	27.3	7.1	5.4	3.0	49.4
55-59	1.2	-	27.1	2.4	1.0	0.9	32.5
60+	0.1	-	106.7	1.5	0.4	0.4	109.0

Эдийн засгийн идэвхигүй хүн амын 26.7 хувь нь буюу 154.7 хүн 15-19 насны бүлэгт, 18.8 хувь нь буюу 109.0 мянган хүн 60, түүнээс дээш насны бүлэгт байна. 171.0 мянган хүн суралцаж байгаагийн ихэнхи нь залуучууд байна.

Хүснэгт 7.12. Тохирох ажил олдохгүй байгаагийн улмаас ажил эрхлээгүй хүн ам, насны бүлэг, хүйсээр, мян.хүн, 2000 он			
Насны бүлэг	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бүгд	53.1	37.3	90.4
15-24	16.8	12.8	29.7
25-34	17.6	13.1	30.7
35-44	12.8	9.4	22.2
45-54	4.7	1.8	6.5
55+	1.2	0.1	1.3

Эцэст нь ажилгүйчүүдийг хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдалтай холбож тодорхойлох хүндрэлтэй асуудал руу эргэж орох хэрэгтэй. Дээр тайлбарласан ажил хайж байгаа хүн амаас гадна 90 гаруй мянган хүн тохирох ажил олдохгүй байгаагийн улмаас ажил эрхлээгүй гэж хариулсан байна.

**Хүснэгт 7.12** дахь насны бүтэц уламжлалт аргаар тооцсон ажилгүйчүүдийн насны бүтэцтэй адил байна. Тохирох ажил олдохгүй байгаа гэж хариулсан хүмүүсийг итгэл алдarsan ажилчид (ойлголт, тодорхойлолтыг энэ тайлангийн Бүлэг 1, Тооллого зохион явуулсан тухай тайлангийн **Бүлэг 3**-аас харна уу) гэж нэрлэдэг ба эдгээрийн 65 гаруй хувийг 35-аас доош насныхан эзэлж байна.

Ажиллах хүчний бодлогын зарим зорилгоор уламжлалт аргаар тооцсон ажилгүйчүүд дээр итгэл алдарсан ажилчдыг нэмж ажилгүйчүүдийг тодорхойлдог.


Энэхүү ажиллах хүчнийг тооцох өргөжүүлсэн арга нь ажлын боломжит эрэлтийг гаргадаг тул зарим тохиолдолд хэрэгцээтэй байж болох юм. Энэ аргаар тооцоход ажилгүйдлийн түвшин ажиллах хүчний 25 хувьд хүрч байна.

Хүснэгт 7.13. Ажиллах хүч, өргөжүүлсэн ойлголгоор, мян.хүн, 2000 он	
Эдийн засгийн идэвхийн байдал	Хүн ам
<b>Ажиллах хүч</b>	<b>1034.4</b>
Ажил эрхэлдэг	779.1
Ажил хайж байгаа	164.9
Тохирох ажил олдохгүй байгаа	90.4

## Бүлэг 8. ӨРХ, ОРОН СУУЦ, ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Өмнөх тооллогуудын нэг адил 2000 оны тооллогод өрх, орон сууц нэг бүрийн талаархи бүлэг асуултыг асуусан. Тооллогод хамрагдсан хүн амын ихэнхи нь ганц биеэрээ, эсвэл хэсэг бүлгээрээ хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангаж өрх үүсгэн амьдарч, аль нэг өрхөд тоологджээ. Ихэнхи өрх уламжлалт хэлбэр болох гэр бүлээрээ, түүнчлэн зочид, найз нөхөдтэйгээ, хамт амьдарч байв. Харин өрхөд тоологдоогүй цэрэг, хоригдол болон эмнэлэгт хэвтэж байгаа өвчтөн, оюутан сурагчдын нийтийн байранд амьдарч байсан хүмүүсийг нийтийн байранд тоологдсон хүн амд оруулсан юм.

Зураг 8.1. Өрх, нийтийн байранд тоологдсон хүн ам, 2000 он



Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын үр дүнгээс харахад нийт хүн амын 98.5 хувь нь 541.1 мянган өрхөд тоологдсон байна. Үлдсэн 1.5 хувь буюу 35.9 мянган хүн нийтийн байранд тоологджээ. Тайллангийн энэ хэсэгт зөвхөн өрх, өрхөд тоологдсон хүн амын талаар авч үзэх болно. Гэхдээ нийтийн байранд тоологдсон хүн амын талаар удахгүй хэвлэгдэн гарах орон сууцны сэдэвчилсэн судалгаагаар судлах болно.

Хүснэгт 8.1. Өрхийн тоо, байршил, 1989 болон 2000 он


Байршил	1989		2000		$\frac{2000}{1989}$ %
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	
Бүгд	427.8	100.0	541.1	100.0	126.5
Хот	235.6	55.1	296.4	54.8	125.8
Хөдөө	192.2	44.9	244.7	45.2	127.3

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор нийт 541.1 мянган өрх тоологдсон нь 1989 оныхоос 26.5 хувиар өсчээ. 1989-2000 онд хотын өрх 25.8 хувь, хөдөөгийн өрх 27.3 хувиар өссөн байна.

## Өрхийн хэлбэр

Өрхийн хэлбэр буюу өрхөд тоологсон хүн ам, өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтайгаар нь өрхийг ангилан харуулах нь нийгэм, хүн ам зүй, эдийн засгийн судалгаанд болон бодлого боловсруулагчдад нэлээд сонирхолтой үзүүлэлт болдог. Өрхийн дөрвөн хэлбэрийн тодорхойлолтыг Бүлэг 1-ээс харна уу. Өрхийн хэлбэрийг өрхийн гишүүдийн өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай гэсэн асуултад хариулсан байдлаар ангилж **Зураг 8.2-д** харуулав.

### Зураг 8.2. Өрхийн хэлбэр, 2000 он



Нийт өрхийн 6.5 хувь нь ганц бие, 62.9 хувь нь ам бүлээрээ байгаа өрх, 27.8 хувь нь нийлмэл ам бүлтэй өрх, 2.7 хувь нь холимог ам бүлтэй өрх байна. Нийт өрхийн дотор ам бүлээрээ буюу эхнэр, нөхөр, хүүхдийнхээ хамт амьдарч байгаа өрх дийлэнх хувийг эзэлж байна. Мөн нийлмэл ам бүлтэй, өөрөөр хэлбэл эцэг, эх, ах, дүүс, садан төрлөөрөө сууж байгаа өрх ч олон байна. Энэ нь өрхийн ам бүлийн бүтцийн түгээмэл хэлбэрүүд бөгөөд үр хүүхэд, хамаатан садантайгаа хамт амьдрах нь манай уламжлалт заншилтай уялдаатай гэж үзэж болно.

### Хүснэгт 8.2. Өрхийн тоо, байршил, өрхийн хэлбэрээр, 2000 он

Байршил	Ганц бие өрх		Ам бүлээрээ байгаа өрх		Нийлмэл өрх		Холимог өрх		Бүгд
	Дүнд мян.өрх	Эзлэх хувь	Дүнд мян.өрх	Эзлэх хувь	Дүнд мян.өрх	Эзлэх хувь	Дүнд мян.өрх	Эзлэх хувь	
Бүгд	35.4	6.5	340.6	62.9	150.4	27.8	14.7	2.7	541.1
Хот	16.4	5.5	167.7	56.6	101.4	34.2	10.9	3.7	296.4
Хөдөө	19.0	7.8	172.9	70.6	49.0	20.0	3.8	1.6	244.7

Өрхийн бүтцийг хот, хөдөөгөөр авч үзвэл ялгаатай байдал нэлээд их байна. Нийлмэл ам бүлтэй өрхийн тоо хотод (101.4 мянга) хөдөөнөөс (49,0 мянга) 2 дахин их байгаа нь төв суурин газарт орон сууцны хүрэлцээ хангамжтай холбоотой байж болох талтай.

**Хүснэгт 8.3-т** өрхийн ам бүлийн тоо байршилаар ялгаатай байгааг харуулж байна. 3-4 ам бүлтэй өрхийн эзлэх хувь хот, хөдөөд бараг адил байна. Ам бүл цөөнтэй (1-2 ам бүлтэй) өрхийн эзлэх хувь хөдөөд хотоос 4,5 пүнктээр илүү байна. Харин ам бүл олонтой (5-6, 7, түүнээс олон ам бүлтэй) өрхийн эзлэх хувь хотод хөдөөгөөс илүү байна. Энэ нь хотод нийлмэл болон холимог өрх хөдөөгөөс олон тоотой байсантай тохирч байна (Хүснэгт 8.2) Өрхийн ам бүлийн талаархи бусад мэдээллийг Хавсралт 1-ийн Хүснэгт 22-оос харна уу.

Хүснэгт 8.3. Өрхийн тоо, дунд эзлэх хувь, байршил, ам бүлийн тоогоор, 2000 он												
Байршил	1-2		3-4		5-6		7+		Бүгд			
	мян. өрх	Дунд эзлэх хувь	мян. өрх	Дунд эзлэх хувь	мян. өрх	Дунд эзлэх хувь	мян. өрх	Дунд эзлэх хувь	мян. өрх	Дунд эзлэх хувь	мян. өрх	Дунд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>92.8</b>	<b>17.2</b>	<b>220.8</b>	<b>40.8</b>	<b>161.3</b>	<b>29.8</b>	<b>66.2</b>	<b>12.2</b>	<b>541.1</b>	<b>100.0</b>		
Хот	44.8	15.1	121.2	40.9	91.1	30.7	39.3	13.3	296.4	<b>100.0</b>		
Хөдөө	48.0	19.6	99.6	40.7	70.2	28.7	26.9	11.0	244.7	<b>100.0</b>		

Өрхийг ам бүлийн тоогоор ангилбал 3-4 хүнтэй өрх 40.8 хувь, 5-6 хүнтэй өрх 29.8 хувийг эзэлж байна. Энэ нь аймгаар бага зэргийн ялгаатай байна. Тухайлбал, улсын хэмжээгээр нийт өрхийн 58 орчим хувийг 1-4 хүнтэй өрх эзэлж байхад Ховд аймгийн нийт өрхийн 48.1 хувь нь, Баян-Өлгий аймгийн нийт өрхийн 49.3 хувь нь 1-4 хүнтэй өрх байна. Харин Өмнөговь (67.3 хувь), Булган (65.2 хувь), Орхон (63.5 хувь) аймгуудад нийт өрхийн дийлэнхи хувийг цөөн хүнтэй буюу 1-4 хүнтэй өрх эзэлж байна. Улсын түвшинд 7, түүнээс дээш хүнтэй өрх нийт өрхийн 12.2 хувийг эзэлж байхад Баян-Өлгий, Ховд аймгуудад 18.1, 17.8 хувийг тус тус эзэлж байна. **Хавсралт 1-ийн Хүснэгт 23-ыг** харна уу.

Аймаг, нийслэл	Ам бүлийн тоогоор					Өрхийн ам бүлийн дундаж тоо
	1-2	3-4	5-6	7+	Бүгд	
<b>Бүгд</b>	<b>17.2</b>	<b>40.8</b>	<b>29.8</b>	<b>12.2</b>	<b>100.0</b>	<b>4.3</b>
Архангай	22.5	40.7	28.5	8.3	100.0	4.0
Баян-Өлгий	13.4	35.9	32.7	18.0	100.0	4.7
Баянхонгор	21.5	39.2	28.4	10.9	100.0	4.1
Булган	19.2	46.0	27.3	7.5	100.0	4.0
Говь-Алтай	17.2	41.0	30.5	11.3	100.0	4.3
Дорнговь	20.8	42.2	27.6	9.4	100.0	4.0
Дорнод	18.9	38.6	29.6	12.9	100.0	4.3
Дундговь	19.0	41.6	29.1	10.3	100.0	4.2
Завхан	18.3	42.2	30.1	9.4	100.0	4.1
Өвөрхангай	19.3	41.6	29.8	9.3	100.0	4.1
Өмнөговь	23.2	44.1	25.5	7.2	100.0	3.9
Сүхбаатар	17.2	39.8	29.9	13.1	100.0	4.3
Сэлэнгэ	15.8	42.8	29.8	11.6	100.0	4.3
Төв	19.6	42.8	28.3	9.3	100.0	4.1
Увс	16.4	38.2	32.7	12.7	100.0	4.4
Ховд	13.1	35.0	34.1	17.8	100.0	4.7
Хөвсгөл	19.0	42.9	28.4	9.7	100.0	4.1
Хэнтий	20.5	42.8	27.6	9.1	100.0	4.0
Дархан-Уул	16.3	44.6	29.1	10.0	100.0	4.2
Улаанбаатар	14.1	39.5	30.7	15.7	100.0	4.6
Орхон	17.6	45.9	28.1	8.4	100.0	4.1
Говьсүмбэр	21.1	41.1	28.2	9.6	100.0	4.0

Улсын хэмжээнд өрхийн ам бүлийн дундаж тоо 4.3 байна. Баян-Өлгий (4.7), Ховд (4.7), Увс (4.4) аймаг, Улаанбаатар (4.6) хотод ам бүлийн дундаж тоо улсын дунджаас дээгүүр байна. Эдгээр нь өрхийн зохион байгуулалт, орон сууцны хүрэлцээ, хангамж муу, төрөлтийн түвшин зэргийг харуулж байна.

Хүснэгт 8.5. Өрхийн тоо, өрхийн тэргүүлэгчийн хүйс, байршил, дунд эзлэх хувиар, 2000 он						
Өрх	Хот		Хөдөө		Бүгд	
	мян.өрх	Дунд эзлэх хувь	мян.өрх	Дунд эзлэх хувь	мян.өрх	Дунд эзлэх хувь
Бүгд	296.4	100.0	244.7	100.0	541.1	100.0
Эрэгтэй тэргүүлэгчтэй	242.3	81.7	210.4	86.0	452.7	83.7
Эмэгтэй тэргүүлэгчтэй	54.1	18.3	34.3	14.0	88.4	16.3


**Хүснэгт 8.5**-д үзүүлсний дагуу нийт өрхийн 16.3 хувийг эмэгтэй тэргүүлэгчтэй, үлдсэн 83.7 хувийг эрэгтэй тэргүүлэгчтэй өрх эзэлж байна. Энэ төрх байдал байршилаар ялгаатай байна. Хотод эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь хөдөөгийнхөөс 4.3 пунктээр илүү байна.

### Орон сууц

2000 оны тооллого өрхийн бүтэц болон орон сууцны нөхцлийн талаар хязгаарлагдмал мэдээлэл цуглуулсан юм. Байшин болон уламжлалт орон сууц болох гэрийн талаар өөр өөр төрлийн мэдээлэл цуглуулах шаардлагатай гэж үзсэн тул байшин болон гэрийг тус тусад нь авч үзсэн. Өрх нэг бүрийг эхлээд гэрт эсвэл байшинд (сууцны тусдаа байшин, нийтийн сууцны байшин доторхи сууц, нийтийн байр) амьдарч байгаа гэж ангиlj, тусгай асуултуудыг асуусан.

Орон сууц нь хүн амын аж байдлыг тодорхойлдог тул орон сууцны үзүүлэлтийг хувь хүний боловсрол, эдийн засгийн идэвхийн талаархи асуудалтай хамт дараагийн шатанд судлах нь зүйтэй. Харин энэ тайландаа дан ганц орон сууцны тооллогын талаар бичигдсэн болно.

### Зураг 8.3. Өрхийн орон сууцны төрөл, 2000 он



Хоёр болон түүнээс олон орон сууцтай өрхийн хувьд тооллогын үед амьдарч байсан үндсэн орон сууцны талаархи мэдээллийг цуглуулсан.

Хүснэгт 8.6. Өрх, сууцны төрөл, байршилаар, 2000 он						
Сууцны төрөл	Хот		Хөдөө		Бүгд	
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>296.4</b>	<b>100.0</b>	<b>244.7</b>	<b>100.0</b>	<b>541.1</b>	<b>100.0</b>
Гэр	84.0	28.3	191.6	78.3	275.6	50.9
Байшин	212.4	71.7	53.1	21.7	265.5	49.1

**Хүснэгт 8.6**-аас харахад тооллогын үед нийт өрхийн 49 хувь нь байшинд, 51 хувь нь гэрт амьдарч байна. Хот, хөдөөгийн хооронд нилээд их ялгаатай байна. Хотод нийт өрхийн бараг 72 хувь нь байшинд, 28 хувь нь гэрт амьдарч, хөдөөд гэр зонхилж байна. Хөдөөгийн өрхийн 78 хувиас илүү нь гэрт амьдарч үндэсний уламжлалт амьдралын шинж чанарыг тусгаж байна.

Тооллогын зорилгын дагуу байшинд амьдарч байгаа өрхийг сууцны зориулалтаар ангилсан. Нийт өрхийн бараг 47 хувь тусдаа байшинд эсвэл нийтийн сууцны байшин доторх сууцанд амьдарч байна. Нийт өрхийн 1.6 хувь нь нийтийн байр, 0.6 хувь нь сууцны бус, 0.2 хувь нь бусад сууцанд амьдарч байна. Тооллогоор орон гэргүй хүмүүсийг бусад сууцанд амьдарч байгаа гэж үзсэн болно (Бүлэг 1-д тодорхойлолт өгөгдсөн). Өрхийг сууцны зориулалт, аймаг, нийслэлээр Хавсралт 1-ийн **Хүснэгт 24**-т, орон гэргүй хүмүүсийн талаархи мэдээлийг Хавсралт 1-ийн **Хүснэгт 25**-д харуулав.

Хүснэгт 8.7. Өрх, сууцны зориулалтгаар, 2000 он		
Сууцны зориулалт	Өрх	
	мян.өрх	Дүнд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>541.1</b>	<b>100.0</b>
Гэр	275.6	50.9
<b>Байшин</b>	<b>265.5</b>	<b>49.1</b>
Сууцны тусдаа байшин	133.9	24.7
Нийтийн сууцны байшин доторх сууц	119.0	22.0
Нийтийн байр <sup>1</sup>	8.4	1.6
Сууцны бус	3.4	0.6
Бусад	0.8	0.2

<sup>1</sup>оюутан, сурагчдын нийтийн байр, ажиллагчдын нийтийн байр, нийтийн бусад байр

**Хүснэгт 8.8**-д өрхийг сууцны зориулалт, байршилаар харуулав. Хот, хөдөөгийн хооронд нилээд их ялгаатай байна. Урд өмнө ажиглагдаж байсны нэгэн адил

хөдөөгийн өрхийн гэрт амьдрах нь хотын өрхийнхөөс хамаагүй илүү байна. Сумын төвийг оруулахгүйгээр хөдөөг авч үзвэл үүнээс ч илүү ялгаатай байдал ажиглагдав. Хөдөөгийн (сумын төв ороогүй) дөнгөж 10.1 хувь нь байшинд, 89.9 хувь нь гэрт амьдарч байна. Сумын төвд өрхийн дийлэнхи нь гэрт амьдарч байгаа ч хөдөөгийнх шиг биш нийт өрхийн 56.7 хувь нь гэрт амьдарч байна. Аймгийн төвийн өрхийн 37.5 хувь, Улаанбаатарын нийт өрхийн 21.8 хувь гэрт амьдарч байна.

Сууцны зориулалт	Байршил						Бүгд
	Хөдөө <sup>2</sup>	Сумын төв	Тосгон	Аймгийн төв	Улаанбаатар		
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Гэр	89.9	56.7	26.1	37.5	21.8	50.9	
Байшин	10.1	43.3	73.9	62.5	78.2	49.1	
Сууцны тусдаа байшин	8.9	35.0	39.3	29.5	29.9	24.7	
Нийтийн сууцны байшин доторх сууц	0.6	5.9	30.2	30.2	44.8	22.0	
Нийтийн байр <sup>1</sup>	0.4	1.4	3.1	1.7	2.5	1.6	
Сууцны бус	0.1	0.9	1.2	0.9	0.8	0.6	
Бусад	0.1	0.1	0.1	0.2	0.2	0.1	

<sup>1</sup>оюутан, сурагчдын нийтийн байр, ажиллагчдын нийтийн байр, нийтийн бусад байр

<sup>2</sup>сумын төв ороогүй

Хотод орон сууцны төрөл ялгаатай байгаа ч хөдөөгийнхтэй адил тийм их ялгаатай биш байна. Аймгийн төвийн өрхийн бараг 63 хувь байшинд амьдарч байна. Байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь тосгонд нийт өрхийн 74 хувь, Улаанбаатар хотод 78 хувь болж өсч байна.

Сууцны зориулалтаас зарим сонирхолтой дүр зураг ажиглагдаж байна. Хөдөөгийн байшинд амьдарч байгаа өрхийн дийлэнхи нь сууцны тусдаа байшинд, гэхдээ сумын төвийн өрхийн 14 хувь нийтийн сууцны байшин доторх сууцанд амьдарч байна. Хотод ялгаатай байдал илүү их байна. Тосгонд байшинд амьдарч байгаа нийт өрхийн талаас илүү хувь нь сууцны тусдаа байшинд амьдарч байна. Аймгийн төвд энэ нь 47 хувьд хүрэхгүй, нийтийн сууцны байшин доторх сууцанд амьдарч байгаа өрхийн эзлэх хувиас ялигүй бага байна. Улаанбаатар хотод газрын төлбөр, хотын төвөөс холдох зайд зэргээс шалтгаалан байдал эсрэг байна. Нийслэл хотын нийт өрхийн бараг 45 хувь нь нийтийн сууцны байшин доторх сууцанд амьдарч байна.

## Орон сууцны өмчлөл, өмчийн хэлбэр

**Хүснэгт 8.9**-д байшин, гэрт амьдардаг өрхийн орон сууцыг улсын, хувийн, холимог гэж ангилж өмчлөлийн хэлбэрээр харуулав (**Бүлэг 1**-д тодорхойлолт өгөгдсөн).

**Хүснэгт 8.9. Өрх, сууцны төрөл, өмчийн хэлбэрээр, 2000 он**

Сууц төрөл	Улсын		Хувийн		Холимог		Бүгд	
	Мян.өрх	Дүнд эзлэх хувь						
Бүгд	44.9	8.3	491.0	90.7	5.2	1.0	541.1	100.0
Гэр	0.9	0.3	274.3	99.5	0.4	0.2	275.6	100.0
Байшин	44.0	16.6	216.7	81.6	4.8	1.8	265.5	100.0

Нийт өрхийн 91 хувь нь хувийн өмчийн сууцанд, арав хүрэхгүй хувь нь улсын болон холимог өмчийн сууцанд амьдарч байна. Гэрт амьдарч байгаа бараг бүх өрх хувийн өмчийн гэрт амьдарч байгаа нь гайхах зүйл биш юм. Хувийн өмчийн байшигийн эзлэх хувь тийм өндөр биш, нийт байшинд амьдардаг өрхийн 82 хувь хувийн өмчийн, 2 орчим хувь нь холимог өмчийн сууцанд амьдарч байна.

**Хүснэгт 8.10. Өрх, сууцны өмчлөлийн хэлбэр, байршилаар, 2000 он**

Өмчлөлийн хэлбэр	Хот		Хөдөө		Бүгд	
	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	Мян.өрх	Дүнд эзлэх хувь
Бүгд	296.4	100.0	244.7	100.0	541.1	100.0
Улсын	37.2	12.5	7.7	3.1	44.9	8.3
Хувийн	254.6	85.9	236.4	96.6	491.0	90.7
Холимог	4.6	1.6	0.6	0.3	5.2	1.0

**Хүснэгт 8.10**-д орон сууцны өмчлөлийг хот, хөдөөгөөр харуулав. Хөдөөд нийт өрхийн 97 хувь хувийн өмчийн сууцанд амьдарч байгаа нь хөдөөд хувийн гэрт амьдардаг өрхийн эзлэх хувийн жин өндөр байгаагаас шалтгаалж байна. Хотын өрхийн 86 хувь хувийн өмчийн сууцанд амьдарч байгаа нь бүх төрлийн орон сууцны дийлэнхийг хувьчилсныг харуулж байна.

## Өрхийн цахилгаан болон телефон утасны хангамж

Өрхийн цахилгаан болон телефон утасны хангамжийн хот, хөдөөгийн ялгааг **Хүснэгт 8.11**-д харууллаа. Монгол Улсын нийт өрхийн 67 хувь, хотын өрхийн 95 хувь, хөдөөгийн өрхийн 34 хувь цахилгаан хэрэглэдэг байна. Телефон утастай өрхийн тоо харьцангуй бага, тэгээд ч хот, хөдөөгийн ялгаа их байна. Монгол Улсын нийт өрхийн 17 хувь, хотын өрхийн 29 орчим хувь, харин хөдөөгийн өрхийн дөнгөж 2 хувь телефон утастай байна.

**Хүснэгт 8.11. Өрхийн цахилгаан болон телефон утасны хангамж, байршилаар, 2000 он**

	Хот		Хөдөө		Бүгд	
	мян.өрх	эзлэх хувь	мян.өрх	эзлэх хувь	мян.өрх	эзлэх хувь
Цахилгаан эрчим хүчээр хангагдсан	280.4	94.6	83.6	34.1	364.0	67.3
Телефон утастай	87.0	29.3	5.2	2.1	92.2	17.0

## Гэрт амьдардаг өрх

Гэр нь монголчуудын уламжлалт орон сууц бөгөөд, одоо ч Монгол Улсын нийт өрхийн 50.9 хувь нь амьдарч байгаа юм. Энэ удаагийн тооллогоор гэрт амьдардаг өрхөөс гэрийн ахуйн нөхцлийн өвөрмөц онцлогийг харгалзан байшингийхаас тусдаа өөр асуултыг асуув.

Гэрт амьдардаг өрхийн дийлэнхи нь зургаагаас цөөн ханатай гэрт амьдардаг (Ханын тодорхойлолтыг **Бүлэг 1**-ээс харна уу).

**Хүснэгт 8.12. Гэрт суудаг өрх, ам бүлийн тоо, гэрийн ханын тоогоор, 2000 он**


Ам бүлийн тоо	Ханын тоо								Бүгд			
	5-аас цөөн		5		6		6-аас дээш					
	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь				
Бүгд	56.7	20.6	158.4	57.5	51.7	18.7	8.8	3.2	275.6	100.0		
1-2	19.5	35.6	27.1	49.4	7.3	13.3	0.9	1.7	54.8	100.0		
3-4	22.5	20.2	64.2	57.8	21.0	18.9	3.4	3.1	111.1	100.0		
5-6	11.2	14.2	48.0	61.0	16.4	20.8	3.1	4.0	78.7	100.0		
7+	3.5	11.5	19.1	61.5	7.0	22.6	1.4	4.4	31.0	100.0		

Хамгийн түгээмэл нь таван ханатай гэр бөгөөд гэрт амьдардаг өрхийн 57.5 хувь 5 ханатай гэрт амьдарч байна. Гурван хувиас ялигүй илүү нь зургаагаас дээш ханатай гэрт амьдарч байна. 1-2 хүнтэй өрхийн 35 хувиас илүү нь таваас цөөн ханатай гэрт, харин хоёр хүрэхгүй хувь нь долоо, түүнээс дээш

ханатай гэрт амьдарч байна. Ерөнхийдөө ам бүлийн тоо өсөх тутам таваас цөөн ханатай гэрт амьдардаг өрхийн тоо буурч, том гэрт амьдардаг өрхийн тоо өсч байна. Долоо, түүнээс олон хүнтэй, өөрөөр хэлбэл олон ам бүлтэй өрхийн 11.5 хувь таваас цөөн ханатай гэрт амьдарч байна. Эдгээр өрхийн 4 хувиас илүү нь зургаагаас дээш тооны ханатай гэрт амьдарч байгаа нь цөөн ам бүлтэй өрхийнхтэй харьцуулахад харьцангуй өндөр байна.

Гэрт амьдарч байгаа өрхөөс гэрийн нөхцлийн талаар хэд хэдэн асуулт асуусан. Эрүүл мэндийн асуудлаар төлөвлөгөө боловсруулагчдад ундны усны эх үүсвэрийн талаархи асуудал хамгийн чухал юм. Гэрт амьдарч байгаа бүх өрхийн 48 хувь нь ундны усаа гүний болон уурхайн худгаас авдаг нь ундны усны найдвартай эх үүсвэртэйг харуулав. Гэрт амьдардаг өрхийн 42 хувь нь ундны усаа гол, мөрөн, булаг, шанд, нуур, цөөрмөөс, 10 хувь нь бусад (цас, бороо гэх мэт) эх үүсвэрээс авдаг байна.

#### Зураг 8.4. Гэрт амьдардаг өрх, усан хангамжаар, 2000 он



Гэрт амьдардаг хотын өрхийн ихэнхи нь бие засах газартай байна. Нийт гэрт амьдардаг өрхийн 77 хувь нь тусдаа бие засах газартай байхад, гэрт амьдардаг хотын өрхийн 93 хувь, хөдөөгийн өрхийн 70 хувь тусдаа бие засах газартай байна.

#### Хүснэгт 8.13. Гэрт амьдарч байгаа өрхийн эзлэх хувь, ахуйн нөхцлийн үзүүлэлт, байршилаар, 2000 он

Ахуйн нөхцөл	Хот	Хөдөө	Бүгд
